



**СОЁЛЫН ЯАМ**



**Тайлангийн дугаар: 220020**

# НҮҮДЛИЙН СОЁЛ ДАХЬ ХАРИЛЦААНЫ СОЁЛЫН СУДАЛГАА

**сэдэвт тойм судалгааны ажлын тайлан**

(Present day Norms and Customs of Interpersonal Communication in the Mongolian  
Nomadic Culture)

**Progressive report**

Захиалагч: Соёлын яам

Гүйцэтгэгч: ЮНЕСКО-ийн ивээл дор НСИСОУХ

Улаанбаатар

2022

*Энэхүү судалгааны тайланг Монгол Улсын Соёлын Яамны захиалгаар хийж буй ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн Соёл Иргэнийг Судлах Олон Улсын Хүрээлэнгийн “МОНГОЛ НҮҮДЭЛЧДИЙН ХАРИЛЦААНЫ ОНЦЛОГ, ХЭМ ХЭМЖЭЭ, ЁС ЗАНШИЛ” сэдэвт тойм судалгааны ажлын хүрээнд хийж гүйцэтгэв.*

Хянасан: Ч.Мөнхтуул (Доктор, НСИСОУХ)

Судалгааны багийн ахлагч: Б.Төгсбуян (НСИСОУХ)

Судалгааны багийн гишүүд: М.Пагмадулам (НСИСОУХ),

Улаанбаатар хот

2022 он

## ХҮСНЭГТ ЗУРГИЙН ЖАГСААЛТ

### Хүснэгт:

Хүснэгт 1. Жан Пенрозын “Төрсөн нутаг”-т багтах агуулга ба Д.Бум-Очирын тайлбар.

### Зураг:

- Зураг 1. Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Баянгол багийн Чоно төрдөг гэх савдагтай (эзэнтэй) ууланд малчин Мөнхбаатар унасан мөчир, гишүү, унаанга түүж буй нь. 2022 оны 6 дугаар сар.
- Зураг 2. Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Азарга багийн малчин Бямбасүрэн түлшээ бэлдэж буй нь. 2022 оны 6 дугаар сар.
- Зураг 3. Архангай аймгийн Ихтамир сумын Хан-Өндөр багт амьдардаг Сүрэнхорлоогийн эцэг, эхдээ зориулан босгосон гэр бүлийн, тахилгагүй овоо. 2022 оны 6 дугаар сар.
- Зураг 4. АПУ ХХК-ийн Дээж сүү, сүүн бүтээгдэхүүн.
- Зураг 5. Тооноороо сацал огт өргөдөггүйг тод санаарай та минь... С. Цогтбаяр.
- Зураг 6. Архангай аймгийн Ихтамир сумын Хан-Өндөр багт байдаг морины овоо. 2022 оны 6 дугаар сар, хээрийн судалгааны тэмдэглэлээс.
- Зураг 7. Зураг 6-д байгаа морины овоон дээр тавьсан хонины мөртэй чулуу. 2022 оны 6 дугаар, хээрийн судалгааны тэмдэглэлээс.
- Зураг 8. “Ардын хувьсгалын 31 жил”, 1952 он. Зураач: Тодорхойгүй. “Үнэн” сониноос эрхлэн гаргадаг “Матар” сэтгүүлийн 1952 оны 7 дугаар сарын дугаар №7.
- Зураг 9. Архангай аймгийн Ихтамир сумын Хан-Өндөр багийн Хан-Өндөр хайрханы тахилгын үеэр. 2022 оны 6 дугаар сарын 8, хээрийн судалгааны тэмдэглэлээс.
- Зураг 10. Хан-Өндөр хайрхныг тахисны 3 хоногийн дараа хур, тунадас орж бэлчээрийн гарц сайжрав. 2022 оны 6-р сарын 12, хээрийн судалгааны тэмдэглэлээс.
- Зураг 11. Stora-гийн ачааг саравчлан харж хүлээе! Сайн яваад ирэх болтугай. С.Цогбаяр, 2022 он.
- Зураг 12. Нус нь өтгөн, цус нь шингэн байг ээ! (Орчин үеийн ерөөлийн үг). С.Цогбаяр, 2022 он.
- Зураг 13. Хонх хамтлаг, 1989 он.

- Зураг 14. “Нөхөрлөл” Ү. Ядамсүрэн, 1967 он.
- Зураг 15. Архангай аймагт замд төөрсөн тул нутгийн малчинтай уулзаж буй замчин. Хээрийн судалгааны тэмдэглэлээс.
- Зураг 16. “Малчны гэрт” Б. Чогсом, 1981 он.
- Зураг 17. Ө. Баярбатын 2022 оны Цагаан сарын баярын ширээ. 2022 оны цагаан сарын шинийн нэгний өдөр.
- Зураг 18. Архангай аймгийн Ихтамир, Өндөр-Улаан сумдад хийсэн хээрийн судалгааны үеэр малчдын айлчин, гийчдэд зориулж тавьсан тавгийн идээ. 2022 оны 8 дугаар сар.
- Зураг 19. Архангай аймгийн Ихтамир, Өндөр-Улаан сумдад хийсэн хээрийн судалгааны үеэр малчдын айлчин, гийчдэд зориулж тавьсан тавгийн идээ. 2022 оны 6 дугаар сар.
- Зураг 20. 2022 оны 2 дугаар сард гар утсанд маань “Мөр гаргах” гэх дугаараас ирсэн мессеж
- Зураг 21. 2022 онд МБШТ Гандантэгчинлэн хийдийн цахим хуудаснаас онлайнаар уншуулсан номын талаар ирсэн мессеж
- Зураг 22. Өөрийн фейсбүүкээс скрийншот хийж авсан зураг, 2022 оны 10 дугаар сар.

## **ГАРЧИГ**

### **УДИРТГАЛ**

#### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ХҮН-БАЙГАЛЬ ХООРОНДЫН ХАРИЛЦАА**

1.1 “Газрын эзэн” ба хүн хоорондын харилцаа

1.2 Идээний дээж “сүү”

1.3 Хүн-малын харилцаа

1.4 Газрын эзэнтэй холбогч “овоо”

1.5 Нутаг

1.6 Бүлгийн дүгнэлт

#### **ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХҮН-ХҮН ХООРОНДЫН ХАРИЛЦАА**

2.1 Монгол хүн бэлгээрээ

2.2 Хүн ахтай дээл захтай

2.3 Бүлгийн дүгнэлт

#### **ГУРАВДУГААР БҮЛЭГ: ХҮН-ТЕХНОЛОГИ ХООРОНДЫН ХАРИЛЦАА**

3.1 Цахим үндэстэн

3.2 Фейсбүүкээр явуулчих аа!

3.3 Монгол цахим гэр бүл

3.4 Бүлгийн дүгнэлт

#### **ДҮГНЭЛТ: БАЙГАЛЬ-ХҮН-ТЕХНОЛОГИ**

#### **САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

#### **НОМ ЗҮЙ**

#### **ХАВСРАЛТ**

## УДИРТГАЛ

Аливаа үндэстний онцлог, ондоошил нь соёл, урлаг, ёс заншил, хэм хэмжээ зэргээр илэрдэг. Харин соёл, урлаг, ёс заншил, хэм хэмжээ зэргийг илэрхийлэгч зүйлсийн нэг бол хүн-хүн хоорондын харилцаа юм. Монголчуудын хувьд эртнээс нүүдлийн мал аж ахуй эрхлэн байгальд дасан зохицож амьдарсаар ирсэн нь хүн-хүн хоорондын харилцаанд ихээр нөлөөлсөн байдгийг тус судалгаагаар гаргаж ирэхийг зорьсон юм. Зарим тохиолдолд хүн-байгалийн харилцаа нь хүн-хүн хоорондын харилцааны суурь болох ч үе байна. Нэг ёсондоо нүүдэлчдийн харилцаа байгаль-хүнийгэм гэсэн гуравласан холбоогоор явж, эргэлдэж байдаг нь анхдагч, хоёрдогч эх сурвалжууд, хээрийн судалгааны ярилцлага зэргийн үр дүнд батлагдаж байв. Энэ талаар гадаад, дотоодын олон судлаачид судалж, нүүдэлчдийн хүн-хүн хоорондын харилцаа, өдөр тутмын мэндчилгээ, зочломтгой зан, хүндлэл, цээрлэх ёс зэрэгт хүн-байгалийн харилцаа байдаг талаар бичиж тэмдэглэсэн нь энэхүү судалгааны ажлыг хийх үндэслэл болсон юм. Гэсэн хэдий ч нийгэм, соёл, хүн гэх ойлголт маань өөрчлөлт, шинэчлэлт гэх үгтэй үргэлж хоршиж байдаг тул түүний илрэх хэлбэр, тодорхойлох утга ухагдахуунд өөрчлөлт орсоор байгаа нь ч хээрийн судалгааны үеэр ажиглагдаж байв. Эдүгээ техник, технологи, хиймэл оюун ухаан хөгжиж, “мэдээллийн эрин үе” гэгдэх болсон цаг үед хүн-хүн хоорондын харилцаанд хүн-байгаль нөлөөлөх бус хүн-технологи нөлөөлж эхэлсэн байна. Өөрөөр хэлбэл, байгаль-хүн-технологи-нийгэм гэх дөрвөлсөн холбоо нэгэнтээ бий болжээ. Хувь хүн, гэр бүл, хувь хүн-байгаль, нутгийн иргэд-байгаль хооронд үүсдэг харилцаанд технологийн эзлэх байр суурь өдөр ирэх тутам нэмэгдсээр байна. Техник, технологи хүн-хүн, хүн-байгалийн харилцаанд нөлөөлөхийг төрийн бодлогоор дэмжиж, нийгмийн бүхий л давхарга, салбарт технологийг нэвтрүүлснээр технологийн хувь хүмүүс болон ард иргэдэд нөлөөлөх нөлөө улам томорсоор байна. Жишээлбэл, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх замаар эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилт тавьж, “Цахим Үндэстэн” болох уриалгыг дэвшүүлсэн юм. Иймд, нүүдэлчин монголчуудын өнөө цагийн харилцааны онцлог, хэм хэмжээ, ёс заншил, түүнд гарч буй өөрчлөлт, шинэчлэлтийг судлах зайлшгүй шаардлагатай тулгарч байна. Дээрх судалгааны үндэслэлийн хүрээнд Улаанбаатар, Архангай, Баянхонгор хээрийн судалгаа явуулж, хот болон хөдөө амьдардаг хүмүүсийн хүн-байгаль, хүн-хүн, хүн-технологийн харилцааг харьцуулан судалж, уламжлал, шинэчлэлийг тодрууллаа.

## Судалгааны үндэслэл:

Монголын нүүдэлчдийн хүн-хүн, хүн-байгаль хоёрын харилцаа нь соёл, уламжлал, зан заншил, түүхэн цаг үе, байгаль, цаг уурын нөхцөл байдал, нийгмийн байгууламж, сүсэг бишрэл, амьдралын хэв маяг, сэтгэлгээний өвөрмөц хэв шинж зэргээс бүрэлджээ. Дэлхий ертөнц даяаршиж, гадаад дотоод харилцаа улам өргөжин тэлж, соёл хоорондын синкретизм асар их байгаа энэ цаг үед монголчууд бусад улс, үндэстнүүдээс онцгойрох онцлогоо судлан, таниулахыг эрмэлзэх болсон байна. Жишээлбэл, үндэсний онцлог, ёс заншил, хэм хэмжээгээ судлах талаар Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.2.1-ийн “Өв соёл, зан заншилаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг төлөвшүүлж, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх цогц арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ”<sup>1</sup>, 1.5.1-ийн “Монгол хүний онцлог, давуу тал, үнэт зүйлийг тодорхойлж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ”<sup>2</sup>, 2.1.3-ын “Монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх шатны боловсролын байгууллагад хэрэгжүүлнэ”<sup>3</sup> болон Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх зорилтын 1.2-ын I үе шатын “Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ”<sup>4</sup>, II үе шатын “Үндэсний үнэт зүйлд суурилсан соёлын дархлааг тогтвортой бэхжүүлж, уламжлал шинэчлэлийн тэнцвэрт харьцааг хэвшүүлнэ”<sup>5</sup> гэх мэтээр эрх зүйн баримт бичигтээ тусгаж өгсөн нь тус судалгааг төрөөс явуулж буй бодлогын үндсэн чиглэлтэй шууд хамаарч буйг харуулж байна.

Монголчуудын хувьд байгаль дэлхийтэйгээ дасан зохицож амьдарч ирсэн тул хүн-байгаль хоорондын өвөрмөц харилцаатай. Иймээс монголчуудын хувьд хүн-байгаль-нийгэм гэх гуравласан холбооны харилцааг бүрэлдүүлдэг онцлогтой ард түмэн (Х.Сампилдэндэв, 2004). Энэ талаар гадаад, дотоодын олон судлаач тал талын өнцгөөс судалж, монголчуудын харилцааны онцлог, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсон (Х.Нямбуу 1970, З.Дэнсмаа 2016, Caroline Humphrey 2012, David Sneath

---

<sup>1</sup> Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail/15584>

<sup>2</sup> Мөн тэнд, <https://legalinfo.mn/mn/detail/15584>

<sup>3</sup> Мөн тэнд, <https://legalinfo.mn/mn/detail/15584>

<sup>4</sup> “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, <https://old.legalinfo.mn/annex/details/11057?lawid=15406>

<sup>5</sup> Мөн тэнд, <https://old.legalinfo.mn/annex/details/11057?lawid=15406>

2022) хэдий ч нийгэм нь өөрөө амьд организм тул байнгын өөрчлөлт, шинэчлэлттэй тулгарч байна. Жишээлбэл, нүүдэлчдийн харилцаанд “Сайн байна уу? Тарган тавтай хаваржиж байна уу?” гэх мэт цаг агаар, мал маллагаатай холбоотой мэндчилгээ хүн-хүн хоорондын харилцаанд элбэг байсан бол өнөөдөр “Hi! (Сайн уу!), Ажил тавлаг уу?” гэх гадаад үг хэллэг болоод оффисын ажилтай холбоотой мэндчилгээ хэрэглэх болжээ. Энэ мэтчилэн хүн-хүн, хүн-байгалийн харилцаанд монголчуудын өвөрмөц сэтгэлгээ ил болон далд хэлбэрээр илэрч, уламжлагдан ирсэн боловч нийгмийн өөрчлөлттэй холбоотойгоор гадаад илрэх хэлбэрт нь өөрчлөлтүүд орсоор байна. Дан ганц нийгэм, соёлын өөрчлөлт хүн-хүн, хүн-байгалийн харилцаанд өөрчлөлт оруулаад зогсохгүй техник, технологийн хөгжил дэвшил монгол нүүдэлчдэд шинэ төрлийн харилцаа бий болгоход нөлөөлж байна. Өнөөдөр монголын хамгийн алслагдмал бүсэд ч малчид ухаалаг гар утас, интернэт ашиглаж, телевиз болон бусад мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авч харилцаж байна. Энэ нь монгол нүүдэлчдэд хүн-техникийн харилцаа гэх шинэ харилцааг бий болсныг харуулж байгаа юм. Иймд, XXI зууны монголчуудын хүн-хүн, хүн-байгалийн харилцааг цаг үетэй нь холбон судлах шаардлага зайлшгүй гарч байна.

### **Судлагдсан байдал:**

Монголчуудын хүн-хүн, хүн-байгаль хоорондын харилцааны онцлогтой холбоотой ном болоод судалгааны бүтээлүүд арвин. Тэдгээрийг ерөнхийд нь дараах байдлаар ангилж болохоор байна. Үүнд:

#### **1. Монголчуудын хүн-хүн хоорондын харилцааны судлагдсан байдал:**

Хүн төрөлхтний үүсэл хөгжил цаашлаад соёл, иргэншил, нийгэм бүрэлдэн бий болсон цагаас эхлэн хүн-хүн хоорондын харилцаа нь микро түвшний харилцаа байсаар ирж, тухайн үндэстний онцлогийг шууд болон шууд бус байдлаар харуулдаг тусгал болсоор иржээ. Иймд хүн-хүн хоорондын харилцаа нь тухайн үндэстний бусад үндэстнээс ялгарах ондоошил болж өгдөг. Аливаа ард түмний аман зохиол, урлаг нь хүн-хүн хоорондын харилцааны анхдагч эх сурвалж болдог. Жишээлбэл, монголчуудын сэтгэлгээний илрэл болсон зүйр цэцэн үгэнд “Хүн ахтай, дээл захтай” гэж байдаг (Kohl-Garrity, 2019). “Хүн ахтай, дээл захтай” гэх хүндлэх ёсыг илэрхийлсэн олон домог байдгаас хамгийн алдартай нь Монголын нууц товчоонд гардаг Алунгоо эхийн домог юм. Алунгоо эх “*Та таван хөвүүн, миний нэгэн хэвлийгээс төрсөн биш үү. Та нар ганц*



ганцаар салбал нэжээд сум мэт хүнд хялбархан дийлэгдэнэ. Та нар эв эеэ нэгтгэвэл тэр багласан таван сум мэт бэх болж, хэнд ч хялбар дийлэгдэхгүй болно” гэдэг (Ц.Дамдинсүрэн, 1940). Өөрөөр хэлбэл Алун-гуагийн хоёр хөвүүд болох Бэлгүнүтэй, Бүгүнүтэй хоёр Буха хатаги, Бухату салжи, Бодончар мунхагийг Малиг баяуд овгийн зарц хүний хүүхэд хэмээн сэрдсэнд Алун-гуа эх хөвүүддээ ах дүүгээ хүндэлж, эв эетэй байхыг зааж сургадаг. Ах нь дүүгээ, дүү нь ахыгаа хүндлэн харилцах нь ураг төрөл, цаашлаад төр улс эв эетэй, энх тайван байх үндэс болж буй юм.

Монголчуудын хүн-хүн хоорондын харилцааны тухай Монгол орноор аялж байсан олон хүмүүс бичиж тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, 1970-аад онд Монгол орныг судалж байсан Япон улсын монголч эрдэмтэн Шива Рёотарогийн “Тал нутгийн тэмдэглэл”-д монголчуудын хүн-хүн хоорондын харилцааны онцлог бол нэг нэгэндээ сайн, сайхныг хүсэхээс гадна аливаа зүйлийг болж, бүтэх эерэг талаас нь харахад байдаг гэдгийг монгол эмэгтэйн амьдралын түүхээр дамжуулан харуулсан байдаг (司馬遼太郎, 2008).

Монгол аман зохиол, түүхийн сурвалж бичгүүд дээр үндэслэн монголчуудын уламжлалт хүн-хүн хоорондын харилцааг судалсан судалгааны бүтээлүүд олон. Тэдгээр нь монголчуудын хүн-хүн хоорондын харилцааг тал, талын өнцгөөс харж, шинэлэг, сонирхолтой санаанууд дэвшүүлсэн байдаг. Жишээлбэл, Х.Нямбуу монголчуудын харилцаа бэлгэдэл дээр тогтдог гэх санаагаа малчин хүмүүсийн мэндлэх ёс болох “Сайн байна уу, сайхан зусаж байна уу” гэх мэт мэндчилгээний үгтэй холбон тайлбарласан байна (Х.Нямбуу, 1970). Мөн тэрээр “Нэг өдөр танилцаж, мянган өдөр нөхөрлөнө” гэх зүйр цэцэн үгийн утгыг дээрх мэндлэх зан үйлтэй холбож, нэг нэгнийгээ хүндлэн мэндлэх нь хүн-хүн хоорондын харилцааны эхлэлийг тавьдаг гэж тайлбарлажээ (Х.Нямбуу, 1970). Тэгвэл З.Дэнсмаагийн нэг сэдэвт судалгааны бүтээлд мэнд мэдэх ёс нь хүмүүс хоорондын эерүү, найрсуу зан харилцаатай холбоотой гэх санааг дэвшүүлжээ. Тэрээр монголчуудын “Сонин сайхан юу байна?” гэх мэнд мэдэх ёс нь нүүдэлчин монголчууд бэлчээрийн мал ахуй эрхэлдгээсээ шалтгаалж хоорондоо хол амьдран суудаг малчид шинэ, сонин мэдээлэл сонсох шаардлагаар ингэж мэндэлдэг гэж тайлбарлахаас гадна, тал нутагт дайралдсан малчид заавал эерүү, сайхан зантай харилцаагаа эхэлдэг гэх санааг дэвшүүлжээ (З.Дэнсмаа, 2009).

Хүн-хүн хоорондын харилцаа бол нийгмийн хамгийн жижиг бүлэг болох гэр бүл дотор ч байдаг. Энэ талаар Б.Энхболд монгол гэр бүлийн харилцаанд буддын шашны гол үзэл болох нигүүлсэхүй үзэл байдаг талаар санаа дэвшүүлсэн байна (Б.Энхболд,

2010). Түүний нэг сэдэвт судалгааны бүтээлд хүн-хүн хоорондын харилцаанд зөвхөн тухайн ард түмний аж амьдрал нөлөөлөөд зогсохгүй шашны үзэл санаа ч мөн тодорхой хэмжээнд нөлөөлсөн байдаг гэжээ (Б.Энхболд, 2010). Б.Энхболд нигүүлсэхүйн үзэл болох амьтан бүхнийг өөрийн эх мэт үзэж, бүх амьтай, амьгүй бүгдийг өөрийн эх мэт хайрлан, эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусын тулд гэх буддын шашны үзлийг монгол хүмүүс харилцаандаа эрхэмлэдэг гэх санааг дэвшүүлсэн.

Хүн-хүн хоорондын харилцаанд монголчуудын цээрлэх ёсон нөлөөлж байдаг талаар Л.Хантөгс судалжээ (Л.Хантөгс, 2004). Тэрээр “Цээрлэх ёс нь хүн ертөнцийн аливаа зүйлтэй харьцах харилцааны үнэлэмжийг агуулдаг” гэх санааг дэвшүүлж, цээрийн ёсонд аливаа үйлдэл хийхийг хориглосон мэт зүйлс их байдаг боловч уг чанар нь үйлийн үрийг сайн байлгахыг хүсэмжилсэн байдаг гэжээ (Л.Хантөгс, 2004). Өөрөөр хэлбэл, хүн-хүн, хүн-байгаль хоорондын харилцааг зохицуулах зохицуулагч нь цээрийн ёс болж, ёс суртахууны хэм хэмжээг төлөвшүүлдэг чухал ач холбогдолтой гэх сонирхолтой санааг дэвшүүлжээ.

Дан ганц монгол судлаачид монгол нүүдэлчдийн харилцааг судлаад зогсохгүй гадаадын олон эрдэмтэн, судлаачид монгол нүүдэлчдийн хүн-хүн хоорондын харилцааг судалсан байдаг. Жишээлбэл, Каролин Хампри монголчуудын зочлох ёсны талаар судалж, зочин, гийчинг угтан авах гэрийн эзэн болоод гийчний мөрдөх ёстой 100 дүрэм байдаг гэх санааг дэвшүүлсэн (Humphrey, *The Host and the Guest: One Hundred Rules of Good Behaviour in Rural Mongolia*, 1987). Тэрээр энэхүү 100 дүрмээрээ монголчуудын зочлох ёсонд хүн-хүн хоорондын харилцаа хэрхэн илэрдэг талаар судалж, монголчууд айлчин гийчин угтахдаа үзүүлдэг зочломтой зангийнхаа хариуд ямар нэгэн хариу огт нэхдэггүй гэх сонирхолтой санааг дэвшүүлж, энэ нь нүүдэлчин монголчуудын харилцааны онцлог болно гэжээ (Humphrey, *The Host and the Guest: One Hundred Rules of Good Behaviour in Rural Mongolia*, 1987). Мөн Элиса Мириам Кохл-Гаррити өөрийн нэг сэдэвт судалгааны бүтээлдээ монголчуудын хүн-хүн хоорондын харилцаа нь хүндэтгэл дээр тогтож байдаг гэх санааг дэвшүүлж, монголчуудын хүн-хүн хоорондын харилцаа нь улс төр, шашин, эдийн засгийн нөлөөгөөр институцлэгдэж хүн-хүн хоорондын харилцаа нь хууль эрх зүй, улс төрийн үг хэллэгээр баяжиж цаашлаад нийгмийн давхарга, статусыг илэрхийлэх хэлбэр болдог гэх сонирхолтой санааг дэвшүүлсэн байна (Kohl-Garrity, 2019). Давид Снийт гэр дотор хүмүүс хаана суудагтай хүн-хүн хоорондын харилцааг холбож, тухайн хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь,

статус нь түүний гэр дотор хаана суудагтай холбоотой байдаг гэж судалсан байна. Тэрээр гэрийн хоймор хэсэгт ахмад, хүндтэй хүмүүс сууж хүмүүсийн хүндэтгэлийг хүртдэг гэх санааг дэвшүүлжээ. Мөн Давид Снийт XVIII зууны Монголд хэрэгжиж байсан Халх журам гэх эрх зүйн баримт бичигт зочлох ёсыг хуульчилж өгсөн талаар сонирхолтой баримт гаргаж иржээ (Sneath, 2019). Язгууртан дээдэс, лам, элч нар айлаар зочлоход тухайн айл морь, мал, хөсөг, тэргээр хангаж өгөх ёстой гэж Халх журамд хуульчилж өгсөн байна. Үүнээс гадна, дээрх эрх зүйн баримт бичигт хүүхдүүд эцэг эхийгээ хүндлэх ёстой, хэрэв үл хүндэтгэвээс шийтгэх ёстой талаар хуульчилж өгсөн нь монголчууд хүн-хүн хоорондын харилцааны эрхэм ёсоо хууль, эрх зүйн бичигтээ хүртэл тусгаж байсныг харуулж байна (Sneath, 2019). Харин Кристофер Атвүүд Монголчуудын харилцаанд Манж Чин гүрний нөлөө байдаг гэх санааг дэвшүүлсэн. Тэрээр язгууртан, ноёдод өгдөг зэрэг дэв нь монголчуудын өдөр тутмын харилцаанд нөлөөлсөн талаар өөрийн өгүүлэлдээ бичжээ (Atwood, 2000). Энэ мэтчлэн монгол нүүдэлчдийн хүн-хүн хоорондын харилцааг судалсан гадаад, дотоодын олон судалгаа байна.

## 2. Монголчуудын хүн-байгаль хоорондын харилцааны судлагдсан байдал

Нүүдэлчин монголчууд нь байгаль, дэлхийтэйгээ дасан зохицож амьдарч ирсэн ард түмэн. Иймдээ ч бусад ард түмнээс илүүтэйгээр байгаль дэлхийгээ аргадан, тайтгаруулж ан, амьтантай зэрэгцэн оршсоор ирсэн юм. Монголчуудын ардын аман зохиол, үлгэр домог, түүхэн сурвалж бичгүүдэд хүн-байгалийн хоорондын харилцааг дүрсэлсэн байдаг. Жишээлбэл, монгол зүйр цэцэн үгт:

Усны эх нь булаг

Улсын эх нь нагац

Хүний уг нагац

Модны уг үндэс гэдэг. Энэ нь хэдий эхийн талын садан төрөл болох нагацыг өвөг удмын эх үндэс хэмээн хүндэтгэсэн утгатай байгаа ч модны уг үндэс, усны эх нь булаг гэдгээс ах дүү, хамаатан садныгаа хүндэтгэн үздэгтэйгээ адил байгаль дэлхийг хайрлан, хүндэтгэх ёстой гэх санааг дэвшүүлж байгаа юм. Мөн нагац үгүй болоход өөрийн бие үгүй шиг усны эх, модны үндэс үгүй болоход байгаль дэлхий үгүй болно гэх санааг давхар гаргаж ирчээ. Мөн хүн-байгалийн харилцааны нэг бол байгаль, дэлхийг магтсан магтаал юм. Ардын аман зохиолын дотор нутаг усны байгаль түүний үзэсгэлэн, ан

амьтан, араатан жигүүртэн, ашигт малтмал зэрэг арвин баялгийг нь бахархан магтсан магтаалууд нь эх нутгаараа бахархан хайрлахын үзэл санаа юм гэж Х.Сампилдэндэв бичсэн байдаг (Х.Сампилдэндэв, 2004). Цаашлаад монголчуудын өдөр тутмын амьдралдаа байгаль дэлхийтэйгээ харилцдаг олон хэлбэр байдаг нь уул, овоо тахих болоод бусад ёс заншил, зан үйлээр илрэн гарч ирдэг.

2011, 2012, 2013 онуудад гаргасан ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэнгийн удирдан хэрэгжүүлсэн төслүүд дээр нүүдэлчдийн харилцаа нь дан ганц хүмүүс хоорондын харилцаа бус байгаль дэлхийтэй харилцах харилцаан дээр тулгуурлаж байдаг гэх санааг дэвшүүлжээ (Б.Энхтүвшин 2011, Б.Энхтүвшин 2012, Ж.Энэбиш 2013). Монголчуудын байгаль дэлхийтэйгээ харьцах харилцааг гадаадын судлаачид ихэд сонирхон судалдаг. Жишээлбэл, Каролин Хампри, Марина Монгуш, Теленгид нар байгаль гэх үгийн “бай” нь “байх” гэх үгний үндэс болж, амьд биетийн оршихуйтай холбоотой ойлголт байдаг гэх санааг дэвшүүлсэн байдаг (Humphrey et al, 1993). Мөн тэрээр монголчуудын уламжлалт хүн-байгалийн харилцаанд шашны үзэл санаа нөлөөлж, аливаа газар усыг эзэнтэй гэж үзэх болсон гэжээ.

Энэхүү уул, усны эзэн гэх ойлголт гарч ирснээр монголчуудын хүн-байгалийн харилцаа улам төгөлдөржиж, монголчуудын өдөр тутмын амьдрал болоод зан үйлд хүртэл нөлөөлж эхэлжээ. Энэ талаар С.Дулам “Одон тэнгэрийг урих, тахих судар”-тай (Банзаров, 1846) холбож, хүн-байгалийн харилцаа бол монгол нүүдэлчдийн харилцаанд томоохон байр суурь эзэлдгийг тайлбарлажээ.

### **Судалгааны зорилго:**

Даяаршлын нөлөөгөөр Монгол нүүдэлчдийн хүн-хүн, хүн-байгаль хоёрын уламжлалт харилцаанд ямар өөрчлөлт орж буйг, мөн түүнд юу нөлөөлж байгааг нийгэм-соёл, антропологийн онолын үүднээс судлахыг зорилгоо болгов. Мөн техник технологийн хөгжил дэвшил хүмүүсийн харилцаанд хэрхэн нөлөөлж буйг гаргаж ирэх нь тус судалгааны бас нэгэн зорилго болно. Дээрх зорилгуудын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн.

- Хүн-хүн хоорондын уламжлалт харилцааг гадаад, дотоодын судлаачдын судалгаанд тулгуурлаж тодорхойлох,
- Хүн-байгаль хоорондын уламжлалт харилцааг гадаад, дотоодын судлаачдын судалгаанд тулгуурлаж тодорхойлох,

- Хүн-хүн, хүн-байгаль хоорондын уламжлалт харилцаанд өөрчлөлт орж буйг хээрийн судалгаанд тулгуурлаж тодорхойлох,
- Хүн-хүн, хүн-байгаль хоорондын уламжлалт харилцаанд өөрчлөлт оруулж буй хүчин зүйлсийг тодорхойлох,
- Даяаршлын нөлөө монгол нүүдэлчдийн харилцаанд нөлөөлж буйг тодорхойлох,
- Хүн-технологийн харилцаа монгол нүүдэлчдийн харилцааны онцлогт нөлөөлж буйг тодорхойлох,
- Хүн-хүн, хүн-байгаль, хүн-технологийн хоорондын харилцааг антропологийн орчин үеийн онолуудтай холбон тайлбарлах.

### **Судалгааны ач холбогдол: онолын болон практик:**

Тус судалгаа нь дан ганц хүн-хүн, хүн-байгаль хоорондын уламжлалт харилцааг судлаад зогсохгүй XXI зуунд дээрх харилцаа нь хэрхэн өөрчлөгдөж, түүнд юу нөлөөлж буйг гаргаж ирэхийг оролдсон нь XXI зуунд амьдарч буй монголчуудын харилцааны шинэ хэв маягийг тодруулсан судалгаа болж өгч, цаашдын монгол нүүдэлчдийн харилцааг судлах судалгааны суурь болох ач холбогдолтой. Мөн тус судалгааг хийхдээ нийгэм-соёлын онолуудыг ашигласнаараа хүн-хүн, хүн-байгаль, хүн-технологийн хоорондын судалгааг онолын түвшний судалгааны эргэлтэд оруулах ач холбогдолтой. Үүнээс гадна, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.2.1-ийн “Өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг төлөвшүүлж, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх цогц арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.”<sup>6</sup>, 1.5.1-ийн “Монгол хүний онцлог, давуу тал, үнэт зүйлийг тодохойлж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.”<sup>7</sup>, 2.1.3-ын “Монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх шатны боловсролын байгууллагад хэрэгжүүлнэ”<sup>8</sup> болон Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх зорилтын 1.2-ын I үе шатын “Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ.”<sup>9</sup>, II үе шатын “Үндэсний үнэт зүйлд суурилсан соёлын дархлааг

<sup>6</sup> Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай, <https://legalinfo.mn/mn/detail/15584>

<sup>7</sup> Мөн тэнд

<sup>8</sup> Мөн тэнд

<sup>9</sup> Алсын хараа 2050, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого,

<http://nda.gov.mn/backend/files/%D0%90%D0%9B%D0%A1%D0%AB%D0%9D%20%D0%A5%D0%90%D0%A0%D0%90%D0%90%202050%20%D0%9C%D0%9E%D0%9D%D0%93%D0%9E%D0%9B%20%D0%>

*тогтвортой бэхжүүлж, уламжлал шинэчлэлийн тэнцвэрт харьцааг хэвшүүлнэ.*”<sup>10</sup> гэх мэт Монгол Улсын бодлогыг тодорхойлсон эрх зүйн баримт бичгийн суурь судалгаа болж өгөх ач холбогдолтой юм.

### **Судалгааны асуудал ба нэр томьёо:**

#### **а) Судалгааны асуудал**

Тус судалгааны асуудал бол нүүдэлчин монголчуудын хүн-хүн, хүн-байгаль хоорондын харилцаа нь уламжлалаа хадгалангаа хэрхэн өөрчлөгдөж буйг судлахаас гадна хүн-технологи гэх шинэ харилцааны хэлбэрийн талаар тодруулах юм. Энэхүү асуудлуудыг тодруулахын тулд дараах нэр томьёог түлхүүр нэр томьёо болгон судалгаагаа хийнэ.

#### **б) Судалгааны нэр томьёоны тодорхойлолт**

**Харилцаа (Communication):** Харилцааг олон салбар шинжлэх ухаан янз бүрийн өнцгөөс тайлбарласан байна. Жишээлбэл, хэлний антропологит “Харилцаа нь нэг этгээд нөгөө этгээдийг өдөөн хатгадаг үйлийг хэлнэ” (Hockett, 1958) гэж тодорхойлж, тухайн соёлын хэлээр дамжин өрнөдөг гэж үзжээ. Гэсэн хэдий ч харилцааг дан ганц хэлээр дамжин илэрдэг гэж үзэх нь учир дутагдалтай. Учир нь хүн-хүн хоорондын харилцаанд дан ганц тухайн үндэсний хэл чухал үүрэг гүйцэтгээд зогсохгүй биеийн хэлэмж, нүдний харц, дохио зангаа, нүүрний хувирал зэрэг тодорхой хэмжээнд үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү аман бус харилцааны хүн-хүн хоорондын харилцааг зохицуулах фактор болж өгдөг юм (Birdwhistell, 1952). Монголд ч ахмад настантай мэндлэхдээ золгох, хүний нүд рүү эгцэлж удаан харахгүй гэх мэт харилцааг зохицуулдаг аман бус харилцаа байдаг.

Харин социологийн шинжлэх ухаанд харилцааг нэгээс нөгөөд тодорхой утга бүхий мэдээлэл дамжуулдаг гэж тайлбарладаг (Mondal, 2018). Харилцаа нь дан ганц хүн-хүн хооронд байхгүй соёлын бүх өгөгдлүүд хоорондоо харилцаж болдог талаар социологийн шинжлэх ухаан онцолжээ. Иймд монголчуудын хүн-байгаль болон шинээр бий болоод буй хүн-технологи хоорондын харилцааг ч дээрх ойлголтын хүрээнд тайлбарлаж болохуйц байгаа юм.

---

[A3%D0%9B%D0%A1%D0%AB%D0%9D%20%D0%A3%D0%A0%D0%A2%20%D0%A5%D0%A3%D0%93%D0%90%D0%A6%D0%90%D0%90%D0%9D%D0%AB%20%D0%A5%D3%A8%D0%93%D0%96%D0%9B%D0%98%D0%99%D0%9D%20%D0%91%D0%9E%D0%94%D0%9B%D0%9E%D0%93%D0%9E.pdf](#)

<sup>10</sup> Мөн тэнд

Мөн сүүлийн жилүүдэд хөгжиж буй медиа судлалд орчин үеийн нийгэмд аливаа харилцаа нь медиагаар дамжиж илрэх боломжтойгоос гадна медиа ертөнцөөс тодорхой хэмжээгээр мэдээлэл авч буй тохиолдолд хүн-технологийн харилцаа ч харилцааны нэг хэлбэр болох боломжтой гэж тайлбарлаж байна (Coman, 2006).

**Хүндлэл (Respect):** Хүндлэл гэх ойлголтыг соёл бүр янз янзаар тайлбарладаг. И.Кант хүндлэлийн талаар философийн үүднээс эргэцүүлж, хүндлэлийг аливаа хүн зөвхөн өөрийн зорилгоо гүйцэтгэхийн тулд ашиглаж болохгүй, бүх хүн тэгш харилцаатай байх ёстой гэх санааг дэвшүүлсэн байдаг (Kant, 1785). Мөн барууны орнуудад хүндлэл нь “love” (хайр) буюу аливаа зүйлийг хайрлахтай нягт холбоотой байдаг талаар судлаачид бичжээ (Seeman, 1997). Дорно дахинд түгсэн күнзийн сургаалд хүндлэлийг (Filial Piety) зөвхөн эцэг эх, ахмад настныг хүндлэх хүндлэл бус хүний дотоод сэтгэлтэй холбоотой байдаг гэж тайлбарладаг (Wawrytko, 1982). Соёл судлаач Кю-Тайк Сүнг Күнзийн сургаалд байдаг хүндлэлийг эцэг эхийгээ хүндлэх, бэлэг солилцооны, хэлний, баяр наадмын, орон зайн хүндлэл гэх мэтээр ангилжээ (К.Т., 2017).

**Бэлгэдэл (Symbol):** Бэлгэдэл бол хэлний дохио тэмдгээс цааш нь хоёр дахь “мета-хэл” бүтээдэг. Үр тарианы нэгэн зүйлийг “арвай” хэмээн нэрлэж буй нь анхдагч дохио мөн бол түүнээс ургуулан дөрвөн арвайгаар мал сүрэг, эд баялаг өсч үржихийг бэлгэдэж, байгаа нь дохионы дохио буюу бэлгэдэл болж, дараагийн хэлийг бүтээж байгаа хэрэг мөн (С.Дулам, 2000). Бэлгэдлийн талаар антропологич Шерри Ортнер судалж, бэлгэдэл нь ямар нэгэн асуудлыг шийдэх, даван туулах хүмүүний үйл хэргийн төлөвлөгөө (plan), хөтөлбөр (program), хөтөч (guide) юм гэж үзсэн (B.Ortner, 1973). Тодруулбал, бэлгэдэл нь хүмүүний амьдралын тодорхой асуудлыг шийдэх, даван гарах үйл хэргийн кодлогдсон програм (B.Ortner, 1973). Ортнерийн үзэж буйгаар түлхүүр бэлгэдэл (key symbols), түлхүүр бус бэлгэдэл (non-key symbols) гэж байдаг. Түлхүүр бэлгэдэлд улс орны далбаа, сүлд тэмдэг гэх мэтчилэн багтдаг бол түлхүүр бус бэлгэдэлд монголчуудын хүн-хүн, хүн-байгалийн харилцаанд гарч ирдэг байгаль дэлхийд сүү, цайныхаа дээжийг өргөх, овоо тахилга гэх мэт зан үйлүүд ордог.

**Технологи (Technology):** Технологийг хүний оюун ухааны практик хэрэгжилт (Ferre, 1995) гэж тодорхойлжээ. Ферийн үзэж буйгаар хүмүүст технологийг удирдах хүч байдаг учир хүн-технологийн харилцаанд хүмүүс илүү сүпериор байдаг. Гэсэн хэдий ч 1995 онд тодорхойлсон Ферийн тодорхойлолтоос хойш технологи асар хурдацтай хөгжиж, өнөөдрийн дэлхий ертөнцийг технологигүй төсөөлөхийн аргагүй болсон.

Сүүлийн жилүүдэд нийгмийн асуудал болоод буй их хотын ганцаардал хүн-хүн, хүн-байгаль хоёрын харилцааг багасгаж байгаа ч хүн-технологи хоорондын харилцааг ихэсгэх болжээ. 2021 оны байдлаар Япон Улсад нийт 696000 гаруй хикикомори<sup>11</sup> байдаг гэх тоон баримт байх агаад дээрх хүмүүсийн дийлэнх хувь нь гадаад ертөнцтэй харьцахдаа зөвхөн технологийг ашигладаг гэжээ.

### **Судалгааны онолын өнцөг:**

Хүн-хүн хоорондын харилцааг антропологийн бүтцийн онол, бэлэг солилцооны онолуудтай холбон судалсан судалгаа их байна. Гэсэн хэдий ч харилцаа нь нийгэм, соёлын нэг элементийн хувьд антропологийн бусад онолуудтай холбон тайлбарлах боломжтой. Жишээлбэл, Лесли Вайтын соёлын хувьслын онолоор соёлын гурван янзын тогтолцоог ялгаж үздэг (Д.Бум-Очир, 2012). Үүнд, технологийн тогтолцоо буюу хүнийг байгальтай холбоход хэрэглэгдэх дасан зохицуулагч арга технологи, нийгмийн тогтолцоо буюу хүнийг хүнтэй аль эсвэл бүлэг хүмүүстэй холбож байдаг социологийн систем, гуравдугаарт, сэтгэлгээний тогтолцоо болох сэтгэлгээ, итгэл үнэмшил, мэдлэг, бэлгэдэл ордог (Д.Бум-Очир, 2012). Иймд нүүдэлчин монголчуудын хүн-хүн, хүн-байгалийн харилцаа нь хүнийг байгальтай холбоход хэрэглэгддэг зан үйл болоод ёс заншил түүнээс үүдэн гарч ирсэн сэтгэлгээ, итгэл үнэмшил, мэдлэг болох юм. Лесли Вайт аливаа соёл дах анхан шатны тогтолцоог бүрдүүлснээр соёлын элементүүд хоорондоо зохицох боломжтой болдог гэж үзсэн. Мөн Лесли Вайт “бэлгэдэл”-ийн талаар “бэлгэдэл гэдэг бол хүн төрөлхтний ертөнц нь юм” гэж, бэлгэдлийг анхдагч ба хоёрдогч бэлгэдэл гэж ангилжээ (White, 2007). Түүний үзэж буйгаар анхдагч бэлгэдэл нь шууд утга бүхий төлөөллийг хэлдэг бол хоёрдогч бэлгэдэл нь шууд бус утгатай ба үгс нийлж өгүүлбэр болоод утга илэрхийлдэг. Нэг ёсондоо монгол нүүдэлчдийн “Амархан сайн байна уу?” гэх мэндчилгээний үг нь “сайн”, “амар” гэх мэт сайн сайхны бэлгэдлийг агуулсан хоёрдогч бэлгэдэл бүхий ойлголт болно.

Антропологийн ухаанд хүн-хүн хоорондын харилцаанаас гадна хүн-хүмүүн бусын харилцааг ч судлах болж, янз бүрийн нийгэм, соёлд соёлын онцлогоосоо хамаарч хүмүүс дан ганц хүмүүстэй харилцаад зогсохгүй байгаль дэлхий болоод амьтадтай харилцдаг талаар дурдсан байдаг. Энэ талаар мултиспешис онолыг баримтлагч Эдуардо Кон “антропологи нь зөвхөн хүнээр хязгаарлагдахгүй, бидний эргэн тойронд буй бүх

---

<sup>11</sup> Хикикомори (引きこもり) буюу өөрийн сонирхдог зүйлээ хийхээс бусад үед огт гэрээсээ гардаггүй хүнийг хэлнэ.



амьд ба амьд бус биетийн харилцааг судлах ёстой” (Kohn, 2013) гэж тодорхойлсон. Мөн хүн-хүмүүн бусын харилцаанд тухайн нийгмийн улс төр, эдийн засаг, соёл онцгой нөлөө үзүүлдэг хэмээн маргасан байдаг. Иймд хүн-байгалийн харилцаа нь дан ганц антропологийн асуудал болоод зогсохгүй экологи, биологийн асуудал болж буй юм.

Даяаршил нь хүн-хүн, хүн-байгалийн харилцаанд нөлөө үзүүлж буй хамгийн том фактор. Иймд бид XXI зуунд хүн-хүн, хүн-байгалийн харилцааг уламжлалт мэдлэг дээр тулгуурлан судлахтай зэрэгцэн даяаршилтай холбон судлах зайлшгүй шаардлагатай тулгарч байгаа юм. Антропологич Аржун Аппадурай даяаршил дахь нэгтшил ба олоншлын талаар судалсан. Тэрээр мэдээллийн хэрэгсэл нь улс үндэстнүүд хоорондын соёлын синкретизмд томоохон нөлөө үзүүлж байна гэж үздэг. Өөрөөр хэлбэл, мэдээллийн технологи өндөр хөгжсөн нь дэлхий нийтийг нэгдсэн нэг мэдлэг мэдээллээр хангаж, улс үндэстнүүд нэгтшлийн үйл явцад орж байгаа юм (Appadurai, 1990). Жишээлбэл, нүүдэлчин монголчуудын хүн амын талаас илүү хувь нь хот, суурин газарт төвлөрч амьдрах нь монголчуудын хүн-хүн, хүн-байгаль хоорондын харилцаанд өөрчлөлт оруулж, утга агуулгынхаа хувьд уламжлалаа хадгалж байгаа ч илрэх хэлбэрт нь өөрчлөлт оруулах үндсэн нөхцөл нь болж байгаа юм. Мөн мэдээллийн хэрэгсэл, техник технологийн асар хурдацтай хөгжил нь хүн-технологийн харилцаа гэх шинэ харилцааг бий болгожээ.

### **Судалгааны арга зүй ба бэрхшээл:**

Тус судалгааг чанарын, дедуктив судалгааны арга зүй ашиглан хийнэ. Чанарын судалгааг хагас бүтэцлэгдсэн ярилцлагын аргаар, Улаанбаатар, Архангай, Өмнөговь аймгуудад оршин суудаг малчин болоод бусад хөдөлмөр эрхлэх насанд хүрсэн 20 хүнээс авахаар төлөвлөсөн.

Судалгаа явуулахад тохиолдсон бэрхшээл нь хөдөө орон нутагт ярилцлага авч байхад уул уурхайтай холбоотой судалгаа явуулж байгаа мэт сэрдэж, ярилцлага өгөхгүй байсантай холбоотойгоор судалгааны таамаглал болон дэвшүүлсэн асуудлаа батлахад төлөвлөсөн хугацаанаас илүү хугацаа зарцуулсан.

### **Судалгааны бүтэц**

Тус судалгаа удиртгал, гурван бүлэг, дүгнэлт, хавсралт ном зүй гэсэн хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээр бүлэгт хүн-байгаль хоорондын уламжлалт харилцаа болоод түүнд гарч буй өөрчлөлтийн тухай, хоёрдугаар бүлэгт хүн-хүн хоорондын уламжлалт харилцаа

болоод түүнд гарч буй өөрчлөлтийн тухай, гуравдугаар бүлэгт хүн-технологийн харилцааны талаар судлав.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### ХҮН-БАЙГАЛЬ ХООРОНДЫН ХАРИЛЦАА

*Нүүдэлчин монголчууд эртнээс байгалийн эрс тэс уур амьсгалд дасан зохицож, мал сүргээ маллаж ирсэн уламжлалтай ард түмэн. Иймд, монголчуудад цаг агаар тогтуун байх нь амьдралын чухал үзэгдэл байсан талаар аялагчид, эрдэмтэд, судлаачид өөрсдийн тэмдэглэл, судалгаандаа онцлон тэмдэглэсэн байдаг. Эртний монголчууд байгалийн гамшигт үзэгдлийг ямар нэгэн далдын хүчинд бий болж буйд итгэж, байгалийг шүтэх, байгалийг аргадах, хишиг гуйх гэх мэт зан үйлүүд үйлдэж ирсэн нь өнөөдрийг хүртэл үргэлжилж байна. Жишээлбэл, зарим уул, өвөрмөц тогтоц бүхий газар нутгийг эзэн, савдагтай хэмээн итгэж өргөл өргөх, овоо тахих зан үйлийг Архангай, Баянхонгор аймаг, Улаанбаатар хотод үйлдэж байна. Үүнээс гадна монголын зарим судлаачдын судалгааны бүтээлүүдэд газрын эзэн савдагийг амьтны дүртэй байдаг талаар тэмдэглэж, судалсан байдаг нь Архангай аймагт хийсэн хээрийн судалгааны үеэр ч ажиглагдаж байлаа. Хэдий Монгол Улсад техник, технологи хөгжиж “Цахим үндэстэн” болох зорилгыг төрийн бодлоготоо тусгасан байгаа ч хүн-байгалийн уламжлалт харилцаа хэвээр хадгалагдаж буй нь дан ганц хөдөө орон нутагт гэлтгүй хотод оршин суудаг хүмүүсийн дунд ч байна. Иймд нэгдүгээр бүлгээр монгол нүүдэлчдийн харилцааны суурь болсон хүн-байгалийн харилцаа, түүний уламжлал, шинэчлэлийг тодрууллаа.*

#### **1.1 “Газрын эзэн” ба хүн хоорондын харилцаа**

Хүн ба байгалийн харилцаа холбооны тухай монголчуудын үзэл нь юун түрүүн тэнгэр, газрын тайлга тахилга, уул, овоо, лусын тахилга, сацлын зан үйлүүдээр илэрч байдаг. Уул, овоо, лусын тахилга, сацлын зан үйлийг хийхдээ монголчууд тухайн уул, овоо, лусаа газрын эзэдтэй (зарим тохиолдолд савдагтай) хэмээн итгэж газрын эзэдтэй харилцаа үүсгэж байдаг нь сонирхолтой. Тэрхүү харилцаа нь газрын эзнээс эмээх, хүндлэх, хайрлах байдлаар өргөл, тахилга, сацлын зан үйлийг хийж, хариуд нь хур бороо оруулах, өөрсдийн амьдралыг сайн сайхан явуулахыг хүсэх, амь, амьдралаа даатгах гэх мэт байдлаар илэрдэг. Хүн ба газрын эзний харилцаа үргэлж сайн, сайхныг бэлэгшээсэн, хоёр тал ашигтай харилцаа байдаггүй. Зарим тохиолдолд уул, усыг бохирдуулах, савдагтай уулнаас ан агнах, жимс түүх, түлш бэлтгэх зэргээс үүдэж газрын эзэн уурсан хилэгнэж, байгалийн гамшигт үзэгдэл болох золгүй явдал тохиож ч болдог талаар ярьж байв (Г.Зулбаатар, Улаанбаатар хот, 2022).

Хүний зүгээс байгалийг “эзэд”-тэй хэмээн үздэг үзэл эртнээс монголчуудад байсныг С.Дулам тодруулж, “Савдаг-Газрын эзэн (Атаа хилэн хорслоор арин, аюумшигт товуун дүртэй, цаг цагт өргөл тахилгыг нь дутаахгүй байх учиртай аль нэг орон нутгийн газар шорооны тэнгэр),”, “Шивдаг-Дэлхийн эзэн (Лусын бүлэгт төлөв хамаарах бөгөөд тийм болохоор олонх тохиолдолд хангари, барс, арслан, баавгай, чоно гэх мэт)”, “Навдаг-Орны эзэн (Хүний оройн үсэнд ирж оршин амь нас, хишиг буяныг сахин хамгаалдаг)” (С.Дулам, 2009) хэмээн ялган үзжээ. Өөрөөр хэлбэл, нүдэнд харагдаж, гарт баригдахгүй ч бидэнтэй харилцаж байдаг байгаль дэлхийн эздүүдийг ялгасан хэрэг юм. Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Баянбулаг гэх малчдын хаварждаг газрын хажууханд байх Чоно төрдөг догшин уул нь газрын эзэнтэй (савдагтай) тул малаа ч бэлчээж болдоггүй талаар малчид дурдсан (Мөнх-Эрдэнэ, Жаргал, Архангай аймаг, 2022). Гэсэн хэдий ч Мөнх-Эрдэнэ, Жаргал нарын газрын эзэн, уул усны савдагтайгаа ойртон, энерги авч, гэр бүл болоод өөрийн амь нас, аз, хийморийг даатгадаг газар бол дээрх Чоно төрдөг гэх догшин уул юм. Малчин Мөнх-Эрдэнэ *“Миний төрсөн нутаг энэ газар биш ч энэ уулын оройгоос төрсөн нутгаа хардаг. Хийморио сэргээдэг. Хааяадаа нэг гарахад их сайхан байдаг.”* (2022 оны 06 сар, Архангай аймаг дахь хээрийн судалгааны тэмдэглэлээс) гэж хэлсэн бол Баянбулагт хаварждаг малчин Жаргал *“Савдагтай ууланд ургаж байгаа цэцэг, навч, модыг тасдаж болохгүй. Тусгай түлш бэлтгэдэг газар гэж байна. Эндээс зөвхөн унасан мөчир, гишүү л түүж болно. Савдагтай.”* (2022 оны 05 сар, Архангай аймаг дахь хээрийн судалгааны тэмдэглэлээс) гэж хэлснээс үзэхэд хүний зүгээс байгалийг “эзэд”-тэй хэмээн үзэж тухайн газрыг хүндлэн, хайрлаж, хүн-байгаль, хүн-газрын эзний хооронд харилцаа үүсэж буйг харуулж байна. Мөн Л.Жаргал *“Савдагтай гээд айх хэрэг байхгүй. Болохгүй л юм хийхгүй бол”* (2022 оны 05 сар, Архангай аймаг дахь хээрийн судалгааны тэмдэглэлээс) гэж унасан мөчир, гишүү түүх үедээ хэлж байсан нь байгаль дэлхийтэйгээ буруу харьцах, газрын эзний зөвшөөрөлгүйгээр мод унагаах, ан агнах, жимс түүхэд газрын эзэд уурлан хилэгнэдэг болохыг хэлж байна. Энэ мэтчлэн биднийг хээрийн судалгаагаар Архангай аймагт ярилцлага хийн явж байхад догшин буюу эзэнтэй, савдагтай гэж хэлэгддэг олон уул, газар байсан ба малчид үр, хүүхдүүдээ эзэнтэй ууланд тоглуулдаггүй, малаа бэлчээдэггүй нь монголчуудын хүн-байгаль хоорондын харилцаа, тэр дундаа байгалиа хайрлан хамгаалах, эргээд байгаль дэлхийгээ тогтуун, тайван байхыг хүссэн өвөрмөц харилцааны нэг илрэл юм. Доорх зургийг 2022 оны 06-р сард Архангай аймагт хээрийн судалгаа хийж байх үедээ авсан бөгөөд Чоно

төрдөг гэх савдагтай уулын мод, Азарга багийн Бямбасүрэнгийн хаваржааны ойролцоо байх түлш бэлтгэдэг уулнаас илүү шигүү ургасан байгааг харж болохоор байна.



Зураг 1. Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Баянгол багийн Чоно төрдөг гэх савдагтай (эзэнтэй) ууланд малчин Мөнхбаатар унасан мөчир, гишүү, унаанга түүж буй нь. 2022 он 06-р



Зураг 2. Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Азарга багийн малчин Бямбасүрэн түлшээ бэлдэж буй нь. 2022 он 06-р сар

Тус хоёр ууланд хар мод голчлон ургах ба байгалийн тогтоц, ургадаг ургамалын төрөл зүйлд ялгаа бараг байхгүй. Гэсэн хэдий ч малчин Мөнхбаатар Чоно төрдөгөөс унасан мод, гишүү, унаанга түүхдээ өдөр харж, мод бэлтгэх тусгай өдрөөр бэлтгэдэг бол Бямбасүрэн түлшээ бэлтгэхдээ өдөр, судар хардаггүй гэж хэлж байв. Иймд монголчуудын хүн-байгаль, хүн-газрын эзэнтэй харилцах харилцаа нь байгаль дэлхийн далдын хүчинд итгэх, монголчуудын ертөнцийг харах үзэл, байгаль дэлхийгээ хайрлан, хамгаалахтай шууд холбогдож буй нь ажиглагдсан юм. Мөн Архангай аймгийн малчин Эрдэнэбаяр “Савдагтай уулнаас энэ хавийнхан түлш бэлтгэдэггүй. Холоос ирсэн хүмүүс харин хааяа түлш бэлтгээд байгаа харагддаг. Хар модоор нь сүхний иш хийдэг.” (2022 оны 05 сар, Архангай аймаг дахь хээрийн судалгааны тэмдэглэлээс) гэж хэлж байсан ба энэ нь тухайн газар нутгийн эзэд, савдаг бол ойр орчимд нь нутаглан амьдардаг хүмүүстэй холбогдож, харилцаа үүсгэдэг бол өөр нутгийн хүмүүстэй харилцаа тогтоодоггүй мэт сонирхолтой санааг дэвшүүлж байгаа юм.

Эртний хүний сэтгэлгээгээр байгалийн аливаа зүйлийг амьтай (анимизм) хэмээн итгэж, түүнийг хэрхэн танин мэдсэн тухай дэс дараалал нь “Дүр-Үйлдэл-Юм-Санаа” гэсэн дараалалтай байсныг С.Дулам “Одон тэнгэрийг урих тахих судар”-т:

*Дардайн байгч уулын эзэд*

*Дархиран урсагч усны эзэд*

*Арвайн байгч уулын эзэд*

*Сарвайн ургасан өвс модны эздээс хутаг гуйнам* (С.Дулам, 2009)

хэмээн гардгаар жишээлэн бүхий л зүйл эзэнтэй бөгөөд тэр эзэд нь тодорхой дүрс хэлбэртэй, мөн тэднээс хишиг хутаг гуйж байдгийг судлан бичсэн нь хүн байгалийн харилцааны чухал нэгэн ойлголт юм. Энэ талаар Архангай аймгийн Ихтамир сумын малчин эмэгтэй Сүрэнхорлоо өөрийн аав ээждээ зориулж овоо босгохдоо газрын эзнээс гуйж овоогоо босгосон талаараа дурдаж, өвөл зундаа сайн, сайхан амьдрахыг газрын эздээс хүсэж, цагаан идээгээ өргөдөг талаар онцлон хэлж байв (2022 оны 05 сар, Архангай аймаг дахь хээрийн судалгааны тэмдэглэлээс). Түүний босгосон гэр бүлийн, тахилгагүй овоо нь хиргисүүр байдаг жижиг толгод дээр байрладаг ба тэрээр дээрх газрыг тус газар нутагт амьдарч байсан өвөг дээдэстэй нь холбож өгдөг гэж хэлэхээс гадна аав, ээжийнх нь амьдарч өссөн газар тул аав, ээж нь төрж, өссөн газартайгаа үргэлж холбоотой байх болно гэж хэлж байв. Өөрөөр хэлбэл, монголчуудын байгаль дэлхийтэйгээ харилцаж буй харилцаа нь байгаль дэлхийгээ “эзэн” гэх үл харагдах нэгний өмч болгохоос гадна өвөг дээдэстэй нь холбож өгдөг, тэдэнтэй харилцах харилцаа болж байна. Үүний үр дүнд, “Хад бүр хан болсон, бут бүр бурхан болсон” гэж үздэг байгалийн эздэд сацал өргөх, тэдгээрийг баясгах, тахих зан үйлийн олон уламжлал бий болжээ (Х.Сампилдэндэв, 2004).





Зураг 3. Архангай аймгийн Ихтамир сумын Хан-Өндөр багт амьдардаг Сүрэнхорлоогийн эцэг, эхдээ зориулан босгосон гэр бүлийн, тахилгагүй овоо. 2022 оны 06-р сар.

Сүрэнхорлоо дээрх овооны дэргэд “Дээр нэг чоно улиад байсан. Би харах гээд очсон боловч байхгүй. Ойр, ойрхон дуугараад байдаг юм.” (2022 оны 05 сар, Архангай аймаг дахь хээрийн судалгааны тэмдэглэлээс) гэж хэлсэн ба тухайн газар нутагт амьдардаг малчид Чоныг “Хангай” гэж нэрлэдэг бөгөөд газрын эзэн мэтээр хүндэлдэг нь ажиглагдсан (2022 оны 06 сар, Архангай аймаг дахь хээрийн судалгааны тэмдэглэлээс). Мөн хэд хэдэн малчид малыг нь чоно барихад, хангай юмаа авч байна хэмээж бэлэгшээдэг нь газрын эздийг зөвхөн нүдэнд үл харагдах биетээр төсөөлөхгүй амьтдын дүрээр илэрч болох ба өөрсдийн мал нь байгаль дэлхийн “юм” болохоос малчдын өмч биш гэдгийг харуулж байгаа юм. Дээр дурдсан С.Дуламын Шивдаг-Дэлхийн эзэн (Лусын бүлэгт төлөв хамаарах бөгөөд тийм болохоор олонх тохиолдолд хангари, барс, арслан, баавгай, чоно гэх мэт)-ий тайлбарийг (С.Дулам, 2009) Сүрэнхорлоогийн дурдсан чонын улих дуу болоод чоныг хангай хэмээж хүндлэн үзэж, хүн газрын эзэн хооронд харилцаа үүсэж буйтай холбож болохоор байна.

## **1.2 Идээний дээж сүү**

*Газрыг эзэнтэй (зарим тохиолдолд савдаг) хэмээн үзэж буй эртний монголчуудын сэтгэлгээ хүн-байгалийн харилцаа бий болоход хамгийн их нөлөө үзүүлсэн гэхэд хэлсдэхгүй. Иймд, газрын эзэнтэй харилцаа тогтоож, түүнийг уурлуулж хилигнүүлэхгүй байх нь нүүдэлчин монголчуудын амьдралын баталгаа болж байна. Мөн эртний монголчуудаас өнөөгийн малчдын дунд ч газрын эзнийг хүнээс илүү хүчирхэг,*

*ямар нэгэн ид шидийн юм (сайн, муу аль нь ч байх боложмтой) хийдэг гэж итгэж буй нь газрын эзэнд ямар нэгэн юм өргөх, тэд нарыг баярлуулах, хариуд нь өөрсдийн амь, амьдралыг даатгах далдын хүчинд тулгуурласан харилцааг бий болгожээ. Энэхүү харилцаа нь тахилгын зан үйл гэхээсээ илүүтэй өдөр тутмын амьдралд, өглөө наранд, шөнө саранд тэнгэр, нар, саранд сүү өргөх гэх мэтээр илэрч байна. Эдүгээ энэхүү сүү, цайныхаа дээжийг өргөх нь монгол ёс, соёлын нэг хэсэг болжээ. Харин энэхүү дэд бүлэгтээ газрын эздэд сүү өргөх шалтгааныг тодруулахыг оролдож, хүн-байгалийн ямар харилцаа нуугдаж байдаг талаар тодруулахыг зорьлоо.*

Монголчуудын байгаль дэлхийгээ эзэнтэй хэмээн үзэж аливааг өргөх, гуйж буй өгөө авааны харилцаа (М.Моссынхоор бол “бэлэг солилцоо”) нь амьтны амь таслан тахиx, амьдаар сэтэрлэхээс илүүтэй өдөр тутам сүү, цайныхаа дээжийг өргөх байдлаар илрэх нь элбэг байна. Орон нутагт амьдарч байгаа хүмүүст байгаль дэлхийтэйгээ харилцах тун амар байх бөгөөд өглөө наранд сүү, цай, цагаан идээний дээжээ өргөх төдийгүй, шөнө сар болоод одонд өргөх уламжлал ч байна. Тухайлбал, Увс аймгийн Завхан сумын өндөр настан Н.Орлом гуай зөвхөн өдөр дээж өргөдөггүй, долоон бурхан одонд шөнө дээж өргөдөг хэмээн ярьсан нь, “*Сар шөнө гарна. Тэгээд хүний амьдрал дээр доороо ороод л, нэг хэсэг нь тэнгэрт дэвшээд, нэг хэсэг нь дороос гарч ирнэ. Тэгэхээр тэр бурхан гэдэг юм чинь шөнө их явдаг гэнэ. Сар нарандаа өргөнө, дөрвөн зүг найман зовхистоо өргөнө. Яахав, ёстой тэгээд юм хооллож үнэхээр чадаж байгаа бол миний хүүхдүүдэд буян болно биз дээ*” (Н.Орлом, Баянхонгор аймаг, 2022) гэснээс үзвэл зөвхөн нарыг төдийгүй, сар, одыг шүтэх монголчуудын үзэл сэтгэлгээ өнөө цаг үед тодорхой хэмжээгээр хадгалагдаж байгааг харуулжээ. Мөн Н.Орлом гуайн ярьснаас нар, саранд өргөл өгөхөд байгаль дэлхий хариуд нь үр хүүхдүүдэд нь буян болох Моссын өгөө авааны харилцаа байгааг харж болохоор байна. Барнард Моссын нийгэм дэх бэлгийн үүргийг функционализмын жинхэнэ жишээ (Barnard, 2000) хэмээн тодорхойлж, бэлэг солилцоо буюу өгөө авааны харилцаа нь нийгмийн харилцааг өдөөж, нийгмийг ажиллагаанд оруулж байдаг гэжээ (Д.Бум-Очир, 2012). Иймдээ ч монголчуудын байгаль дэлхийдээ сүү, цайныхаа дээжийг өргөх харилцаа нь байгаль дэлхийтэйгээ дасан зохицож амьдарсаар ирсэн монголчуудын байгалиа аргадан хайрлах, хариуд нь байгалийн гамшигт үзэгдэл зэргээс малаа хамгаалах, үр хүүхдийн ирээдүйн амьдралыг даатгах зэрэг далдын хүчтэй холбогдох хүсэлтэй холбогдож байна.

Дээрх сүү, цайныхаа дээжийг өргөж, газрын эзэнд өөрийн болон дотны нэгнийхээ ирээдүйг даатгах өгөө авааны харилцаа монголчуудын өнө эртний түүхэнд ч бичигдэж



үлдсэн байдаг. Жишээлбэл, Монголын нууц товчоонд Мэргидүүд Бөртийг булаасны дараа Тэмүжин Мэргидийг дайлаар мордохынхоо өмнө “Хүзүүндээ бүсээ өлгөж, малгайгаа гартаа атган, гараа цээжиндээ наан наран өөд есөн удаа сөхрөн бөхийж, Бурхан Халдун уулсын зүг мөргөж сүү цацав” (Battsengel, 2018) гэж гардаг. Нэг ёсондоо Тэмүжин өөрийн хийх гэж буй тулаан болоод Бөртийн амь нас, ирээдүйг байгаль дэлхий, газрын эзэндээ даатгаж сүүгээ өргөж байна.

Мөн хол газар явж буй нэгний аян зам өлзийтэй байх, буцаж ирэхийн ерөөлийг дэвшүүлж байгаль дэлхийдээ сүү, цайныхаа дээжийг өргөж, харилцах тохиолдол ч бий. Энэхүү байгаль дэлхийтэйгээ харилцах явцад монголчууд сүүтэй цайг өргөл болгох нь элбэг. Сүүтэй цай нь дан ганц байгаль дэлхийд өргөх сацал (харилцаа) болоод зогсохгүй айлчин гийчин, хүндтэй зочин ирэхэд өгдөг зочломтгой зангийн нэг илрэл болдог. Монгол зүйр цэцэн үгт,

Цай ч үгүй

Царай ч үгүй; (Raymond, 2010)

Цай хэдий шингэн боловч идээний дээж

Цаас хэдий шингэн боловч номын хуудас; (Raymond, 2010)

гэх мэт зүйр цэцэн үг байдаг. Энэ нь өдөр тутмын амьдралдаа байгаль дэлхийд өргөдөг сацлын нэг, цай нь дан ганц байгальтайгаа харилцахдаа бус хүн-хүн хоорондын харилцааг зохицуулж байгааг ч харуулж байгаа юм.

Монголчуудын байгаль дэлхийдээ сүү, сүүтэй цайны дээжийг өргөх сацлын зан үйл нь монголчуудын “цагаан” өнгөний бэлгэдэлтэй холбогдож, монголчуудын итгэл бишрэл, соёлын онцгой элемент, байгаль дэлхийтэйгээ нэгдэх, харилцах харилцаа болж байдаг. Сүү нь цэвэр ариун байдал, бэлчээрийн өв уламжлал, эхийн сэтгэлийг илэрхийлдэг бэлгэдлийн чанартай (Thrift, 2014). Монголчууд сүү, цагаан идээнийхээ дээжийг байгаль, дэлхий, нутаг усныхаа уулс, газрын эзэн, савдагтаа өргөдөгөөс гадна хүндэт зочид, айл гэрийн эзэнд идээ, ундныхаа дээжийг баривдаг. Энэхүү цагаан өнгөний бэлгэдэл нь цэвэр ариун байдлыг илэрхийлэх бөгөөд монголчуудын ахуй амьдралтай ч холбогддог. Монголчууд төл малыг өвөл болтол сүүнээс нь салгадаггүй, үнээг хүн саахаас өмнө богинохон хугацаанд төл малд нь хөхүүлэхийг зөвшөөрдөг (Thrift, 2014). Өөрөөр хэлбэл, монголчуудын сүү, цагаан өнгөний бэлгэдэл нь мал аж ахуйн эх мал болон төл малын хоорондын ариун харилцаа, цаашлаад хүн болоод этүгэн (газар) эхийн

харилцаатай холбогдож байгаа юм. Өөрөөр хэлбэл, байгаль дэлхийдээ сүү өргөх нь хүн болон байгалийн харилцааг эх, үрийн харилцаа мэт ойртуулж өгөхөөс гадна хүн, амьтан бол байгаль дэлхийгээс хараат амьтан гэх монголчуудын аж ахуйгаад үүдэлтэй үндэсний өвөрмөц сэтгэлгээний тусгал болжээ. Өнөөдөр ч гэсэн сүүг ариун, цэвэр байдлыг илэрхийлдэг байдлаар авч үзэх, хүн-байгаль хоорондын харилцааны онцгой хэлбэр байдлаар үзэх явдал бидний өдөр тутамд байнга дайралдаж байдаг. Жишээлбэл, Увс аймгийн Тэс сумаас Улаанбаатар хотод их сургуульд суралцахаар ирсэн МУИС-ийн оюутан “Сүүг газар ч асгаж болохгүй. Дандаа л тэнгэрт өргөдөг. Ээж тэнгэрт өргөхдөө нэг юм хэлээд л байдаг. Заяа маяа гээд. Сүүг газарт асгачихвал манайхан мөрөндөө заавал түрхдэг. Хамаагүй шалны алчуураар бас арчиж болохгүй шүү.” (З.Бадамсүрэн, Улаанбаатар хот, 2022) гэж хэлсэн. Энэ нь сүүг ариун, цэвэр гэж үзэн хайрлан, хамгаалан, хүндтэй нэгэн, аль эсвэл юманд өргөдөгөөс газарт асгаж болохгүй гэх монголчуудын хүн-байгалийн харилцааны онцгой тохиолдол гарч ирж байна. Мөн яагаад мөрөндөө хүргэдэг талаар асуухад, “Уучлаарай гээд уучлалт гуйж байгаа нь юм уу даа” (З.Бадамсүрэн, Улаанбаатар хот, 2022) гэж хариулснаас харахад тухайн сүүг амьд биет мэт үзэж амьдчлаж буйг харуулж байна.

XXI зууны хотжсон нийгэмд амьдарч буй монголчууд харь орон руу явж байгаа нэгнийхээ төлөө сүү, цайны дээжээ өргөх нь элбэг байдаг. Шинээр байгуулагдсан “Чингис хаан олон улсын нисэх буудал”-ын ойр орчимд сүү, цайны толбо болсон хэсэг олон байдаг. Иймд, байгаль дэлхий, газрын эзэнд сүү өргөх нь монголчуудын зан заншил, бэлэг солилцооны илрэл, оюун санааны зан үйл, ёс суртахууны чухал элемент, нийгмийн харилцааг зохиоцуулагч чухал хүчин зүйлсийн нэг хэвээр байгаа юм (Ahearn, 2020). Монголын томоохон хувийн хувьцаат компани нэг болох АПУ-гаас үйлдвэрлэдэг сүүн, сүүн бүтээгдэхүүний нэр “Дээж” гэж байгаа нь монголчуудын байгаль дэлхий



Зураг 4. АПУ ХХК-ы Дээж сүү, сүүн бүтээгдэхүүн,  
Эх сурвалж: <https://ikon.mn/n/2c1q>

болоод хүндтэй нэгэндээ хүндтгэл үзүүлж сүү, цайныхаа дээжийг өргөдөг харилцаатай шууд холбогдож байна.

Байгальтай харилцах, хүсэх, гуйх зорилгоор хийж буй цай, сүүний дээж өргөх зан заншил нь сүүлийн үед Улаанбаатар хотод хэрхэн өрнөж, “үнэлэгдэж” байгааг авч үзье. Цай сүүнийхээ дээжийг өргөх уламжлал нь хотжилтын улмаас нэлээд асуудал үүсгэх болсон нь хүмүүс гадаа гарч бус, байрныхаа цонхоор өргөж, энэ нь уул ус, тэнгэр хангайдаа өргөхөөс илүүтэй нэг нэгнийхээ машинд өргөх явдал болж хувирчээ. Доорх зурагт настай эмэгтэй нь хэдийгээр үр хүүхэд, ард түмэн, улс орныхоо төлөө хэмээн сүүнийхээ дээжийг өргөж байгаа ч зохисгүй газраас өргөвөл энэ нь бэлгэдлийн шинж чанараа алдаж, үр дүнд нь орчныг бохирдуулсан явдал болно гэдгийг хошин зургаар харуулжээ. Мөн монгол гэрийн тооноор сацал өргөдөггүй шиг орон сууцныхаа цонхоор өргөх нь буруу юм гэдгийг шүүмжилжээ.



*Зураг 5. Тооноороо сацал огт өргөдөггүйг*

*Тод сайн санаарай та минь... С. Баярцогт*

Улаанбаатар хотод оршин суудаг залуу иргэдийн хувьд “Сүүгээ цонхоор өргөх нь хоёрын хооронд юм шиг санагддаг. Угтаа нартаа өргөдөг байтал хагас дутуу, ёс болгосон маягтайгаар хийж байгаа юм шиг санагддаг” (2022 оны 9-р сар, Улаанбаатар хот дах хээрийн судалгааны тэмдэглэлээс) гэх мэт сэтгэгдэлтэй байгаа юм. Өөрөөр хэлбэл, байгаль дэлхийдээ сүү, цайныхаа дээжийг өргөх нь монголчуудын аж ахуйгаас үүдэлтэй зан үйл болоод харилцаа болох нь шууд харагдаж байгаа юм. XXI зууны хотжсон

Улаанбаатар болоод бусад суурин газруудад монголчуудын хүн-байгалийн харилцаанд өөрчлөлт орох нь цаг хугацааны асуудал болж буй юм.

Гэсэн хэдий ч байгалийн эзэдтэй харилцаж, тэднээс хүссэнээ гуйж мөргөх, тахиж замаар өөрсдийн амьдралд хэрэгтэй бүхнийг авах харилцаа нь нүүдэлчдийн хувьд өөрсдөдөө гэхээс илүүтэй ангийн хишиг, малын үржил шимийг гуйхад чиглэсэн байдаг. Энэ тухай Х.Сампилдэндэв “Мал төллөн сааль сааж эхлэх үеэр малынхаа үр төлийг бүрэн мэнд бойжуулж идээ цагаа элбэгтэй байхыг бэлгэдэн саасан сүүний дээжийг тэнгэр, газар орчны уул усанд цацал өргөх ёс үйлддэг байв” (Х.Сампилдэндэв, 1985) гэжээ. Ч.Заяасүрэн,

“Сацлын олон судруудын агуулга нь тун адил байдаг бөгөөд ерөнхийдөө хавар зуны их ган гачиг, өвлийн зуд турхныг үзүүлэхгүй байхыг гуйсан шинжтэй байдаг. Сацлын судруудад хамгийн их давтагдаж буй үгсийг нарийвчлан гаргахад “Тэнгэр” хэмээх үг хамгийн олон тохиолдож байлаа. Тухайлбал, “Гүүний үрс гаргах” сацлын сударт 23 удаа орсон байдаг” (Ч.Заяасүрэн, 2021)

гэхчлэн бичсэн байдаг нь тэнгэр шүтлэгт монголчууд тэнгэртэйгээ харилцах үндсэн шалтгааныг харуулжээ. Энэ талаар Клайр Чонг “*Дурсамж, мэдрэмж идэж, уух юманд шингэн хүн хоорондын харилцаанд дахин гарч ирснээр сэтгэл хөдлөлийн хүчтэй хариу үйлдэл төрүүлдэг*” (Chong, 2019) гэж тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, хүн-байгаль, хүн-хүн хоорондын харилцаа сүү, цайгаар дамжин гарч ирэх нь монголчуудын харилцааны чухал элемент болж өгч байна.

Дан ганц хотод оршин суудаг иргэдийн хувьд ч гэлтгүй хөдөө, орон нутагт амьдардаг зарим залуу малчин гэр бүлүүд огт байгальтай харьцдаггүй гэж өөрсдийгөө үзэж байв (З.Гансувд, Баянхонгор, 2022). Малчин гэр бүлийн хувьд ингэж хэлсэн нь сонирхолтой бөгөөд мал аж ахуйг байгалиас хараат бус байдлаар буюу өөрсдийн хүч хөдөлмөрөөр маллаж байгаа гэж ойлгодогтой холбоотой байна. Мянга, мянган жилийн турш байгаль дэлхийдээ сүү, цайныхаа дээжийг өргөж ирсэн монголчуудын дунд ч ёс заншлаа хадгалж үлдэхгүй, үр хойчдоо өвлүүлэхгүй байгаа үзэгдэл ажиглагдаж байна.

### **1.3 Хүн-малын харилцаа**

*Өмнөх дэд бүлэгт өгүүлсэнчлэн монголчуудын хүн-байгалийн харилцаанд газрын эзэн-хүн хоорондын харилцаа гол байр суурь эзэлж, газрын эзэнг аргадаж, байгаль цаг уурын таатай нөхцлийг хүсэх, гай барцдаас хол байлгах гэх мэтийг хүсэн, сүү, цайныхаа*

*дээжийг өргөх солилцооны харилцаа байгааг ажиглаж болохоор байна. Малчдын цаг, уурын таатай нөхцлийг газрын эзнээс хүсээж буй нь мал аж ахуйтай шууд холбоотой. Мал аж ахуй, мал маллагаа нь нүүдэлчин монголчуудын амьдралаа залгуулах гол эх булаг юм. Зарим судлаачид “Бэлчээрийн мал аж ахуйн нийгэмд хүн малыг тэжээх, үржүүлэх, ажиглах, махчин амьтдаас хамгаалах зэрэг нь ноёрхолын, тэгш бус, харилцааг бий болгодог” (Descola, 2013) гэж үздэг ч монголчуудын хүн-малын харилцаа нь ноёрхолын, тэгш бус, харилцаанаас илүү дотно харилцаа үүсгэсэн тохиолдол хээрийн судалгааны үеэр хэд хэд гарч ирэв. Ялангуяа судалгаанд оролцсон малчин эмэгтэйчүүд малаа өөрийн үр хүүхэд мэт хайрлах, өхөөрдөх хандлага ажиглагдаж байсан. Иймд энэхүү дэд бүлгээрээ монгол хүний малтайгаа харилцах харилцааны онцлог, өвөрмөц байдлыг гаргаж ирэхийг зорьлоо.*

Хэдий энэ мэтчлэн хүн-байгалийн харилцаа хотжилт, техник технологийн хөгжлийн улмаас мартагдаж байгаа ч хүн ба байгалийн харилцаанд хувь оруулах нэгэн сонин зүйл бол хүн болоод малын харилцаа юм. Мал хэдийвээр үг яриагүй боловч малчин хүн малтайгаа ярих, дуудах, нэрлэх байдлаар харилцах нь тун элбэг байна. Тухайлбал, малыг нэрлэх нь энэхүү харилцааны хамгийн анхдагч хэлбэр бөгөөд тухайн мал нэрээ мэдэж, эзнээ дуудахад ирдэг болох, эхийнх нь нэрийг үр төлд нь дамжуулсаар хэдэн үеээр нь нэрлэх тохиолдлууд байна (2022 он 8-р сар, хээрийн судалгааны тэмдэглэлээс). Үхрийн хувьд, Борко, Зээрээ, Онио, Бүдүүнээ (Т.Болор-Эрдэнэ, Баянхонгор, 2022), Бороо, Хөөрхнөө, Согоо (С.Гантулга, Баянхонгор, 2022) гэхчлэн нэрлэж байна. Малчин С.Гантулгын “Буурал эмээ” нэртэй сарлагийн үнээ байдгийг хүмүүс сонсоод хүн гэж боддог тухай ярьсан нь тэднийх буурал үс урд руу нь унжсан сарлагаа тэгж нэрлэснээс болжээ. Ялангуяа малчин эмэгтэйчүүд төл малаа өөрийн хүүхэд мэт хайрлан маллалдаг нь Архангай, Баянхонгор аймагт хээрийн судалгаа хийх явцад ярилцлага авсан бүх эмэгтэйчүүдэд ажиглагдсан. Архангай аймгийн Өндөр-Улаан, Ихтамир сумын малчин эмэгтэйчүүд төл малаа хүүхэд мэт хайрлан асарч, өвдсөн үед нь гэр дотроо оруулан эмчлэх мөн хайртай малаа муулдаггүй талаар дурдсан ба хүүхдүүдээ авдрын цоож, орны хөлөөс уях нь үнээгээ саахдаа төл малаа хашаанаас уяхтай ижил гэж хэлэх тохиолдол ч гарч байв (2022 оны Архангай аймаг дах хээрийн судалгааны тэмдэглэлээс).

Дээрх хүн-малын харилцааг олон орны судлаачид судалсан байдаг (Pedersen 2001, Descola 2013, Jordan 2003, Ventsel 2006). Үүнээс Десколагийн хүн-малын хооронд бичсэн нэг сэдэвт бүтээлд “Бэлчээрийн мал аж ахуйн нийгэмд хүн малыг тэжээх,

үржүүлэх, ажиглах, махчин амьтдаас хамгаалах зэрэг нь ноёрхолын тэгш бус, харилцааг бий болгодог” (Descola, 2013), гэсэн бол Фин өөрийн өгүүлэлдээ “Монголчууд Сибир орчмын нүүдэлчидтэй ижилхэн, мал маллахдаа эзэн-өмчийн харилцаагаар харьцдаг” (Fijn, 2011) гэх санааг дэвшүүлсэн байдаг. Гэсэн хэдий ч зарим судлаачид хүн-малын харилцаанд сүнсний асуудал гарч ирдэг гэх санааг гаргаж ирсэн нь монголчуудын хүн-мал-байгалийн харилцааг зөвөөр тодорхойлсон болов уу гэж харж байна. Жишээлбэл, Монголчууд малдаа ихэд хүндэтгэлтэй хандаж, малыг муулах үедээ малын сүнснийг хүндэтгэж, цус урсгахгүйгээр зан үйлээ хийдэг (David, 2010). Мөн мал муулахынхаа өмөн “Ум мани падмэ хум” гэх Буддын шашны тарни уншихаас гадна “Би чамайг алах санаагүй байсан, андуурчихлаа” гэх мэтчлэн уучлалт хүссэн үг шивнэж, “Чамайг олон өнгийн тугал болохыг хүсэн ерөөе” (Charlier, 2015) гэх мэт эзэн-өмчийн харилцаанд байхааргүй харилцаатай байхаас гадна тусгай зан үйл үйлддэг болохыг олон судлаачид тэмдэглэн үлдээжээ. Мөн зарим малыг бусад малаас илүү “дээд” амьтан гэж үзэж, өндөр газар үлдээдэг заншил байна. Жишээлбэл, адууны гавлын ясыг модны орой, уулын орой, овоо тахилга зэрэгт тавьсан байдаг (Stépanoff, 2017) нь монголчуудын морио хүндлэн дээдэлдэг харилцаатай холбоотой. Архангай аймгийн Ихтамир сумд хээрийн судалгаа хийж явахад морин овоо нэг бус удаа тааралдсан. Мөн тус морин овоон дээр хонины мөртэй чулууг тавьж, сүү өргөсөн байгаагаас харахад тухайн газар нутгийн хүмүүс ихэд бэлэгшээдэг болох нь тодорхой байна. Монголчуудын амьдрал, аж ахуй мал



маллалгаатай шууд холбоотой, байгаль дэлхий, цаг уурын нөхцөл байдлаас шууд хамаарч байдаг тул малыг ихэд дээдлэн харилцдаг аж. Энэ талаар сүүлийн жилүүдэд монголчууд урлаг, соёлын салбартаа ч харуулж дуу, кино, бүжгэн жүжиг гэх мэт олон урлагийн төрөл зүйлээр хүн-малын харилцааг харуулах болсон. Жишээлбэл, 2019 онд гарсан Хийморь, 2020 онд гарсан Шарга даага гэх мэт монгол уран сайхны кинонд хүн-байгаль, хүн-мал амьтдын харилцааг дүрсэлсэн байдаг. Дээрх кинонд дан ганц хүн гэлтгүй мал амьтан хүртэл эх нутгаа хэмээх санагалзсан сэтгэлтэй байхаас гадна хүн-байгаль-мал гурвын хооронд хүйн холбоо байдаг мэтээр дүрсэлсэн нь монголчуудын өвөрмөц сэтгэлгээг харуулж байгаа хэрэг.

Хүн-мал хоёрын хооронд хүйн харилцаа бий болоход эмэгтэйчүүд чухал байр суурь эзэлдэг. Эх малдаа гологдсон төлийг эхд нь авхуулах, сүү саах, төл малыг хаших



*Зураг 6. Архангай аймгийн Ихтамир сумын Хан-Өндөр багт байдаг морин овоо. 2022 оны 06-р сар, хээрийн судалгааны тэмдэглэлээс*



*Зураг 7. Зураг 6-т байгаа морин овоон дээр тавьсан хонины мөртэй чулуу. 2022 оны 06-р сар, хээрийн судалгааны тэмдэглэлээс*

гэх мэт сэтэрлэх, муулахаас бусад үед эмэгтэйчүүд малаа бие даан хариулж, маллалдаг. Ялангуяа эх малдаа гологдсон төл малыг эхд авхуулахдаа эмэгтэйчүүд янз бүрийн дуу, авиа гарган харилцаж, эх, үр хоёрыг нийлүүлдэг байна. Энэхүү зан үйлийг ажваас үр хүүхдээ хайрлан өсгөдөг, эх хүний сэтгэл тухайн малыг хайрлан, энэрч байгааг шууд харуулдаг. Хэрэв эх нь төл малаа авахгүй тохиолдолд айл гэрийн эмэгтэйчүүд, хүүхдүүд, зарим тохиолдолд эрэгтэйчүүд хүртэл өөрийн нэгэн төрөл мэтээр хайрлан, өсгөдөг болох нь хээрийн судалгааны үеэр ажиглагдсан. Жишээлбэл Архангай аймгийн Ихтамир сумын Хан-Өндөр багт амьдардаг Мөнххишиг эхдээ гологдсон унагыг угжиж, өсгөдөг

талаараа ярьж “Эх нь догшин юм. Одоо энэ нэг гэж амьтан...” гэж хэлж байв (2022 он 6-р сар, хээрийн судалгааны тэмдэглэлээс). Мөн Мөнххишигийн эхнэр Сүрэнхорлоо өмнө нь тэднийд өөр нэг эхдээ гологдсон унага байхад нь өсгөж, өндийлгөж, өнөө унага нь ер өөрсдийг нь салахгүй дагаад явдаг байсан (2022 он 8-р сар, хээрийн судалгааны тэмдэглэлээс) талаар дурдсан. Монголчуудын хүн-байгалийн харилцаанд томоохон байр суурь эзэлдэг хүн-малын харилцаа нь зөвхөн эзэн-өмчийн харилцаа гэхээсээ илүүтэй сэтгэл, зүрхнээсээ холбогддог найз, нөхөд, ах дүүсийн харилцаа мэт байна.

Харин эмэгтэйчүүдийн хувьд эхдээ гологдсон төлийг авхуулахдаа янз бүрийн дуу авиа гарган харилцдаг. Эргээд мал нь өөрийнхөө эзнийг таньдаг бөгөөд дуугаар нь уярах тохиолдол байна. Харин зарим говийн аймгуудад ингэнд ботгыг авахуулахдаа тусгай зан үйл хийж, морин хуур, дуучин зэргийг хүртэл авчирч авхуулах жишээ байдаг. Архангай болон Баянхонгор аймгуудад хээрийн судалгаа хийж байх явцад малчин эмэгтэйчүүд мал болгонтой өөр, өөр дуу, авиагаар харилцдаг талаар хэлж байв (2022 он, хээрийн судалгааны тэмдэглэлээс). Жишээлбэл, үнээ тугалаа голсон тохиолдолд өөвлөх буюу өөв өөв гэх үгийг уянгалуулан дуулдаг бол хонь, ямаанд хонь, ямааны майлахыг дуурайн түшгэрэх, уянгын аялгуугаар тойглох, зуузуулах, адууг гурийлдан төл малыг нь авахуулдаг байна. Зарим тохиолдолд эх мал нь чононд бариулсан, үхсэн тохиолдолд ишгийг хонинд, хургийг ямаанд авахуулсан тохиолдол ч байна. Монголчуудын хүн-малын харилцаа нь мал аж ахуйтайгаа холбогдож, байгалийн шалгарлыг эргүүлж буй нь дээрх зан үйлээс харагдаж байгаа юм. Мянга, мянган жилийн турш үргэлжилсэн дээрх хүн-малын харилцаатай холбоотой зан үйлийг социализмын үеийн таван жилийн



төлөвлөгөөний биелэлтийг илрэхийлсэн зурагт оруулсан байгаа нь монгол эмэгтэй хүн болоод төл мал, цаашлаад малтайгаа харилцах харилцааг харуулж байгаа юм.

Нийгмийн бүх ангийн төлөөлөл “Ардчилал, социализмын төлөө”, “Энх тайван!” зэрэг уриа лоозон барьж, социализмын үеийн таван жилийн төлөвлөгөөгөө биелүүлэхийг уриалсан дээрх зурагт малчин эмэгтэй арагтаа тэвэр дүүрэн хурга, ишиг хийж тэвэрсэн байгаа нь малчин эмэгтэйчүүд төл малтайгаа харилцаж ирсэн монгол уламжлалыг харуулахаас гадна социализмын үед эмэгтэйчүүдийн нийгэмд нийлүүлдэг



Зураг 8. “Ардын хувьсгалын 31 жил”, 1952 он. Зураач: Тодорхойгүй. “Үнэн” сониноос эрхлэн гаргадаг “Матар” сэтгүүлийн 1952 оны 7 сарын дугаар №7.

бүтээгдэхүүн нь төл мал байсан нь харагдаж байгаа юм.

Монголчуудын байгаль дэлхийгээ хайрлах, тэр дундаа өөрийн малыг хайрлах, харилцах нь хотод оршин суудаг эмэгтэйчүүдэд ч ижил байна. Жишээлбэл гэртээ муур тэжээдэг Э.Батцэцэг “Миний муур бол манай бага хүү. Би гурван хүүхэдтэй хүн дээ...” (Э.Батцэцэг, Улаанбаатар хот, 2022), Ц.Сайнноров “Энэ нэг мууртай чинь хүн шиг ярих хэрэгтэй. Ухаантай шүү.” (Ц.Сайнноров, Улаанбаатар хот, 2022) гэж хэлэх нь монголчууд хотжсон ч байгаль, дэлхий амьд амьтныг хайрлах хайр, түүнтэй харилцах харилцаа хэвээр байгааг харуулж байгаа юм. Энэ мэтчлэн монголчуудын байгалийг хайрлан, хүндэтгэх сэтгэл малчин хүн, хотын хүнд ч тодорхой хэмжээгээр байгааг харж болохоор байна.

#### 1.4 Газрын эзэнтэй холбогч “овоо”

*Дээрх дэд бүлгүүдэд монголчуудын хүн-байгалийн харилцааны олон талт байдлыг харуулахыг зорьсон бол тус дэд бүлэгд хүн-байгалийн харилцааг юу холбож өгдөг талаар судлахыг зорьсон юм. Монголчууд газрын эзэн гэх хийсвэр ойлголттой олон мянган жилийн турш харилцаж ирсэн нь сонирхол татам. Ихэнх тохиолдолд “овоо”-ны тахилга, түүнтэй холбоотой зан үйл хийж газрын эзэдтэй харилцах нь Архангай, Баянхонгор аймагт хийсэн хээрийн судалгааны үеэр ажиглагдсан юм. Овоо нь нэг талаас хүн-байгалийн харилцааг холбогч (gate-keeper) болж өгдөг бол мөн монголчуудын уламжлалт байгаль хамгаалах ёстой холбоотой. Овооны зан үйлийн дараа байгаль дэлхий өнгө жавхаатай болох, хүмүүсийн ажил үйлс бүтэх гэх мэт сайн, сайхан зүйлс ирдэг. Эсрэгээрээ, зарим тохиолдолд хараал, муу юм дагуулах гэх мэт муу, муухай зүйлс ч тохиолдож болох сонирхолтой ухагдахуун юм. Иймд тус дэд бүлгээрээ хүн-байгаль хоёрыг холбогч “овоо”-ны талаар бичив.*

Монголчуудын хүн-байгаль хоорондын харилцааны бас нэгэн онцгой харилцаа бол байгаль дэлхийд буюу савдаг (газрын эзэн), шивдаг (орон дэлхийн эзэн), нявдаг (нутгийн эзэн)-уудад хандан хийх уламжлалт зан үйл бол уул, овооны тахилга бөгөөд тухайн уулын тэнгэрийг тайх ёслол, овоог тахиx юм (С.Дулам, 2009). Тухайлбал, Баянхонгор аймгийн Баянговь сумынхан төрийн тахилгат Их Богд хайрхныг, Шинэжинст сумынхан Сэгс Цагаан богд хайрхныг, Архангай аймгийнхан Булган уулыг тахиж, үргэлж сүсэглэж байдаг нь ажиглагдаж байсан юм (2022 он, хээрийн судалгааны тэмдэглэлээс). Уул, овоог тахиx зан үйл нь тухайн уулын тэнгэрийг тайх зан үйл бөгөөд энэ нь монголчуудын тэнгэрийн тухай үзэл сэтгэлгээтэй гүнзгий холбоотойг Ш.Бира “Эртний монголчууд Тэнгэрийг ихэд тахин шүтэж, аливаа ариун нандин бүхнээ, үүний дотор төр улсаа дээдлэн өргөмжлөхдөө юуны өмнө Тэнгэр бурхантай шууд холбон үзэж, энэ талаар бүхэл бүтэн сургаалыг буй болгосон бөгөөд түүнийг нь бид Тэнгэрийн үзэл буюу Тэнгэризм хэмээн нэрлэж байгаа юм.” (Ш.Бира, 2011) хэмээсэн нь монголчуудын байгальтай харилцах харилцаа нь гэрийн хүрээнээс халин, төр улсын хэмжээнд тунхаглагдсан харилцаа болохыг харуулж байна. Монголчуудын овоо тахилга нь малчдаас үл хамаарах хүчний эрхшээлд буй зүйлд нөлөөлөх арга юм (У.Бямбаян, 2014). Овоо нь ихэвчлэн уулын орой дээр байх агаад монголчууд үүнийг “уулын тахилга” (Humphrey, After-lives of the Mongolian Yurt: the archaeology of a Chinese tourist camp, 2002) гэж нэрлэдэг. Уул, овоог тахилгатай, тахилгагүй хэмээн хуваан үздэг. Тахилгатай овоо нь жил бүрийн тахилгын тогтсон өдөртэй, нэг сум, аймаг бүр улсын

хэмжээнд, тухайн нийгмийн бүлгийн онцлон шүтдэг, томоохон ёслолын шинжтэй зан үйлийг хэлдэг бол тахилгагүй нь хувь хүн юм уу, өрх бүлийн шинжтэй, тэдний буян хишиг, аз хийморийг даасан байх нь олонтаа (У.Бямбаням, 2014). Биднийг хээрийн судалгаанд явж байх хугацаанд Архангай аймгийн Ихтамир сумын Хан-Өндөр багийн Хан-Өндөр хайрханг тахих овооны тахилга болсон. Тус хайрханг Хан-Өндөр уулын бэлд нутагладаг малчид зуны эхэн сард тахидаг. Тус багийн малчин Ариунжаргал “*Овоо тахисны дараа тэнгэр, хангай сайхан болж, хур бороо их ордог. Овоо тахисны дараа л бороо орно доо*” (Ариунжаргал, Архангай, 2022) гэж хэлж байв. Өөрөөр хэлбэл, Ариунжаргалын үзэж буйгаар овоо тахисны дараа хангай дэлхий баярлаж, буян хишгээ хайрладаг нь бороо болон илэрдэг юм. Ингэснээр тухайн газрын бэлчээр соргог болж, зуншлага сайхан болно.

Өнөөдөр уул, овооны тахилга нь дан ганц хүн-байгаль хоорондын харилцаа болоод зогсохгүй ах дүү, хамаатан садангаараа уулзах хүн-хүн хоорондын харилцааг зохицуулагч болжээ. Жишээлбэл, Архангай аймгийн Ихтамир сумын Хан-Өндөр багийн Хан-Өндөр хайрханг тахихад овоон дээр хэн хамгийн түрүүнд малгай тавьсан түүний гэр бүл овооны тахилгыг зохион байгуулж, тухайн гэр бүлийн нэр дор овоо тахилгын зан үйл явагддаг (2022 он, хээрийн судалгааны тэмдэглэлээс). Иймд, малчид овоо тахих ёсын өмнөх өдөр Хан-Өндөр хайрханд гарч малгайгаа тавин ирэх жилийн овооны тахилгын зохион байгуулалтын эрхийг олж авах юм. Дээрх зан заншлыг хэзээнээс эхлэн хийж эхэлснийг асуухад тодорхой он, цаг үе хэлэх огт байхгүй байсан хэдий

монголчуудын “Малгай тавибал манайх” гэх зүйр цэцэн үг овоо тахилгатай холбоотой байж магадгүй гэх таамаглалыг төрүүлж байсан юм.



*Зураг 9. Архангай аймгийн Ихтамир сумын Хан-Өндөр багийн Хан-Өндөр хайрханы тахилгын үеэр. 2022 оны 6-р сарын 08, хээрийн судалгааны тэмдэглэлээс*



*Зураг 10. Хан-Өндөр хайрханыг тахисны 3 хоногийн дараа хур, тунадас орж бэлчээрийн гарц сайжрав. 2022 оны 6-р сарын 12, хээрийн судалгааны тэмдэглэлээс*

Овооны тахилгын дараа бэсрэг наадам болж, морь уралдах, сур харвах, бөх барилдах зэрэг үйл ажиллагаа болно. Тус хайрханг тахисны дараа үнэхээр байгаль дэлхий баярлан, хариу үзүүлсэн үү гэлтэй цас, бороо орж газрын гарц огцом нэмэгдсэн нь гайхшрлыг төрүүлж байв (2022 он, Архангай, хээрийн судалгааны тэмдэглэлээс).

Гэвч, сүүлийн үед орон нутагт нүүрсний болон алтны уурхай олноор ажиллахын сацуу, дөнгөж эхэлж буй ил уурхайнууд бороо хур оруулахгүйн тулд уул, овоотой холбоотой сонин хачин зүйлс хийх болсныг нутгийн ард иргэд дурдаж байв. Жишээ нь,

яагаад бороо орохгүй байгаа талаар, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Залаа уулыг бөө нар тахихдаа амьд хонь, амьд ямааг уулын оршил дээр булж тахьсан, тиймээс бороо орохгүй байгаа гэсэн тайлбарыг өгч байсан юм (2022 он, Баянхонгор, хээрийн судалгааны тэмдэглэлээс). Энэ нь бидэнд Дарханы замын бүтээн байгуулалт хур борооноос шалтгаалаад удаашрах шинжтэй болохоор уг замыг барьж байгаа хятад иргэд гахайн толгой булж, бороо хурыг буцаасан хэмээн нийгмийн сүлжээнд шуугисныг санагдуулж байсан юм.

Дэлхийн өнцөг булан бүрт овооны соёл байх агаад дотоод ази, тэр дундаа Монгол, Өвөрмонгол, Буриад, Халимаг, Тува, Зүүн Төвд, Чинхайд уул, толгодын орой гэх мэт өндөрлөг газар босгодог ч монголчуудын соёлд ихэвчлэн уул, хайрханыг хэлж газрын “эзэд”-тэй харилцах харилцааг зохицуулж байдаг (Charleux, 2021). Монголчууд хээр явж байхдаа овоотой дайралдах юм бол “Овооны эх нь танд, олзны их нь маньд” гэж хэлэн гурван чулууг газраас авч овоогоо нар зөв гурван удаа тойрохдоо өргөдөг. Энэ талаар “Эзэн, онгод, тэнгэрт зориулсан дархан цаазат газрыг бүтээхэд сүсэгтэн олон оролцоор байх болно” (Davaa-Ochir, 2008) гэж тэмдэглэн үлдээсэн байдаг ба Шарлу овоог Буддизмын суварга, мандалатай адилтган авч үзсэн боловч хэзээ ч бүрэн гүйцэт баригдаж дуусдаггүй хэмээн онцолжээ (Charleux, 2021). Энэ нь тухайн газар нутгийн эзэнтэй харьцах, хүндэтгэлийн харилцааны илрэл юм. Овоонд гурван ширхэг чулуу өргөж буй нь овоо болон газрын эзэн савдагтай зохих ёсоор харьцаж байгааг (Delaplace, 2021) харуулахаас гадна далдын хүчээр материаллаг болон материаллаг бус зүйлсийг системтэйгээр харилцан солилцож байх боломжтой (Smith, 2015). Жишээлбэл, чулуу, элс, мод гэх мэт материаллаг зүйлийг овоонд өргөснөөр хариуд нь материаллаг бус аз, хувь тавилан, эрч хүч, заяа гэх мэт зүйлсийг өөртөө хүсэж буй солилцоо болох боломжтой. Нэг ёсондоо монголчуудын овоо нь тус судалгааны ажлын нэгдүгээр бүлгийн нэгдүгээр хэсэгт бичсэн газрын эзэдтэй харилцах харилцааг зохицуулагч (gatekeeper) болж өгчээ.

Мөн овоог дуртай газраа босгодоггүйг Б.Батхишиг “Овоо нь газар доорх устай холбоотой. Монголчууд байгаль дэлхийгээ хайрлан, хамгаалж байгаа нь овоо. Овоог ухах юм бол усны ундарга байх нь их байдаг.” (2022 он, 05-р сар, Архангай, хээрийн судалгааны тэмдэглэлээс) гэж хэлсэн нь монголчуудын хүн-байгалийн харилцаа нь байгаль дэлхийгээ хайрлан хамгаалахтай шууд холбогдож байгааг харуулж байгаа юм. Монголчуудын байгаль хамгаалах уламжлалын талаар олон судлаачид судалж (У.Гонгоржав 2001, У.Эрдэнэтуяа 2009, О.Амархүү, 2000 Ц.Насанбалжир 1997,

Г.Цэрэнхад 2003), нэгдүгээрт, байгаль хамгаалахад тэнгэр, нар, сар, од эрхсийг шүтэх ёс, хоёрдугаарт, газар, усыг хамгаалах уламжлал, гуравдугаарт, ургамал, амьтныг хамгаалах уламжлал, дөрөвдүгээрт, хууль цаазын бичигт тулгуурласан байгаль хамгаалал зэрэг байдаг гэж дурджээ.

Монголчуудын байгаль дэлхийтэйгээ хэрхэн зохилдож, аж ахуйгаа хөтлөн явуулж, нутаг бэлчээрээ хамгаалж ирсэн талаар цухас авч үзвэл,

“Монгол нүүдэлчдийн үеэс үед улируулан хөгжүүлж ирсэн нэгэн ололт бол оршин зохицохуйн байгаль орчны тухай мэдлэг ухааны уламжлал билээ. Цаг хугацааны ихэнхийг малын дэргэд хөдөө хээр өнгөрөөдөг монголчууд нутаг нуга, газар усныхаа бичил уур амьсгал, ургамал, амьтны аймаг, хөрс шороо, ус ундны байрлал зэргийг танин ойлгож, хүн ба малд ямар нөлөөтэй болохыг ухаарч амьдралаа зохицуулж иржээ. Нүүдэлчдийн хувьд идээшин дассан нутаг бол амьдрах орчин болдог. Иймээс малчин хүн нутаглаж байгаа орчны тухайд малынхаа бэлчээрийг нэгтгэсэн хам ойлголттой байдаг” (Г.Цэрэнханд, 2005) .

Гэхдээ дан ганц мал аж ахуйгаас гадна ан амьтны байршил, тэдний шилжих, үймэх, таргалах, турах, үржлийн үеийг сайн мэдэж байснаараа ахуй амьдралдаа зохилдуулан хэрэглэдэг байжээ. Малчин нүүдэлчид хүнсний багагүй хэрэгцээг ан гөрөөгөөр хангадаг ч, тухайн ан амьтныг хүй элгэн үр төлтэй нь устган сүйтгэж, байгалийн унаган тэнцвэрийг алдагдуулж байгаагүй нь экологийн соёлын нэгэн илрэл бөгөөд энэ нь байгаль хамгаалах уламжлал болсоор иржээ.

Тийм ч учраас нутаг бэлчээрт хор хохирол учруулж болзошгүй зүйлсээс сэргэмжилж, төрийн бодлогын хэмжээнд авч үзэн хуульчилж өгдөг байсан нь “Алтан хааны цаазын бичиг”, “Халх журам” болон бусад хууль цаазын дурсгалуудад бий. Үүнчлэн, 1640 оны “Монгол Ойрадын хууль”-аар халиу, булга зэрэг үслэг анг хулгайгаар агнахыг, 1720 онд Их хүрээний ойр хавь газар ан гөрөө хийхийг хуулиар хориглон дархалж байж. Ерөөс XIII зуунаас XX зууны эхэн үед холбогдох бараг бүх хуулиудад байгаль хамгаалах асуудлыг их бага ямар нэгэн хэмжээгээр тусгаж ирснийг үзвэл төрийн бодлогын хэмжээнд уламжлагдан иржээ.

Б.Баттөмөр, Ц.Цэрэндорж нар “Хүнийг байгалийн бүтээгдэхүүн, биологийн нэг зүйл амьд махбодын хувьд экологийн үндсэн хуулиудад захирагдаж, байгальтай харьцахдаа экологийн хуулиудын болзол, шаардлагыг хангах ёстой гэсэн үзлийг үндэс

болгодог. Хүний хүрээлэн буй орчинд гарч байгаа сөрөг үзэгдлүүдийн ихэнх нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй бөгөөд шим мандлын өөрөө өөрийгөө зохицуулах, сэргээх үйл ажиллагааг эвдсэнтэй холбоотой” хэмээн хүнээс байгальд учруулж буй хор хөнөөлийн талаар дүгнэжээ. Монголчуудын хүн-байгалийн харилцаанд байгаль дэлхийгээ хайрлах, хамгаалах асуудал их байх агаад байгаль дэлхий унаган төрхөөрөө байж малчдын амьдрал хэвийн явагдах боложмтой гэж үзэх хандлага их байгаа нь хээрийн судалгаагаар ажиглагдсан. Жишээлбэл, Хөвсгөл аймгийн малчин өрх “Хотоос хүмүүс ирэх нь сайхан ч энд тэнд хог хаяад байгаль бохирдуулаад байх юм. Тэгэхээр чинь хурдан яваасай гэж л бодох юм.” (Хувийн тэмдэглэлээс) гэж хэлснээс үзэхэд хэдий хүмүүсийг зочломтгой зангаар угтаж авдаг монголчууд ч байгаль дэлхийгээ хайрлан, хамгаалдаггүй хүнийг таатайгаар хүлээж авдаггүйг харуулж байна. Өөрөөр хэлбэл, монголчуудын хүн-хүн хоорондын харилцааны үндэс нь хүн-байгаль хоорондын харилцаанаас үүдэлтэй, цаашлаад мал аж ахуй нь байгалиас шууд хамааралтай байдаг тул хүн-бэлчээр-мал гэсэн гурвалсан холбоон дээр бий болж, байгаль дэлхийгээ аргадан хайрлаж, тогтуун, байхыг хүсэх хүслээ овоогоор дамжуулж газрын эздэд хүргэдэг гэж хэлж болохоор байгаа юм.

## 1.5 Нутаг

*Хүн байгальтайгаа харилцахдаа газрын эзэд, савдагтай “овоо”-гоор холбогдож харилцдаг. Мөн малчин хүмүүс өөрсдийн малтайгаа тодорхой хэмжээнд харилцаж байдаг нь хээрийн судалгааны үеэр ажиглагдсаныг дээр бичсэн. Харин хүн-байгалийн харилцааг цогцоор нь харах боложмтой ухагдахуун бол хүн-нутаг хооронд үүсэж буй харилцаа юм. Монголчууд “унасан газар, угаасан ус” хэмээж нутагтайгаа хүйн холбоотой байдаг талаар эртнээс ярьж ирсэн хүмүүс юм. Иймд, энэхүү дэд бүлэгтээ хүн-нутаг хоорондын харилцааг бичив.*

Хүн-байгалийн харилцаанд унасан газар, угаасан ус буюу “нутаг” гэх ойлголт чухал байр суурь эзэлж байна. Хүн төрсөн нутагтайгаа ямар харилцаатай байдаг, тэр чинээгээр нутгаа хайрлах мэдрэмж үүсдэг (Д.Бум-Очир, 2017). Энэ талаар Архангай аймгийн Өндөр-Улаан сумын малчин эмэгтэй “Хүүхэд багадаа уяуулах нь зөв. Учир нь уяа бол хүүхдийг нутагтай нь холбож өгдөг хүй юм” (Жаргал, Архангай, 2022) гэж хэлснээс хүн байгальтайгаа хүйн холбоотой (эх-үрийн харилцаатай) байдгийг харуулж байгаа юм. Үүнээс гадна Архангай аймгийн Ихтамир сумд нэгэн айлаар зочлоход идэр насны хоёр эрэгтэй сууж байсан ба нэг нь “Ах нь онгоцны нисгэгч байсан. Хятад, Оросыг бүгдийг нь мэднэ. Гэхдээ төрсөн нутаг шиг сайхан газар гэж үгүй. Тэтгэвэртээ гараад



буцаад нутагтаа хүрээд ирлээ” гэж ярьж байснаас нутаг усаа санагалздаг, хайрладаг монгол хүний онцлогийг харуулж байлаа. (2022 оны 05-р сар, Хээрийн судалгааны тэмдэглэлээс) Харин Жан Пенроз 4 төрлийн агуулгыг “төрсөн нутаг” багтаадаг гэж үзжээ. Антропологич Д.Бум-Очир үүнийг Монголын нөхцөлд оруулан тайлбарласан байна. Үүнийг товчлон ойлгуулбал,

	<b>Жан Пенрозын аргумент</b>	<b>Д. Бум-Очирын тайлбар</b>
1	Байгалийн хууль ёсны бөгөөд хувиршгүйн тухай ойлголтууд [Conceptualizations of the legitimacy and immutability of nature]	Хүн байгалийн ёс, газрын хүчийг дагаж амьдарснаар гамшгаас зайлсхийж, хишгийг хүртэж байдаг
2	Нутагтайгаа холбогдох биеийн холбоо хамаарал [Natural physical bonding with homelands]	Хүй дарсан чулуугаар хүн төрсөн нутагтайгаа холбогдох [жишээ нь: Буриадын тоонот хадгалах ёс]
3	Хамаарал, мэдрэмж, дотно байдлын туршлага [Experience of attachment and feelings and belongs]	Монгол хүн унасан ус, угаасан газраа эргэж очин, хөрвөөх, шинээр мэндлэх мэт бие махбодоо сэргээх
4	Нутгийн тухай домог, дурсамж, түүх [History, memory and myth about the homeland]	Хэзээ, хаана, хэрхэн мэндэлснээ ахмад настан, ураг төрлийн хүмүүсээс сонсох, тэр тухайгаа дурсан ярилцах

*Хүснэгт 1.5.1 Жан Пенрозын “төрсөн нутаг”-т багтах агуулга ба Д.Бум-Очирын тайлбар*

Дээрх аргумент болоод тайлбараас үзэхэд нутаг гэх ойлголт нь хүн-байгалийн бүх төрлийн харилцааг багтаасан цогц ойлголт болж байна. Жишээлбэл, байгалийн ёс, газрын хүчийг дагаж амьдран гамшгаас үйлсхийж, хишгийг хүртэж байдаг гэх тайлбар нь зарим газрыг эзэн, савдагтай хэмээн шүтэж, хишиг хүсэх, сүү, цайныхаа дээжийг өргөн аргадах зан үйлтэй, хүй дарсан чулуугаар хүн төрсөн нутагтайгаа холбогдох гэх тайлбар нь ор, авдрын цоожоос уяуулсан хүүхэд төрсөн газартайгаа хүйн холбоотой болдог гэх итгэл үнэмшилтэй, монгол хүн унасан ус, угаасан газраа эргэж очин, хөрвөөх, шинээр мэндлэх мэт бие махбодоо сэргээх гэх ойлголт нь тэтгэвэртээ гарсны дараа төрсөн нутагтаа эргэж ирдэг жишээтэй, хэзээ, хаана, хэрхэн мэндэлснээ ахмад настан, ураг төрлийн хүсүүсээс сонсох, тэр тухайгаа дурсан ярилцах нь овооны тахилгын зан




үйлтэй холбогдож байна. Иймд, монгол хүний хувьд “нутаг” гэх ойлголтын цаана бүхэл бүтэн хүн-байгалийн харилцааны цогц систем байгааг харж болохоор байгаа юм.

## 1.6 Бүлгийн дүгнэлт

Мал аж ахуй эрхэлдэг ард түмний хувьд байгаль, дэлхий, цаг уурын нөхцөл байдал, газар зүйн байршил зэрэг нь малчдын өдөр тутмын амьдралд асар их нөлөө үзүүлж байдаг. Иймдээ ч монгол нүүдэлчдийн хувьд байгаль дэлхийгээ захиран удирдахаас илүүтэй дасан зохицож, аргадан хүндэтгэх, хамгаалах, хариуд нь аз, хувь тавилан, эрч хүч, хамгаалалт зэргийг хүсдэг сонирхолтой харилцаатай байна. Энэхүү харилцаа нь байгаль дэлхийг эзэнтэй гэж итгэх итгэл үнэмшил дээр тогтож тэрхүү эзэндээ сүү, цайныхаа дээжээр өргөл өргөх, овоо босгох, овоо тахилгын зан үйл үйлдэх зэргээр илэрч төрсөн нутаг гэх онцгой ойлголт дээр ирж зангилагдаж байна. Мөн монголчууд дан ганц өөрсдийн хүчээр амьдардаггүй, байгаль дэлхий, эзэн савдаг, малын заяа гэх мэт ойлголтуудад итгэж, тэдгээрийн харилцаан дээр үндэслэн оршин тогтнодог гэж үздэг байна.

Хэдий тийм боловч, XXI зууны хотжиж буй Монгол Улсад хүн-байгалийн харилцаа мартагдах, хотын соёлтой нь зохицохгүй байх зэрэг асуудлууд гарч байна. Харин XXI зуунд монголчуудын уламжлалт хүн-байгалийн харилцаа нь байгаль дэлхийгээ хайрлан, хамгаалах асуудал болж хувиран уламжлалт зан үйлийн хэлбэрээ байгаль хамгаалал гэх хэлбэрт оруулан өөрчилжээ.

Монголчуудын хүн-байгалийн харилцааг схемчлэн үзүүлвэл,



## ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮН-ХҮН ХООРОНДЫН ХАРИЛЦАА

*Нэгдүгээр бүлэгт хүн-байгалийн харилцааны талаар түлхүү бичсэн бол хоёрдугаар бүлэгт хүн-хүн хоорондын харилцааны уламжлал, түүнд гарч буй өөрчлөлтийг түлхүү бичихийг зорьлоо. Учир нь сүүлийн зуун жил монгол малчдын суурин газарт очиж амьдрах, суурьших (хотжих) үзэгдэл ихссэнээр монголчуудын уламжлалт хүн-хүн хоорондын харилцаанд эрс өөрчлөлт орж байна. Гэсэн хэдий ч зарим талаараа монголчуудын уламжлалт хүн-хүн хоорондын харилцааны элементууд өнөөдрийн хүн-хүн хоорондын харилцаанд шингэсэн байгаа нь хээрийн судалгаа хийж байхад харагдаж байсан юм. Иймд, энэхүү бүлгийнхээ 2.1 дэд бүлэгт монгол хүн-хүн хоорондын харилцааны гол үндэс болох “бэлгэ, бэлгэдэл”, түүнд гарч буй өөрчлөлтийн талаар хот, хөдөөгийн нөхцөл байдалд харьцуулан бичив.*

### **2.1 Монгол хүн бэлгээрээ**

Зохиолч Д.Намдагийн “Харааны хонхорт” жүжгийн зохиолоос сэдэвлэн бүтээсэн “Харуул занги” (1986) гэх монгол уран сайхны кинонд орос цэрэг Кузнецов “Танай төрийг дахин сэргэнэ ээ гэж үү?” гэж асуухад Цэрэнжав ноён “Монгол хүн бэлгээрээ, Хятад хүн бэнчингээрээ гэдэг” гэж хэлдэг. Угтаа “Монгол хүн бэлгээрээ” гэдэг нь аливаа юмыг бэлгэдэн, сайн сайхнаар тайлж, бие биенийхээ эрүүл мэнд, энх сайхныг асуун лавлаж мэндэлдэг сайхан харилцаатай (Х.Нямбуу, 1970) гэх санааг агуулж байна. Монгол нүүдэлчид эртнээс аливааг бэлгэдэн өөр хоорондоо харилцдаг байсан нь дан ганц кино болон уран зохиол гэлтгүй ардын аман зохиол, уртын дуу, тууль, магтаал, ерөөл, зүйр цэцэн үг зэргээс ажиглагддаг. Жишээлбэл тууль хайлсаны дараа хэлдэг магтаал шүлэгт,

Үхэлгүй мөнх  
Үгүйрэлгүй баянаар явж  
Дээрээс ноёлох ноёнгүй  
Дэргэдээс халдах дайсангүй  
Амар тайван суув

хэмээдэг нь аз жаргалтай амьдралаа магтан бэлгэдэхийг илэрхийлж байгаа юм (Х.Сампилдэндэв, 2004). Мөн монголчуудын мэндчилгээний харилцан яриа “Сайн байна уу?” гэхэд “Сайн, сайн”, “Сайхан, сайхан”, “Сайн явж байна” гэх мэтээр хариулдаг нь сайн, сайхныг бэлгэдэж буй бэлгэдлийн нэг хэлбэр болдог. Учир нь “Сайн байна уу?”

гэх мэндчилгээний гол үг болох “сайн” нь аливаа зүйлийн эерэг байдал, эв найртай, элэгсаг зан, мэнд амар, тайван, зовлон зүдгүүргүй гэх утгыг илэрхийлж байдаг. (Я.Цэвэл, 2021).

Хүн хоорондын харилцааны эхлэл, мэндчилгээ үгийн бэлгэдэл нь XXI зууны мэндчилгээнд ч хадгалагдан үлджээ. Жишээлбэл, Архангай аймгийн Борт багийн малчин Б.Наранцэцэг, “Малчид мэндлэхдээ “Сайн байна уу, тарган сайхан хаваржиж байна уу? Намаржиж байна уу? гээд л уламжлалт мэндчилгээгээ хийнэ шүү дээ. Тэгээд нутаг усаа их яриад, хуучилж эхлэнэ дээ.” (Б.Наранцэцэг, Архангай, 2022) гэсэн нь малчид өөрсдийгөө сайн, мууг мэдэхийн тулд дээрх асуултыг асууж буй байдал биш, харин сайн сайхныг бэлгэдэж буй бэлгэдлийг илэрхийлж буй нь харагдаж байна. Мөн Улаанбаатар хотод оршин суудаг Э.Батцэцэг, “Сайн байна уу? гэхэд “Өө юмгүй, юмгүй” гэдэг нь нэг л муухай. Ёозгүй.” (Э.Батцэцэг, Улаанбаатар, 2022) гэсэн нь “юмгүй” гэх үг нь аливааг үгүйсгэж, хоосныг илэрхийлж буй сөрөг утга илэрхийлж, бэлгэдлийн шинж байдлыг алдагдуулж байгааг харуулж байна. Дээрх харилцааны бэлгэдэл нь зөвхөн мэндчилгээн дээр байгаад зогсохгүй монгол хүн хоорондын харилцааны бүх хэлбэрт ажиглагддаг. Жишээлбэл Хөвсгөл аймгийн иргэн 67 настай Ц.Сайнноров, “Бид нар ер нь хүнийг ийшээ тийшээ явахад нь болгоомжтой яваарай гэж хэлдэггүй. Муу юм дуудаад байгаа юм шиг. Битгий тэгж хэлж бай.” (Ц.Сайнноров, Улаанбаатар, 2022) гэсэн нь монголчуудын зүйр цэцэн үг “Үгэн дотор үг, үхэр дотор гиваан” гэдгээр тайлбарлаж болохоор байна. Нэг ёсондоо “Болгоомжтой яваарай” гэдэг үгийн болгоомж гэдэг нь хичээнгүйлэн хянах, сэрэмж гэх сөрөг утгатай үг (Я.Цэвэл, 2021) болж, Сайнноровын үзэж буйгаар ямар нэгэн муу зүйлийг татдаг гэх санаатай болж байна. Үүнийг шог зураач С.Цогтбаяр шог зургаараа дараах байдлаар илэрхийлжээ.



Зураг 11. Stora-гийн ачааг саравчлан харж хүлээ! Сайн яваад ирэх болтугай. С.Цогтбаяр, 2022 он

Дээрх зураг нь Stora гэх гар утасны аппликейшний зар сурталчилгааны зураг юм. Энэхүү аппликейшнийг ашиглан гадаадаас бараа бүтээгдэхүүн худалдаж авах

боломжтой ба захиалсан бараагаа хүлээж буй хүнийг дүрсэлжээ. Зурагт дүрслэгдсэн эрэгтэй “Сайн яваад ирэх болтугай!” гэсэн байгаа нь хэлж буй этгээддээ (Stora-аас ирж буй ачаандаа) сайн сайхныг бэлгэдэж буй хэрэг юм.

Үүнээс гадна шог зураач С.Цогбаярын “Нус нь өтгөн, цус нь шигэн байгээ! (Орчин үеийн ерөөлийн үг)” гэх зурагт монгол нүүдэлчдийн харилцааны бэлгэдлийг өвгөн, хүү хоёроор илэрхийлсэн байна. Настай хүмүүс үр хүүхдээ загнахдаа “Цусыг чинь холиод, мөчийг чинь санжаад өгье!” гэж хэлдэг байсан бол энэхүү зурагт хүү нь “Өвөө жаахан хүнлэг бай л даа! Ядахдаа цусыг чинь шингэлье гээч!” хэмээж өвгөний үгийг засаж байна.



Зураг 12. Нус нь өтгөн, цус нь шингэн байгээ! (Орчин үеийн ерөөлийн үг). С.Цогбаяр, 2022 он

Хүүгийн хэлж буй “...ядахдаа цусыг чинь шингэлье гээч!” гэж хүний цус өтгөрснөөр эд, эрхтнүүд хүчилтөрөгчийн дутагдалд орж, үйл ажиллагааны алдагдалд орж эхэлдэг гэх анагаахын шинжлэх ухааны санааг гаргасан байна [Т.Хулан, 2022]. Энэхүү зургаас нэгдүгээрт, ерөнхий боловсролын эрүүл мэндийн хичээл сайн байгааг хоёрдугаарт, монголчуудын аливаа юмыг муугаар боддоггүй, мууг хүсдэггүй бэлгэдэлийн харилцаа харагдаж байна. Нэг ёсондоо “бэлгэдэл=хүнлэг байх” гэх ойлголтыг дээрх зураг шууд бус утгаар илэрхийлж байгаа юм..

Мөн Хөвсгөл аймгийн иргэн 67 настай Ц.Сайнноровын “Бид нар ер нь хүнийг ийшээ тийшээ явахад нь болгоомжтой яваарай гэж хэлдэггүй. Муу юм дуудаад байгаа юм шиг. Битгий тэгж хэлж бай.” гэдгээс “Болгоомж” гэх сөрөг утгат бэлгэдэлийн далд айдсыг сэтгэл судлалын плацебо эффектээр тайлбарлах боломжтой. Плацебо (placēbō) /I will please/ гэдэг нь “Би сэтгэл хангалуун байх болно” гэх латин хэлнээс гаралтай үг

[Buken, 2004] . Сэтгэл судлалын шинжлэх ухаанд аливаа хүн өвчин намдаах эм уугаад өвдөлт намдахад хоёр зүйл нөлөөлдөг гэж үзэж, нэгдүгээрт эмийн нөлөө хоёрдугаарт, өвчтөний “эм уучихсан, одоо зүгээр болно” гэх хүний тархины хариу урвал, сэтгэл зүйтэй холбоотой гэжээ (Buken, 2004). Мөн нөгөө талаас өвдөлт, зовиур нь ч плацебо эффекттэй холбоотой. Үүнийг Япон улсын судлаачид өвдөлтийг тархиндаа төсөөлснөөр тархинд өвдөлттэй холбоотой мэдээллийн сүлжээ бий болж тархины урд хэсэг болон баруун урд хэсэг хариу үйлдэл үзүүлж эхэлдэг байна [Yuichi Ogino, 2006]. Өөрөөр хэлбэл бодит байдал дээр ямар ч өвдөлт байхгүй байхад ч хүний сэтгэл зүйтэй холбоотойгоор өвдөлт мэдрэгдэх боломжтой байна. Энэ мэтчлэн монгол хүн хоорондын харилцаанд аливааг сайн, сайхнаар бэлгэдэх бэлгэдлийн шинж чанар байдгийг харилцааны хэлбэр гэж тайлбарлахаас гадна сэтгэл санаагаа амар тайван байлгах сэтгэл судлалын салбартай холбон тайлбарлаж болохоор байна.

Монголчуудын аливааг эерэг, сайнаар бодож, илэрхийлдэг нь нийгмийн бүхий л цаг үед байсан. Жишээлбэл Хонх хамтлагийн “Бидний араншин” хэмээх дуунд:

За найзуудаа, яриад байгаарай  
Яаж шуухан аж төрж байна даа  
Сайн сайн гэв үү, тийм тийм тийм  
Муугийн ёс биш Монголын ёс  
Сайхан уу гэвэл сайхан гэнэ ээ  
Муугийн ёс биш Монголын ёс

гэж гардаг нь “Монгол хүн бэлгээрээ” гэх зүйр цэцэн үгтэй шууд холбогдож байна. Учир нь Хонх хамтлагийн “Бидний араншин” дуу нь цаг төр ороо бусгаа байсан 1989 онд гарсан дуу. Уг хамтлагийн дуучин Д.Энхболд “Тэр үед хүмүүсийн ярьж болдог, болдоггүй сэдэв гэж байлаа. Тухайлбал, Чингисийн тухай дуулах нь битгий хэл ярих хүн цөөн байлаа. Социализмыг л магтан дуулаад байснаас бодит байдал дээр бүх зүйл тийм эерэг сайхан байгаагүй” [Д.Энхболд, 2014] гэж тухайн цаг үеийг дүрсэлжээ. Дээрх дуунд



Зураг 13. Хонх хамтлаг 1989 он.

Эх сурвалж: С.Амарсанаа, С.Майнбаяр. Монголын Ардчилсан холбооны түүхэн цомог.

“Сайхан уу гэвэл сайхан гэнэ ээ. Муугийн ёс биш Монголын ёс” гэсэн байгаа нь ямар ч ороо бусгаа, хэцүү цаг үед мууг хэлдэггүй, сайныг ерөөдөг монгол хүний харилцааг харуулжээ. МУСК “Харуул занги” дээр ч мөн ижил цаг төр ороо бусгаа байх үед Цэрэнжав ноён “Монгол хүн бэлгээрээ” гэж хэлсэн байдаг шиг монголчуудын дээрх бэлгэдлийн хэлбэр он цаг улирсан ч хадгалагдсаар ирсэн байна.

Монголчуудын хүн-хүн хоорондын харилцааг зохицуулагч бэлгэдэлд бэлэг солилцоо чухал нөлөө үзүүлдэг. Учир нь бэлэг нь эдийн засаг, шашин, улс төр, хууль эрх зүй зэрэг нийгмийн бүхий л хүрээг хамарсан цогц зүйл болохоос гадна бэлэг солилцож буй хүмүүсийн нэр төр, хүндэтгэл цаашлаад зан үйл, эд хөрөнгө, аврал ивээл гэх мэт харилцааг багтааж, дан ганц эдийн засгийн солилцоо бус хүмүүс хоорондын ёс зүйн харилцаа болдог (Д.Бум-Очир, 2012). Мөн бэлэг солилцоо нь хоёр хүн хоорондын харилцааг ойртуулж, дотно болгодог хүчин зүйл болохыг Улаанбаатар хотод явуулсан хээрийн судалгааны үеэр хэд хэдэн хүн дурдсан. Жишээлбэл Улаанбаатар хотод амьдардаг Марал “*Найздаа нэг удаа хоол авч өглөө гэхэд дараагийн удаа надад авч өгнө. Тэгээд би дараа нь авч өгнө, тэгээд дараа нь манай найз. Гэхдээ энэ нь бид хоёрыг дотно байгааг харуулж байгаа.*” (М.Марал, Улаанбаатар, 2022) Түүний ярьж буй “хоол” нь Моссын бэлэг солилцооны “бэлэг” байх боломжтой. Учир нь Маралын найздаа авч өгч буй “хоол” нь өнгөн дээрээ сайн дурын шинжтэй юм шиг боловч үнэндээ бол хүнээс шалтгаалдаггүй нийгмийн албадлагын зүйл болж байна. Өөрөөр хэлбэл, дээрх үйлдэл нь бэлэг өгөх, авах, хариу өгөх гэсэн гурван үйлдлээс бүрдэх бөгөөд энэ нь гурвуул зайлшгүй биелүүлэх ёстой нийгмийн шаардлага болж байгаа юм (Д.Бум-Очир, 2012). Мөн Марал болон түүний найзын бие биендээ хоол авч өгч буй нь тэднийг дотно байгааг илтгэх зүйл гэж хэлснээс хүн-хүн хоорондын харилцаанд гарч ирдэг бэлэг солилцоо нь хүн-хүн хоорондын харилцааг өдөөгч, бататгагч болж байна.

Монголчуудын хүн-хүн хоорондын харилцаанд чухал байр суурь эзэлдэг бэлэг солилцоо нь өнө эртний түүхтэй бөгөөд энэ талаар олон судлаачид судлахаас гадна түүхийн анхдагч эх сурвалжуудад гарч ирсэн байдаг. Жишээлбэл, Монголын Нууц Товчоонд:

“Тэмүжин Жамуха хоёр, Хорхонагийн хөндийд нийлэн бууж, эртний анд бололцсоноо дурсаж, улам дотно болж найралдъя гэлцэв. Анх урьд анд бололцоход Тэмүжин арван нэгэн настай байсан билээ. Тэр цагт Жамуха нэгэн гурын шагайг Тэмүжинд өгч, Тэмүжин нэгэн цутгамал шагайг Жамухад өгч, Ононы мөсөн дээр шагалцан наадаж анд бололцсон билээ.

Түүний хойд хавар алангир нумаар харваж байхад Жамуха, бярууны хоёр эврийг нааж нүхэлж хийсэн дуут сумаа Тэмүжинд өгч, Тэмүжин, арц модон годилоо Жамухад өгч анд бололцов. Хоёр удаа анд болоцсон ёс ийм билээ...” (Ц.Дамдинсүрэн, 1940)

гэж гардаг. Эрт цагийн анд барилдах ёс, найзууд хоорондын харилцаа бэлэг солилцоогоор эхэлж байхад эдүгээ ч гэсэн найзууд хоорондын харилцаанд бэлэг солилцоо чухал байр суурь эзэлж байна. Улаанбаатар хотод хийсэн хээрийн судалгааны үеэр ярилцлага өгсөн хүн тун сонирхолтой санаа хэлсэн нь “*Хэн нэгэнд бэлэг өгөхдөө намайг санагдуулдаг бэлэг өгдөг. Хол явсан ч миний өгсөн бэлгийг хараад намайг санадаг байхаар ч юм уу?*” (М.С, Улаанбаатар, 2022) юм. Нэг ёсондоо тухайн бэлэг нь бэлэг өгч буй хүнийг орлох биет болж хувирч байгаа юм. Үүнтэй ижил гадаад улс орон руу сурах, ажиллахаар явж буй хүмүүс хайртай, дотны нэгнийгээ санагдуулдаг юм авч явдаг аль эсвэл бэлгэнд авдаг. Өөрөөр хэлбэл бэлэг нь хүн-хүн хоорондын харилцааг ойртуулагч зүйл болж байна.

Бэлэг солилцох ёсонд нэгэн сонин зүйл ажиглагддаг нь бэлгэдлийн утга агуулга юм (Н.Бямбасүрэн, 2012). Монголчуудын бэлэг солилцохдоо өгч буй бэлэг нь тухайн бэлэг солилцож буй хүмүүс хоорондоо ямар харилцаатай гэдгийг шууд харуулж байдаг. Бэлгэнд Монголчуудын эрхэмлэх ёс, хүндэтгэл, бэлгэдэл, өнгө, тооны бэлгэдэл, ариун бузрын хорио цээр гээд бүх зүйл байдаг. Жишээлбэл, эрхэм хүндтэй хүндээ хадаг, сүү, халуун хошуут мал бэлэглэдэг бөгөөд үүнийг “Ашдын гурван бэлэг” хэмээдэг (Н.Бямбасүрэн, 2012) Хүн-хүн хоорондын харилцаа болоод түүнтэй холбоотой зан үйл, ёс заншил ихээр гарч ирдэг өдөр бол цагаан сар юм. Цагаан сарын баяраар нэг өрх дунджаар 780,000 төгрөгийг зөвхөн бэлэг авахад зарцуулдаг байна (Э.Болорхажид, 2020). Цагаан сарын бэлэг нь мөн ах дүү, хамаатан садангийн харилцаатай холбогдож байдаг, энэ талаар Э.Батцэцэг “*Цагаан сарын бэлгэнд хүнд хэрэгтэй, нөхцөл байдлаасаа хамаарсан бэлэг өгөх хэрэгтэй. Хөгшчүүлдээ бэлэг гэдэг утгаар өгөөд харин залуучуудад бол гар цайлгах байдлаар бэлэг өгдөг*” гэж хэлэв. (Э.Батцэцэг, Улаанбаатар, 2022) Мөн цагаан сарын бэлгээр юу авах дуртай гэж залуу хүмүүсээс асуухад “Бэлэг бэлгийн дээд бэлэн мөнгө” гэж ихэнх нь хариулж байв (Улаанбаатар хотод хийсэн хээрийн судалгааны тэмдэглэлээс). Өөрөөр хэлбэл, монголчуудын уламжлал харилцаанд байсан хадаг, сүү, халуун хошуут малын зах зээлийн үнэлэмж, үнэ буурч бэлэн мөнгө авах хүсэлтэй байгаа нь ажиглагдаж байгаа юм. Гэсэн хэдий ч бэлэг ямар ч хэлбэрээр байж



болох агаад хүн-хүн хоорондын харилцаанд нөлөөлдөг гол хүчин зүйл байсаар байгаа юм.

## **2.2 Хүн ахтай, дээл захтай**

*Монголчуудын хүн-хүн хоорондын харилцаанд хотжилт, суурьшмал амьдрал зэргээс үүдэн зарим зүйлс устаж үгүй болж байгаа ч бэлгэдэл, хүндлэл хэлбэрээ өөрчлөн байсаар байгаа нь хээрийн судалгааны үеэр ажиглагдсан юм. Ялангуяа хүн-хүн хоорондын харилцааг зохицуулагч зүйл бол “хүндлэл” юм. Монгол нүүдэлчид эртнээс “хүндлэл”-ийг улс төр, шашин, ёс суртахууны үүднээс үр хойчдоо заан сургаж ирсэн нь ийнхүү өнөөдрийг хүртэл хадгалагдсан иржээ. Иймд, тус дэд бүлэгтээ хүн-хүн хоорондын харилцааны хамгийн чухал зохицуулагч “хүндлэл”-ийн талаар бичлээ.*

Монгол хүн хоорондын харилцааны бас нэгэн чухал зүйл бол хүндлэл. Хүндлэл нь хүндлэх гэдэг үгийн нэр үг, “хүндтэйд үзэж ёс журмыг гүйцэтгэх” гэсэн утгатай юм (Я.Цэвэл, 2021). Хүндлэлийн жишээ үлгэр, домог, тууль, зүйр цэцэн үг, ардын аман зохиолд олон гардаг. Жишээлбэл “хүн ахтай, дээл захтай”, “ахаа алд хүндэл, дүүгээ дэлэм хүндэл”, “хүндлэх хөнгөлөх авир өөрийн зангаас, хүндлэгдэх хөнгөлөгдөх авир хүний зангаас” гэх мэт хүндлэлтэй холбоотой зүйр цэцэн үг олон байна. Үүнээс гадна харилцаж буй хүнээ хүндэтгэх нь монгол хүн хоорондын өдөр тутмын харилцаанд үргэлж байсаар ирсэн.

Хүндлэл нь үг болон биеийн хөдлөлөөр илэрдэг. Айлчин гийчинг гэртээ хүлээж авахдаа харуулдаг хүндлэх ёс байна. Үүний тулд хүндэтгэлийн үг ашиглах хэрэгтэй (Х.Нямбуу, 1970). Жишээлбэл ор суу гэхэд морилж айлд, суугаарай, суугаач; ид уу гэхэд зооглож айлд, идээрэй, уугаарай, тогтоочих; унтахад нойрсож айлд, нойрсогтун; босоход дээшилж айлд, дээшлэгтүн гэх мэтээр хүндлэн өгүүлэх үг байдаг (Х.Нямбуу, 1970). Энэ талаар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын малчин О.Алтангэрэл, “*Настай улсуудын хажууд өссөн хүүхдүүд нэг нэгнээ хүндлээд сайхан байна. Хүнтэй мэндлэхтээ таны бие сайн уу, бие тэнхээ данги уу гэж байх юм. Залуучууд чинь өө юу байна, юмгүй дээ л гэж мэндлээд байх юм*” (О.Алтангэрэл, Дорноговь, 2022) гэдгээс аливаа хүнтэй мэндэлж, харилцан яриа эхлүүлэх үг хэллэг нь цаанаа хүндлэлийн утга агуулгатай байдаг нь харагдаж байна. Мөн тэрээр, “*1980-аад оноос хойш хүүхдүүд хүнийг хүндлээд сайхан хүмүүжилтэй болж байна*” (О.Алтангэрэл, Дорноговь, 2022) гэж хэлсэн ба хүндлэлийг хувь хүний хүмүүжилтэй холбож, ахмад хүмүүсийг хүндэлдэг хүмүүс бол хүмүүжилтэй байдаг гэх монголчуудын дунд байдаг яриаг баталж өгчээ. Айлд зочлох, айлчин гийчнийг угтан авах талаар Дэвид Снийт “*Айлчин гийчид зочилж буй айлынхаа*

найз, хамаатан садан, аль эсвэл огт танихгүй хүмүүс ч байж болно. Ямар ч хүн ирэхэд гэрийн эзэн айлчин, гийчинг хүндэлж цайгаар дайлж, хэрэгтэй бол гэртээ хонуулж болно. Тэглээ гээд хариуд нь заавал айлчин гийчнийхээ гэрт дараа нь очиж зочлох ёстой гэсэн юм байхгүй” гэж тайлбарласан байдаг (Sneath, 2019).

Монголчуудын харилцааны чухал элемент болох хүндлэлийг барууны онолын өнцгөөс тайлбарлахад учир дутагдалтай бүрэн гүйцэт тайлбарлах боломжгүй байдаг нь монгол хүн-хүн хоорондын харилцааны явцад гарч ирдэг хүндлэл нь өөрийн гэсэн онцлогтой гэдгийг баталж байдаг. Жишээлбэл, Вебер “Эдийн засаг ба нийгэм” гэх бүтээлдээ нийгэмд эзлэх байр суурь нь хүндлэлтэй холбогдож байдаг (Weber, 1978), Симмел хувь хүн ба нийгмийн ашиг сонирхол нэгдсэн тохиолдолд хүндлэл бий болдог (Simmel, 1905), Бурдьё нэр хүнд хүндлэлийг дагуулж байдаг (Bourdieu, 2008) гэж тайлбарласан байдаг. Монголчуудын хүн-хүн хоорондын харилцааны чухал элемент болох хүндлэлийг дээрх барууны сор болсон эрдэмтдийн тайлбараар тодорхой хэмжээнд тайлбарлаж болох ч бүрэн гүйцэт тайлбарлах боломжгүй. Учир нь Улаанбаатар хотод хээрийн судалгаа хийх явцад авсан ярилцлагад “Хэн нэгнийг эрхэлж буй ажил, яаж явж буйгаар нь хараад харьцаж болохгүй. Бид бүх хүнийг адил тэгш хүндлэх ёстой” (Ц.Сайнноров, Улаанбаатар, 2022) гэж хэлж байсан нь монголчуудын хүн-хүний хоорондын харилцаанд гарч ирдэг хүндлэлд нэр хүнд, нийгэмд эзлэх байр суурь зэрэг нь тийм ч чухал биш гэх санааг гаргаж байна.

Мөн хүндлэл нь үг хэлээр илрэхээс гадна үйлдлээр илэрдэг. Жишээлбэл аян замд хүнтэй дайралдахдаа зөв талаараа зөрж, тэр талынхаа хөлийг дөрөөнөөсөө мултлан мэнд мэдэж өнгөрөөдөг бол ах хүн дайралдвал заавал бууж мэндлэх хэрэгтэй (Х.Нямбуу, 1970). Үүнийг Ү.Ядамсүрэнгийн “Нөхөрлөл” гэх 1967 онд зурсан зургаас харж болно.



Зураг 14. "Нөхөрлөл" Ү.Ядамсүрэн, 1967 он. Эх сурвалж: Монгол уран зургийн галлерейн сан хөмрөг



Зураг 15. Архангай аймагт замд төөрсөн тул нутгийн малчинтай уулзаж буй замчин. Хээрийн судалгааны тэмдэглэлээс. хөмрөг

Хэдий тус зураг нь социализмын үеийн үзэл суртлын агууламжтай байгаа ч залуу эр, өөрөөсөө нас ахимаг эрд тамхийг нь асааж хүндлэл үзүүлж буй дүр дүрслэл байна. Нөхөрлөл гэх үгнээс партизан болон жирийн ард иргэдийн нөхөрлөлийг илэрхийлж буй мэтээр тайлбарлаж болох ч хүндлэл нь өөрөө нөхөрлөлийг бий болгодог зүйл тул тус зураг нь монгол хүн хоорондын харилцааг тун нарийнаар гаргасан зураг байна. Архангай аймагт хийсэн хээрийн судалгаагаар малчид морь унахаа больж, мотоцикл унах нь олон болсон ч хоёр хүн хээр зөрөхдөө мотоциклоо зогсоож мэндлэх, мотоциклоосоо буун мэндлэх, мотоциклоосоо бууж газар суун хуучлах нь олон харагдсан. Энэ нь дээрх нөхөрлөл гэх зургийн залуухан эрэгтэй, настай эрэгтэй хоёрын дүрслэлийн орчин үеийн хувилбар мэтээр тайлбарлаж болохоор байна (2022, 06-р сар Архангай, хээрийн судалгааны тэмдэглэлээс).

Мөн айл гэрт орохдоо зүүн талд бол зөв талын хөлөө нугалж, солгой талын хөлөө босгон суудаг бол баруун талд бол баруун хөлөө босгон, зүүнээ нугалж суудаг байна (Х.Нямбуу, 1970). Энэ талаар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын малчин О.Алтангэрэл *“Залуу хүүхдүүд их завилж суудаг болж. Эмэгтэй залуу хүмүүс хүртэлж цөм завилж суух юм. Намайг бага, залуу байхад настай хүний хажууд завилж суухыг их цээрлэдэг байсан. Ер нь л эмэгтэйчүүд завилж суудаггүй. Эмэгтэй хүний суудлаар суудаг. Нэг хөлөө нугалаад...”* (О.Алтангэрэл, Дорноговь, 2022) гэж хуучилсан нь монголчуудын айл гэрт ороод хүндлэл үзүүлэх уламжлалт харилцааг илэрхийлж байна.


Айл гэрт ороод зүүн аль эсвэл баруун талын хөлөө нугалж, солгой аль эсвэл баруун хөлөө босгон суудаг биеийн хөдлөлийг 1981 онд Ардын зураач Б.Чогсом *“Малчны гэрт”* гэх зурагтаа буулгажээ. Тус зурагт гэрийн баруун талд буй эрэгтэй баруун хөлөө босгон, зүүнээ нугалж суусан бол зүүн талд буй эрэгтэй зүүн талын хөлөө босгон баруун талын хөлөө нугалж суусан байна.



Зураг 16. "Малчны гэрт" Б.Чогсом, 1981 он. Эх сурвалж:  
Монголын уран зургийн галлерейн сан хөмрөг

Монгол гэр дотор хаана сууж байгаа болоод айлчин гийчнийг хаана суулгаж байгаагаас шалтгаалж, хүн-хүн хоорондын харилцаан дах хүндлэл, монголчуудын зочломтгой занг харж болдог. Энэ талаар Кембрижийн их сургуулийн антропологийн профессор Давид Снийтийн өгүүлэлд тодорхой өгүүлсэн байдаг (Sneath, 2019). Тэрээр монгол гэрийн баруун талд айлчин гийчин (хүйс үл хамаарна), зүүн талд айлын эзэгтэй нар байрладаг бол хойморт гэрийн эзэн аль эсвэл хүндтэй хүн суудаг гэжээ (Sneath, 2019). Хүндтэй хүмүүст лам, багш, нийгмийн статусаараа айлын эзнээс дээр хүмүүс (Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гэх мэт) аль эсвэл гэрийн эзний хүндэлдэг хүмүүс суудаг байна. Энэхүү хүмүүсийн гэр дотор суудаг байрлал нь Хөх нуурын дээд монголчуудын хүн-хүн хоорондын харилцаанд ч ижил байдаг (Bum-Ochir, 2006). Өөрөөр хэлбэл, нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг монголчуудын хүн-хүн хоорондын харилцаанд чухал нөлөө үзүүлдэг хүндлэл, түүний нэг болох гэр доторх байрлалаар хүмүүсийн харилцаа тодорхойлогдож байдаг нь он удаан жилийн түүхтэйгээс гадна өнөөдрийг хүртэл монголчуудын дунд хадгалагдаж үлдсэн байгааг харуулж байгаа юм. Харин XXI зууны хотжсон нийгэмд монгол улсын хүн ам орон сууц, байшин руу шилжин суурьшиж байна. Иймд монгол гэрийн бүтэц, дугуй гэр дотор суух хүмүүсийн эрэмбэ дараалал, байршил зэрэгт өөрчлөлт орж байна. Мөн байшин, орон сууцад амьдарснаар ширээ, сандал орж

ирэн дээр дурдсан хөлөө ачин суух ёс бараг мартагджээ. Улаанбаатар хотод оршин суудаг Ө.Баярбатын 2022 оны цагаан сарын баярын ширээн дээр жишээ авч үзвэл,



Зураг 17. Ө.Баярбатын 2022 оны Цагаан сарын баярын ширээ.  
2022 оны 2-р сар

Ө.Баярбатын гэрийн хаалга нь ертөнцийн зүгээр баруун зүг рүү харсан нь монгол гэрийн хаалгаа урагшаа харуулсан байдаг ёсыг эвдэж, гэрийн хоймор буюу хойд зүгт хүндтэй хүн суулгадаг ёс алдагдахад хүргэж байгаа юм. Харин Ө.Баярбатын гэр бүл хүндтэй нэгнийг хаалганаас хамгийн хол байрлах газар суулгаж, хаалганы эсрэг талыг хоймор хэмээн үзэж байна. Нэг ёсондоо монгол гэрийн бүтэц, дөрвөлжин байшин, орон сууцад тохируулж хэлбэрээ өөрчилсөн ч утга агуулга, ёс заншлаа хадгалан үлджээ.

Б.Чогсомын “Малчны гэрт” гэх зурагт айлчин гийчдэд зориулж тавгийн идээ тавьсан нь шууд харагдаж байна. Үүнээс өрөм нь зочин гийчдийг ирэхэд хүндлэн угтдаг идээний дээж болдог. Идээний таваг дүүрэн байх нь зочид гийчдийг хүндэлж буйг илэрхийлэх ба энэ талаар Улаанбаатар хотод оршин суудаг Э.Батцэцэг, “Зочин ирэхэд тавгийн идээ хоосон байж болохгүй. Ямар бүгдийг нь ид гээд байгаа биш дээ. Энэ чинь зүгээр сайхан угтаж авч байгаа хэрэг шүү дээ. Тэр хүн нэгийг иднэ үү, хоёрыг иднэ үү,



*ер хамаагүй. Гол нь тавгаа дүүргэж тавих ёстой”* (Э.Батцэцэг, Улаанбаатар, 2022) гэж хэлсэн нь монголчуудын айлчин, гийчинг угтан авахдаа харуулдаг хүндлэлийг харуулж буй хэрэг юм. Э.Батцэцэгийн хувьд тавгийн идээгээ дүүргэж тавих нь чухал байхад Архангай аймгийн малчдын хувьд айлчин гийчин ирэхэд тавгийн идээгээ дүүргэж тавих нь чухал байдаг. Энэ талаар Архангай аймгийн Өндөр-Улаан, Ихтамир сумдад хээрийн судалгаа хийж явж байхад *“Хотынхон цагаан идээ огт тавидаггүй юм байна лээ. Ховор харагдсан”* гэж хэлж байгаа малчин эмэгтэйчүүд олон дайралдаж байв (2022 он, хээрийн судалгааны тэмдэглэлээс). Малчин эмэгтэйчүүдийн хувьд хамгийн хүндтэй идээ бол цагаан идээ тул айлчин гийчинг цагаан идээгээр дайлдаг. Харин хотод амьдарч буй хүмүүсийн хувьд цагаан идээ олох хэцүү, үнэ өртгийн хувьд үнэтэй байдаг тул өөрийн боломжоороо айлчин, гийчдийг дайлдаг байна. Хэдий монголчуудын айлчин, гийчинг угтах ёсонд өөрчлөлт ороогүй гэж хэлж болохоор байгаа ч түүний гадаад хэлбэрт тодорхой хэмжээний өөрчлөлт орсоор байна.

Дээрх санааг дэлгэрүүлбэл, айлчин гийчинг ирэхэд нь дайлдаг сүүтэй цай бол монголчуудын хүн-байгаль гэлтгүй хүн-хүн хоорондын харилцаанд хүндлэлийг илтгэж буй чухал элемент. Цай бол хүн төдийгүй байгаль дэлхийн эздийн хоорондын харилцааны хэрэгсэл. Хэрэв айл өрх зочиндоо аяга цай барихгүй бол, (ийм зүйл тохиолдох ёсгүй) түүнийг хүлээж авахыг хүсэхгүй байгаагаа илтгэж буй нь ойлгомжтой. Өнөө үед монгол соёлын бүрэлдүүлбэр зарим зүйлс ихээхэн өөрчлөгдөж байгаагийн нэгэнд цайны (хоолны) соёл орж байна. Архангай аймгийн Ихтамир сумынхны хувьд сарлагийн цагаан идээг боловсруулж, эдийн засгийн гол бүтээгдэхүүн болгосон учраас төдий чинээгээр зочин гийчнийг дайлах нь элбэг байв (2022 он, Архангай, хээрийн судалгааны тэмдэглэлээс). Энд, сарлагийн өрөм, ааруул, шимийн архи, боорцог зэргийг айл болгон тавьж, идэж уухаар “шахах”, бэлэглэх жишээтэй. Бас тэд сарлагийн өрмийг нүдсэн борцтойгоо хольж, тогоондоо хуураад шөлтэй хоол хийж өгч байсан нь нүүдэлчин монголчуудын зочломтгой зан, хол газар яваа хүмүүсийг илүү ихээр дайлж цайлдаг ёсыг харуулж байлаа. Гэвч, энэ нутгийнхны хамгийн үнэтэй идээ болох “сүүн хурууд”-аа зочдод хараахан бэлэглэхгүй, бусад идээг бол бэлэглэж байсан нь эдийн засагтай нарийн холбоотой юм.

Харин Баянхонгор аймгийн Баянговь, Шинэжинст сумдад айл өрхүүд төдийлөн идээ тавихгүй, зарим айл зөвхөн хүйтэн цай, зарим айл цайгүйгээр ямааны ааруул тавих зэргээр зочлох ёс нь илт өөрчлөгдсөнийг харуулж байв. Энэ нь тэдний байгалийн бэрхшээлийг даван туулж, ямаагаа арайхийн авч үлдээд, эдийн засгийнх нь гол эх сурвалж байнгын ган, зудад өртөж байгаагаас болсон уу гэлтэй байлаа (2022 он, хээрийн судалгааны тэмдэглэлээс). Өөрөөр хэлбэл, малчин хүний сэтгэл санаа талбиун тогтуун байвал өөр бусадтай харилцахдаа төдий чинээ зочломтгой, нийтэч, харин санаа зовних зүйл ихтэй бол тийм биш байна гэж үзэж болохоор харьцуулалтыг Архангай болон Баянхонгор аймагт хийсэн юм (2022 он, хээрийн судалгааны тэмдэглэлээс).



Зураг 18, 19. Архангай аймгийн Ихтамир, Өндөр-Улаан сумдад хийсэн хээрийн судалгааны үеэр малчдын айлчин, гийчдэд зориулж тавьсан тавгийн идээ. 2022 оны 6-р сар.

Нөгөө талаар, зочлох ёсыг хадгалж буй хэмээн бидний төсөөлж байсан малчдын хувьд ч бүх зүйлийг зарах, худалдах, солилцох, нэг үгээр ашиг олох тал руу нэлээд хандаж буйг дурдаж, үүнд зах зээлийн эдийн засгийн тогтолцоо, эдийн засгийн хямрал зэрэг нөлөөлж буйг дурдаж, цаашдаа энэ талаас харж, судлах нь зүйтэй.

### 2.3 Бүлгийн дүгнэлт

Монголчуудын хүн-хүн хоорондын харилцаа бэлгэдэл, хүндлэлтэй холбоотой үг хэллэг, үйл хөдлөл, ёс заншил, зан үйлээр илэрч байдаг. Тэр дотроос “бэлгэдэл”, “хүндлэл” хоёр нь өдөр тутам хийгээд баяр ёслол гэх мэт бүхий л үед хүн-хүн хоорондын харилцааг зохицуулагч хамгийн чухал зүйл болохыг олон эрдэмтэн, судлаачид мөн хээрийн судалгааны үеэр ярилцлага хийсэн хүмүүс онцолж байв. XXI зуунд өрнөж буй даяаршил, хотжилт зэрэг нь хүн-хүн хоорондын харилцааны гадаад хэлбэрт өөрчлөлт оруулж байгаа ч дотоод агуулгын хувьд хуучин уламжлалыг ор тас үгүй хийж, өөр болгоогүйг тус бүлгийн дэд бүлгүүдэд дэлгэрэнгүй бичиж, хээрийн судалгааны ярилцлага, анхдагч, хоёрдогч эх сурвалжуудаар батлахыг оролдлоо. Жишээлбэл, монголчуудын мэндчилгээ болон жирийн харилцаанд илэрдэг сайн, сайхныг бэлгэддэг бэлгэдлийн ёс нь эдүгээ дуу хөгжим, кино урлаг, уран зургийн төрөл зүйл зэрэгт гарч ирж байгаа нь өнөөдрийг хүртэл бэлгэдэл хүн-хүн хоорондын харилцаанд нөлөө үзүүлсээр байгааг харуулж байгаа хэрэг юм. Мөн ахас, дээдсээ хүндлэх ёс дугуй гэрээс дөрвөлжин байшинд шилжихдээ хэрхэн өөрчлөгдсөнийг Ө.Баярбатын цагаан сарын баярын ширээгээр харууллаа. Энэ мэтчлэн монголчуудын хүн-хүн хоорондын харилцааг зохицуулагч хамгийн чухал хоёр зүйл болох “бэлгэдэл”, “хүндлэл” нь XXI зуунд амьдарч буй монгол хүмүүсийн өдөр тутмын амьдралд ч байгаа нь монголчууд өөрсдийн онцлог, өвөрмөц байдлаа хадгалсаар байгааг харуулж байна.



## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### ХҮН-ТЕХНОЛОГИЙН ХАРИЛЦАА

*1990-ээд онд интернет хүн төрөлхтний амьдралд орж ирсэн нь хүн-технологийн харилцаа гэх шинэ харилцааг бий болгосон юм. 1990-ээд оноос хойш 40 жилийн турш техник, технологи, хиймэл оюун ухааны асар хурдан хөгжлийн үр дүнд өнөөдөр дэлхийн нийт хүн амын дийнлэнх хувь нь өдөр тутамдаа интернетийг ашиглаж, өөрсдийн амьдралд зарим талаараа эерэг, мөн зарим талаараа сөрөг зүйлсийг авчирчээ. Энэхүү бүлгээрээ “хүн-технологи” гэх шинэ харилцааг судлахдаа техник, төхөөрөмж гэхээсээ илүүтэй “интернет”-ийг ашиглаж түүгээр дамжуулан хэрхэн хүн-хүн, хүн-байгаль хоорондын харилцаа зохицож буйг харуулахыг зорьлоо.*

#### **3.1 Цахим үндэстэн**

2022 оны 06-р сарын 08-ны байдлаар олон улсад мэдээллийн аюулгүй байдлын шинжээч, программ хангамж, хөгжүүлэгч гэх мэргэжлүүд хамгийн эрэлттэй 10 мэргэжилд орсон байгаа бол монголд системийн аюулгүй байдал, хиймэл оюун ухаан (Artificial Intelligence), утасгүй холбоо, өгөгдлийн ухаан, нано шинжлэх ухаан, нано инженерчлэл гэх мэт мэргэжлүүд хамгийн эрэлттэй мэргэжилд оржээ (Өдрийн сонин, 2022). Үүнээс XXI зуун бол техник, технологи, хиймэл оюун ухааны эрин үе болохыг шууд харж болохоор байна. Дэлхийн нийт хүн ам 2022 оны 11-р сард 8 тэрбумд хүрэх гэж байгаа талаар Нэгдсэн Үндэстний Байгууллага мэдээллэжээ (Bureau, 2022). Дэлхий хүн амын 66.9% буюу 5.03 тэрбум хүн интернет хэрэглэгч, 59% болох 4.7 тэрбум хүн идэвхтэй сошиал медиа платформ ашиглагч (World, 2022) байна. Өдөр ирэх тусам интернет хэрэглэгч болоод сошиал медиа платформ ашиглагчдын тоо нэмэгдэж байгаа бөгөөд өдөрт 48 минутын дотор 9.6 тэрбум мейл илгээгдэж, 10 тэрбум ам.доллар цахим тоглоомын гүйлгээ хийгдэж, 191 сая компьютер үйлдвэрлэгдэж, 65 сая хүн шинээр интернет хэрэглэгч болж байна (Worldometer, 2022).

Иймд, дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн, “Цахим үндэстэн” болох зорилгыг дараах бодлогын баримт бичигтээ тусгажээ. Үүнд:

- 2021 онд Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”,
- Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх замаар эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилт

Дээрх бодлогын баримт бичгийн хүрээнд дижитал дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдал, тоон бичиг үсгийн чадавх, инновац үйлдвэрлэл, үндэсний хөгжлийн хурдасгуур гэсэн стратегийн зургаан том төлөвлөгөөг баталсан юм. Цахим үндэстэн болох уриалгын дор хэрэгжүүлсэн хамгийн том ажил бол E-Mongolia төрийн үйлчилгээний систем юм. Тус систем нь 58 байгууллагын 606 үйлчилгээнээс гадна 8 аймгийн 498 үйлчилгээг цахимжуулж, нэгтгээд байна. Монгол Улсын 1.9 сая иргэн давхардсан тоогоор 6 сая гаруй үйлчилгээг цахимаар авч, 64.5 тэрбум төгрөгийг хэмнэсэн бөгөөд төлбөртэй үйлчилгээнээс улсын төсөвт 4.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Энэ талаар судалгаанд хамрагдсан залуус *“E-Mongolia амар шүү дээ. Заавал цаг, энергиэ заран байж нэг цонхны үйлчилгээнд очих шаардлагагүй, бүх юмаа гар утаснаасаа шууд хийх боломжтой. Цаг хугацаа ч хэмнэнэ. Мөнгө ч хэмнэнэ”* гэж ярьж байв (2022 он, 10-р сар, хээрийн судалгааны тэмдэглэлээс). E-Mongolia-г ажиллагаанд оруулсны дараа төслийн баг гарч тус системийг хэрхэн ажилладаг талаар олон нийтэд заавар, зөвлөгөө өгөх төвөө Төв шуудангийн нэг давхарын танхимд нээснээр бүх насны хүмүүс E-Mongolia ашиглах боломжтой болсон нь тус аппликейшныг олон нийтэд илүү хурдан түгэхэд дөхөм болжээ. Өөрөөр хэлбэл, хэдхэн жилийн өмнө хүний хийдэг байсан ажлыг технологи орлох болсон юм.

E-Mongolia-гийн талаар ихэнх хүмүүс сайн амтай байгаа боловч олны дунд E-Mongolia-г ашиглахад бэрхшээлтэй, хэцүү гэж хэлэх хүмүүс ч бас байна. Улаанбаатар хотод оршин суудаг өндөр настан иргэн Ц.Сайнноров *“E-Mongolia ашиглах гэхээр яаж ашиглахаа мэдэхгүй юм. Хүүхдүүд байж л ашиглана”* (Ц.Сайнноров, Улаанбаатар, 10-р сар), Монгол Японы төвийн номын сангаар үйлчлүүлдэг уншигч *“E-Mongolia-г ашиглаж эхэлснээс хойш бүх бичиг баримт нэхээд байх юм. Хуучин ингэдэггүй л байсан”* (Хувийн тэмдэглэлээс) гэх мэт сөрөг хандлага ажиглагдаж байгаа юм. Гэвч энэ нь хүний ажлыг технологи булааж авсанаас үүдэн гарсан сөрөг сэтгэгдэл бус тус системийг ашиглаж чадахгүй байх аль эсвэл бичиг баримт гаргаж өгөхөөс залхуурсан гэх мэт хувь хүнээс шалтгаалсан сөрөг хандлагууд байгаа юм. Үүнээс гадна, монгол улсын хувьд бүх аймаг, сум, багуудад интернет сүлжээ нэвтрээгүйгээс шалтгаалж, E-Mongolia болон бусад интернет сүлжээг ашиглаж чадахгүй байгаа хүмүүс байсаар байна. Жишээлбэл, Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Азарга багт хээрийн судалгаа хийж байх явцад малчин хүү Жалцан *“Интернет ормоор л байдаг ч манай энэ хавьд сүлжээ байхгүй. Тэгэхээр төв орохоороо л интернет орно”* гэж хэлж байв (2022 он, Архангай, хээрийн судалгааны тэмдэглэлээс). Хэрэв E-Mongolia-г монголын бүх иргэд хэрэглэдэг болвол

нэг талаас, олон хүмүүс цаг хэмнэж, гар дороосоо төрийн үйлчилгээг авах боломжтой болох боловч түүнийгээ дагаад олон хүмүүс ажлын байргүй хоцрохыг үгүйсгэхгүй.

Монголын Засгийн газар цахим үндэстэн болох уриалгыг гаргаснаас хойш олон төрийн болон төрийн бус үйлчилгээ цахимжсан. Түүний нэг бол гандангийн ном уншуулах үйлчилгээ юм. Миний бие, 1998 оны бар жилээр төрсөн бөгөөд 2022 онд бар



Зураг 20. 2022 оны 02 сард гар утсанд маань “Мөр гаргах” гэх дугаараас ирсэн мессеж  
Зураг 21. 2022 онд төв гандантэгчлэнгийн цахим хуудаснаас онлайнгаар уншуулсан номын талаар ирсэн мессеж

жил орж ном уншуулах шаардлагатай болоход цахимаар ном уншуулах боломжтойг мэдсэн. Иймд цаг хэмнэх, хүйтэнд гадуур алхахгүйн тулд төв гандангийн цахим хуудас руу орж, өөрт тохирох номын жагсаалтаас хэд хэдийг сонгож, цахим банкны үйлчилгээ ашиглан номын төлбөрөө төлж, цахимаар уншуулсан. Өөрөөр хэлбэл, гандан явж оочирлох, ламтай уулзах, төлбөр төлөх гэх мэт бүхий л үйлдлийг 20 минутын дотор хийж байгаа юм. Мөн гандан явахад замд дайралдаж болох байсан хүмүүстэй дайралдахгүй байх, гандан дээр очоод лам нартай уулзаж, өөрийн талаар ярих, төлбөр төлөхдөө төлбөр авч буй хүнтэй ярих гэх мэт хүн-хүн хоорондын харилцаанд үүсэж болох байсан бүх харилцаа байхгүй болсон юм. Энэ нь дээрх хүн-хүн хоорондын харилцаа нь хүн-технологийн харилцаагаар тэр чигтээ орлогдож байгаа бодит процесс болно.

Энэ талаар залуу хүмүүст хэлэхэд “цаг хэмнэсэн, амар болж” гэх мэт хариу үйлдэл үзүүлж байсан бол настай хүмүүст хэлэхэд “номыг ингэж уншуулахгүй ээ, уншсан болохгүй, заавал ганданд оч” гэх мэт хариу үйлдэл үзүүлж байсан юм (Хувийн тэмдэглэлээс, 2022 он). Гэсэн хэдий ч хоёрдугаар бүлэгт дурдсан плацебо эффектийн

дагуу ном уншуулсан хүн өөрөө сэтгэл хангалуун байж чадвал, хүн-хүний харилцааг хүн-технологийн харилцаа орлоход асуудал гарахгүй гэж бодогдоно.

Үүнээс гадна хүн-байгалийн харилцааг ч технологи орлож байгаа жишээ сүүлийн жилүүдэд гарч байна. Хүн-байгалийн харилцааг, хүн-технологийн харилцаагаар орлуулсан төсөл бол “Шамбала-2056” төсөл юм. Уг төсөл нь Дорноговь аймагт хэрэгжиж байгаа бөгөөд говийн цөлжилтийг бууруулах зорилготой. Хүмүүс цахимаар модны мөнгө шилжүүлснээр өөрийн нэр дээр модтой болох тухайн модныхоо ургаж буй мэдээллийг цаг тутамд утсан дээрээ авах боломжтой болж байна. Сүүлийн жилүүдэд монгол орон дах бэлчээрийн доройтол, цөлжилт улам бүр нэмэгдэж байгаа талаар олон судлаачид судалсан байдаг бөгөөд олон улсын хөгжлийн байгууллагууд болоод дотоодын төрийн болон төрийн бус байгууллагууд байгаль орчныг хайрлан, хамгаалах асуудал дээр анхаарах болжээ. Иймд, хүмүүсийг идэвхтэй хамруулж, тогтмол санхүү босгох арга бол цахимаар мод тарих аяныг эхлүүлэх байсан юм. Монголчууд *“нэг мод тарьвал нэг насны буян хурааж байна”* гэж ярих тохиолдол ч бий (Хувийн тэмдэглэлээс). Иймд Шамбала-2056 төсөл нь монголчуудын байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, хариуд нь аз, хийморь, эрч хүчийг хүсэх хүн-байгалийн харилцааг орлож өгчээ. Тус төсөл нь 2020 оноос эхлэн 36 жилийн хугацаанд үргэлжлэх урт хугацааны төлөвлөгөөтэй төсөл.

Хүн-технологийн харилцааг улам гүнзгийрүүлж, ихэсгэсэн нь 2019 оноос эхлэн дэлхий дахинаа тархсан ковид цар тахал юм. Цар тахлын нөлөөгөөр 2020 оноос эхлэн дэлхий дахинаа хөл хорио хоёр жилийн хугацаанд тогтоосон. Энэ хугацаанд бүх зүйл цахимжиж, хүмүүсийн интернет болоод социал медиагийн хэрэглээ огцом өссөн юм. Жишээлбэл, Монгол Улсын Их Сургуулийн ахисан түвшний хичээлүүд болох магистр, докторын хичээл бүрэн цахимжсан. Ингэснээр багш-оюутны хооронд үүсдэг байсан харилцаа багш-компьютер, оюутан-компьютерийн харилцаа болон өөрчлөгдсөн юм. Энэ талаар оюутан, багш нараас ярилцлага авахад янз бүрийн санал, сэтгэгдэлтэй байгаа нь ажиглагдсан. Жишээлбэл, бакалаврын түвшний оюутнуудын зүгээс *“Онлайнаар орохоор юу ч сурдаггүй. Багшдаа нүдүүлж байж хичээлээ хийдэг шүү дээ”*, *“Онлайн худлаа. Юу ч сурахгүй”* гэх мэт оюутан-багш нарын харилцааг илүүд үзсэн байдал ажиглагдаж байхад ахисан түвшний суралцагчид *“Онлайнаар үзсэн нь илүү дээр. Ажлын хажуугаар сургууль руу явахаар ажил ч алаад, хичээлдээ ч сууж чадахгүй юм”*, *“Гадаадаас хичээл авах боломжтой болсон”* гэж хэлцгээж байв (Хээрийн судалгааны тэмдэглэлээс, 2022 он 10-р сар). Харин Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн багш *“Онлайнаар орох хоёр талтай. Эерэг тал нь гэвэл Эрдэнэтэд суралцдаг оюутнуудад заавал биеэр*

*очихгүйгээр хичээл орох боломжтой. Сөрөг тал нь гэвэл оюутнууд юм сурахгүй юм”* гэж хэлж байв (Э.Батцэцэг, Улаанбаатар, 2022 он). Нэг ёсондоо хэдэн зуун жилийн турш танхимаар хичээллэж, хүн-хүн хоорондын харилцаа үүсгэж ирсэн багш-шавийн харилцаа нь тийм ч амархан хүн-технологийн харилцаа руу шилжихгүй байгаа юм. Гэсэн хэдий ч дан ганц их, дээд сургуулиудын хичээл, сургалтыг гэлтгүй өөрийн хүссэн зүйлээ үнэ төлбөргүйгээр өөрийн төрөлх хэл болоод бусад гадаад хэл дээр үзэх боломж өдрөөс өдөрт нэмэгдсээр байгаа юм. Монголын анхны танхимаар хичээллэж эхэлсэн сургууль XX зууны эхэнд Архангай аймгийн Ихтамир сумд байгуулагдаж байсан бол зуухан жилийн дараа нийгмийн өөрчлөлт, хөгжил, цар тахал зэргээс болж, буцаад гэрийн сургууль хүмүүсийн сонголт болох болжээ.

Техник, технологи нь зөвхөн интернет, ухаалаг гар утсаар зогсохгүй бидний өдөр тутмын амьдралын алхам тутамд нөлөөлж байна. Жишээлбэл 1921 онд байгуулагдсан, эдүгээ Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт байрладаг Улсын Их Дэлгүүр нэг болон долдугаар давхартаа автомат касс байрлуулснаар хүмүүс худалдагчтай кассаар үйлчлүүлэхээс илүүтэй, автомат кассаар үйлчлүүлж буй нь ажиглагдсан. 2022 оны 10-р сарын 12-ны өдөр 1 цагийн турш их дэлгүүрийн нэг болон долдугаар давхарт ажиглалт хийсний үр дүнгээр насны хувьд залуухан, бага хэмжээний худалдан авалт хийсэн хүмүүс автомат кассаар үйлчлүүлж буй нь ажиглагдсан. Автомат касс ашиглаж буй хүмүүсийн нэг болох 20 орчим насны залуугаас ярилцлага авахад *“Автомат касс нь оочир багатай, хэрэглэхэд хялбар байдаг. 10-аас доош бараатай хүмүүс л үйлчлүүлдэг болохоор хурдан шуурхай”* (Б.Төгсбуян, Улаанбаатар, 2022) гэж хэлснээс харахад автомат касс нь яарч буй хүмүүс болоод бага худалдан авалт хийсэн хүмүүсийн хувьд хүн-хүний харилцаа үүсгэн “уламжлалт” кассаар үйлчлүүлснээс давуу талтай байгааг харуулж байна. Улсын Их Дэлгүүрийн адил Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг томоохон супермаркетуудын нэг болох И-Мартын “уламжлалт”, хүн-хүний харилцаа үүсгэдэг кассаар үйлчлүүлж буй хүмүүсийг 30 минутын турш ажиглалт хийхэд нэг хүнд зарцуулж буй цаг нь Улаанбаатар Их Дэлгүүрийн автомат кассаар үйлчлүүлж буй хүмүүсийн цагаас ойролцоогоор 4-9 минутаар удаан байсан юм (Улаанбаатарт хийсэн хээрийн судалгааны тэмдэглэлээс, 10-р сар). Нэг ёсондоо, автомат касс хүмүүсийн хэрэглээнд нэвтэрснээр бидний өдөр тутамдаа үйлчлүүлдэг дэлгүүрт үүсдэг хүн-хүний харилцаа байхгүй болох эрсдэлтэй юм.

Үүнээс гадна, хүмүүсийн чөлөөт цагаа өнгөрөөж, найз нөхөд, гэр бүлтэйгээ харилцдаг харилцаанд техник технологийн хөгжил дэвшил асар том өөрчлөлт оруулж байна. 2020 онд гарсан цар тахлын нөлөөгөөр хөл хорио тогтоож, улс даяар

өндөржүүлсэн бэлэн байдалтай байсан. Энэ үед үзвэр, үйлчилгээний газрууд үйлчлүүлэгчдэд үйлчлэх боломжгүй болж, кино үзвэр, соёл, урлагийн тоглолт, нэвтрүүлгүүд цахим хэлбэрт шилжсэн. Жишээлбэл, Өргөө кино театр хөл хорио дуустал үйл ажиллагаа явуулаагүй тул кино сонирхогчид цахимаар кино үзэх болсон. Үүнийгээ дагаад кино, контент бүтээгчид өөрсдийн бүтээлээ онлайнаар, үнэ төлбөртэйгээр тавьж эхэлсэн. Кино, контент бүтээгчдийн хувьд кино театрт кино бүтээлээ гаргахаас илүүтэй цахим орчинд тавих нь илүү их ашигтай байдаг талаар ярьж байв (Өнөрзул, Улаанбатар, 2022). Мөн Фантастик продакшны уран бүтээлчид Өргөө кино театрт киногоо тавихад орлогынх нь 50%-ийг Өргөө кино театр авдаг талаар гомдоллож байсан. Хүмүүсийн хамгийн их хэрэглэдэг кино платформ бол Netflix юм. Netflix дээр нэг ангит болон цуврал кинонууд байрладаг бөгөөд англи, франц, япон гэх мэт хадмалтай тул гадаад хэл сурж буй хүмүүсийн хувьд ч хэлээ сайжруулах боломж нь болж байна.

Дээрхээс гадна, дотоод, гадаадын олон уулзалт, семинар, хурлуудыг цахимаар хийх болжээ. Энэ нь нэгдүгээрт, санхүүгийн хувьд хэмнэлттэй, хоёрдугаарт хүмүүс дуртай газраасаа, хүссэн үедээ оролцох боломжтой, гуравдугаарт олон хүнийг хамруулах боломжтой юм. Дотоод, гадаадын уулзалт, семинар, хурлыг цахимаар зохион байгуулах нь 2022 оны 04-р сарын 29-ний өдөр батлагдсан Монгол Улсын Төрийн хэмнэлтийн тухай хуультай шууд холбогдох юм. Энэхүү хуулийн зорилт нь,

*Энэ хуулийн зорилт нь төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.*

Өөрөөр хэлбэл, гадаад, дотоодын зардал болон зарим худалдан авалтыг хязгаарласан байдал болоод албан байгууллагуудыг ил тод байхыг уриалсан дээрх хууль нь хүн-хүн байгалийн харилцааг улам багасгаж, хүн-технологийн харилцааг нэмэгдүүлэх төрийн зүгээс авч хэрэгжүүлж буй бодлогын нэг болж өгчээ. Бас нэгэн өөр жишээ авч үзвэл, жил бүр Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулдаг Японд суралцах талаар мэдээллийн яармагийн 12 дахь удаагийн яармаг нь 2021 онд коронавирусын улмаас цахимаар зохион байгуулагдсан. Коронавирус цар тахал, хөл хорионы өмнө дээрх яармаг нь Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв дээр японы 10 гаруй их, дээд сургуулийн төлөөлөгчид, Япон Улсаас Монгол Улсад суугаа элчин сайдын яам, ЖАССО төлөөлөгчид зэрэг биеэр хүрэлцэн ирж, оюутнууд газар дээр нь уулзаж, мэдээлэл авдаг байсан бол 2021 онд цахимаар болсноор дээрх

гадаадын төлөөлөгчид ирэх боломжгүй болж, хүрэлцэн ирэхийг хүссэн хүмүүс нь ч цахимаар оролцох шаардлагатай тулгарсан юм. Гэсэн хэдий ч дээрх мэдээллийн яармагийг цахимаар зохиох нь зарим талаараа аль, аль талдаа ашигтай байсан юм. Учир нь Японоос ирж буй их, дээд сургуулиуд болон бусад албан ёсны төлөөлөгчид онгоцны тийз, монголд ирээд байрлах буудлын мөнгө болоод бусад зардлыг гаргах хэрэггүй болсноос гадна дан ганц Улаанбаатар хотод байдаг оюутан, залуус оролцдог байсан бол 2021 оны мэдээллийн яармаг, “цахим мэдээллийн яармаг” нэрийн дор зохион байгуулагдснаар 21 аймгаас олон залуус оролцох боломж нь бүрдсэн юм. Энэ талаар тус яармагт орсон залуусын ихэнх нь сэтгэл хангалуун байгаа талаараа дурдсан (Хувийн тэмдэглэлээс).

Энэ мэтчлэн монголчуудын хүн-хүн, хүн-байгалийн харилцаа болоод ертөнцийг үзэх үзэл зэрэгт техник, технологи асар их нөлөө үзүүлж буй нь бүх салбарт ажиглагдаж байгаа юм.

### **3.2 Фэйсбүүкээр явуулчих аа!**

*“Цахим үндэстэн” болох зорилгын хүрээнд төрийн болон хувийн хэргээ цахимаар бүтээх явдал ихссэн байна. Саяхныг хүртэл иргэний үнэмлэхээ биедээ авч явдаг байсан бол өнөөдөр E-Mongolia-аас иргэний үнэмлэхний цахим хувилбараараа ажлаа бүтээх нь олон болж. Монголчуудын цахимжиж буй үйл явц дан ганц E-Mongolia-аар бус бусад сошиал медиа платформуур явж байна. Монголчуудын албан болон хувийн хэрэгтээ хамгийн их ашигладаг сошиал медиа платформ бол фэйсбүүк (Facebook) юм. Зарим төрийн болон төрийн бус хэвшлийнхэн бичиг баримт, бусад ажил хэрэгтэй холбоотой материалуудаа фэйсбүүкээр бие биедээ явуулж буй нь фэйсбүүк монголчуудын хүн-хүн хоорондын харилцааг зохицуулагч болсон гэхэд хэлсдэхгүй байна. Иймд энэхүү дэд бүлэгтээ фэйсбүүк монголчуудын хүн-хүн хоорондын харилцаанд хэрхэн нөлөөлж буйг харуулахыг зорьлоо.*

Цахим монголын хүрээнд хамгийн их ашиглагдаж буй сошиал медиа платформ бол фэйсбүүк юм. Фэйсбүүкээр монголчууд найз нөхөд, гэр бүл, хамаатан садан, ахан дүүстэйгээ холбогдохоос гадна төрийн болоод төрийн бус байгууллагын ажил ч явагддагийг нуухгүй. “Монголд ажил бүтээхийн тулд фэйсбүүктэй байх ёстой”, “Ангийхантайгаа харьцахын тулд фэйсбүүк нээсэн”, “Шинэ мэдээлэл авахын тулд фэйсбүүк нээсэн” гэж ярьж байгаа хүмүүс Улаанбаатарт хийсэн хээрийн судалгааны

үеэр хэд хэд тааралдаж байв (Улаанбаатар хотод хийсэн хээрийн судалгааны тэмдэглэлээс).

Жишээлбэл, Улаанбаатар хотод хийсэн ярилцлагын үеэр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Мэдээлэл, холбоо, технологийн ахлах багш Э.Батцэцэг “Оюутнуудад мэдээлэл тараах гээд тэнхимийнхээ гадаа цаас гаргаж наах, оюутнуудын веб дээр мэдээ тавих, сургуулийн сайтан дээр байршуулахаас илүү, фэйсбүүк дээр мэдээ, мэдээлэл тавих нь хурдан байдаг” (Э.Батцэцэг, Улаанбаатар, 2022) гэж хэлж буйгаас үзэхэд фэйсбүүк нь монголчуудын мэдээлэл авах гол хэрэгсэл яахын аргагүй мөн болжээ. Гэхдээ нөгөөтэйгүүр, багш, ажилчид фэйсбүүкийг илүүд үзэж, бүх мэдээллээ фэйсбүүкээр дамжуулж тавьж буй нь оюутнуудыг фэйсбүүк ашиглахгүй байхын аргагүйд хүргэж байгаа тохиолдол ч байна. Монгол Улсын Их Сургуулийн Геологийн ангийн оюутан Г.Хулан “Би фэйсбүүк хэрэглэмээргүй л байдаг. Гэхдээ багш бүх мэдээллээ фэйсбүүк дээр тавихаар яалт ч үгүй фэйсбүүк хэрэглэхээс өөр арга алга. Төгсөхөөрөө устгах гэж байгаа” (Г.Хулан, Улаанбаатар, 2022) гэж хэлж байсан нь дээрх асуудал нь хоёр талтай байгааг харуулж байгаа юм.

Үүнээс гадна ямар нэгэн ажлын шугамын асуудлыг хүртэл фэйсбүүкээр хийж буй нь монголчуудын цахим орчин дах харилцааны онцлог болжээ. Угтаа фэйсбүүк гэдэг нь хүний хувийн аккаунт бөгөөд ажлын шугамын ямар ч зүйл хийхгүй байсан ч асуудал үүсгэхгүй байх ёстой байдаг. Гэтэл Т.Болормаа өөрийн хувийн фэйсбүүк хаягтаа найзуудтайгаа ажлын бус цагаар зугаалж буй зураг хийсний дараа захирал нь ажлаа хийхгүй, зугаалаад байгаа мэт сэтгэгдэл бичсэнд “Захирлаасаа ихэд, айж, зургаа устгахад хүрсэн” гэж хэлж байв (Хувийн тэмдэглэлээс). Үүнээс үзэхэд фэйсбүүкийг албаны хэрэглээнд ашиглах нь элбэгшиж, хувь хүний хувийн орон зайд халдаж буй хэрэг болж байна. Фэйсбүүкийн албан хэрэглээнд ашиглаж буйг фэйсбүүк хэрэглэгчид шүүмжилж дараах зургийг байршуулсан байна.

Би танруу бичиг баримтаа  
имэйлээр явуулчих уу?  
Төрийн албаны аниа: пээсбүүкээр  
явуулчих, ягаан цэцэгтэй зурагтай  
хаяг байгаа.

Зураг 22. Өөрийн фэйсбүүкээс скриншот хийж авсан зураг. 2022 оны 10-р сар.



Дээрх зургаас харахад төрийн албаны ажил хэрэг фэйсбүүкээр явагдаж буйг фэйсбүүк хэрэглэгчид шүүмжилжээ. Мөн дээрээс нь төрийн албаны аниа гэдгээс төрийн албанд ихэвчлэн эмэгтэй хүмүүс бичиг, хэргийн ажил хийдэг мөн ягаан цэцэгтэй зурагтай байдаг гэдгээс тэдгээр аниа нар нүүр зураг дээрээ ягаан цэцэгтэй зураг аль эсвэл байгалийн зураг тавьдаг гэх стереотайпыг харуулжээ.

Монголчууд өөрөөсөө ахмад хүмүүсийг аниа, эгч гэж хүндлэн дууддаг. Тэгвэл сүүлийн жилүүдэд женерашион гап (generation gap) буюу хүмүүсийг нас, насаар нь ялган ангилж, тэдгээр нас, насны хүмүүс хоорондын харилцаанд үл ойлголцол гарах нь их байна. Жишээлбэл, фэйсбүүкийг ажил хэрэг, хувийн амьдралдаа тогтмол ашигладаг хүмүүс бүүмэрс үеийхэн (Boomers), X үеийхний ангилалд багтаадаг бол инстаграм ашигладаг хүмүүсийг Z үеийхэнд багтаах хандлагатай байна (*Улаанбаатар хотод хийсэн хээрийн судалгааны тэмдэглэлээс, 10-р сар*). Бүүмэрс үеийхэн бол 1946-1964 оны хооронд төрсөн хүмүүсийг хэлэх бол X үеийхэн нь 1965-1980 онд төрсөн хүмүүсийг хэлнэ. Харин Z үеийхэн бол 1996 оноос 2010 онд төрсөн хүмүүс байдаг. Энэхүү үечлэлийг АНУ болон барууны нийгмийн судлаачид гаргасан бол өнөөдөр дээрх нас, насны хоорондын харилцаа фэйсбүүк, инстаграм зэрэг социал медиагаас болж асуудалтай, үл ойлголцол ихтэй байгаа нь ажиглагдаж байна.

Учир нь социал медиа ашиглахын давуу тал нь дэлгэцний цаанаас хэн, юу гэж бичиж байгаа мэдэгдэхгүй давуу талтай. Гэсэн хэдий ч монголчуудын уламжлалт хүн-хүн хоорондын харилцаанд байх бэлгэдэл, хүндлэлийн асуудал алга болох юм. Учир нь дэлгэцийн цаана хэдэн настай, ямар хүн байгааг мэдэхгүй тул тухайн хүнийг хүндлэх, аливааг бэлгэдэн сайн сайхныг хүсэх шаардлагагүй болох юм. Энэ ч утгаараа ямар нэгэн сөрөг мэдээний дор олон хүмүүс сөрөг сэтгэгдэл бичих агаад тэдний нэгийг арван дөрвөн настай хүүхэд, аль эсвэл тавь гарсан хүн гэдгийг тааварлашгүй. Өөрөөр хэлбэл, цахим орчин, социал медиа гэдэг нь хүн-хүн хоорондын харилцаанд хана үүсгэж, монголчуудын уламжлалт хүн-хүн хоорондын харилцаа үүсгэх боломжийг нь бүрэн хаах тохиолдол гарч байна.

Хүн болгон янз бүр байх агаад сүүлийн жилүүдэд сэтгэл судлалын салбар их хөгжсөнөөр хүмүүсийн темпраментийг янз бүрээр тодорхойлж экстриверт буюу гадагшаа, интроверт буюу дотогшоо хүмүүс гэж ангилжээ. Иймд цахим сүлжээ, онлайн

платформ, социал медиа хөгжсөн өнөө цаг үед интроверт хүмүүс олон хүнтэй харилцахгүйгээр амьдралаа залгуулах, сурч боловсрох боломжтой болж байна. Нэг талаасаа давуу талтай байгаа хэдий ч интроверт хүмүүс өөрсдийгөө дөрвөн хананы дунд түгжиж, нийгмийн харилцаанаас бүр мөсөн холдуулж байгаа юм. Энэ талаар япон судлаачид ихээхэн судалдаг ба японы нийгэмд их хотын ганцаардал гэх зүйл нийгмийн хамгийн том асуудлуудын нэг болж байгаа юм. Монгол ч мөн ижил хотжих, техник, технологи хөгжих зэргээс шалтгаалж их хотын ганцаардал үүсэж буйг Өнөржаргал дурдсан (Өнөржаргал, Улаанбаатар, 2022). Нэг ёсондоо монголчуудын хүн-хүн хоорондын харилцаа, зочломтгой зан зэрэг нь их хотын ганцаардлын улмаас зарим хүмүүсийн дунд огт байхгүй байгааг бид анхаарч үзэх хэрэгтэй байна.

Хэдий фэйсбүүк, инстаграм нь олон хүмүүст янз бүрийн боломж, бололцоог нээж өгч байгаа ч нийгмийн зарим хүмүүст дотогшоогоо бүгэх, нийгмээс тасрахад нөлөөлж буйг анхаарч үзэх хэрэгтэй.

### **3.4 Монгол цахим гэр бүл**

*Эдүгээ хот, хөдөө гэлтгүй бүх хүн ухаалаг гар утас ашиглаж, интернет орчинд өөрийн хүссэн медиа платформоо ашиглах бүрэн боломжтой болжээ. Үүний нэг жишээ бол 10, 20 жилийн өмнө гадаад, дотоодод гэр орноосоо хол сурж, ажиллахаар явсан нэгэн гэрийхэнтэйгээ харилцахдаа захиа, шуудан, аль эсвэл хааяа нэг утсаар, интернетээр (ховор тохиолдолд) харилцаж, мэнд усаа мэддэг байсан бол өнөөдөр өөрийн дуртай цагтаа, дуртай үедээ гэр бүлтэйгээ нүүр, нүүрээ харан ярилцах, харилцаа үүсгэх боломжтой болсон байна. Энэ талаар “Одоо ч амар болждээ. Ингээд л хол байгаа ач охидуудаа хараад” (Ц.Сайнноров, Улаанбаатар, 2022) гэж Улаанбаатар хотод оршин суудаг Ц.Сайнноров ярилцлагын үеэр хэлж байв. Иймд, Интернет, социал медиа, цахим орчин нь монгол гэр бүлд хэрхэн эерэг болон сөрөг нөлөө үзүүлж буйг тус дэд бүлэгтээ тодруулахыг зорьлоо.*

Цахим ертөнц, цахим орчин, цахим хичээл, цахим сургууль, цахим золголт, цахимаар мөнгө олох гэх мэт сүүлийн жилүүдэд “цахим” гэх үг бүх үгтэй хоршин хэрэглэгдэх болжээ. 2019 онд гарсан коронавируст цар тахлын улмаас “хүн-хүн” хоорондын харилцаа “хүн-хүн хоорондын цахим” харилцаа болж нэгэнтээ өөрчлөгджээ. Техник, технологи хүн-хүн хоорондын харилцааг орлуулах хэрэгсэл болох талаар 1990-ээд оноос эхлэн олон эрдэмтэн, судлаачид таамаглал дэвшүүлж байсны нэг бол Ховард Рейнголд юм. Тэрээр өөрийн “Virtual Community” гэх бүтээлдээ интернет гэх шинэ технологи нийгмийг шинэ бүтцэд оруулна гэх санааг дэвшүүлж байжээ (Rheingold, 1995).

Түүний дараа япон судлаач Ёшида интернет орчин хүмүүс хоорондын харилцааг идэвхжүүлж, нийгмийн харилцааны шинэ дэгийг бий болгоно (吉田純, 2000) гэсэн бол АНУ-ын сэтгэл судлаачид “интернет парадокс” гэх ойлголтыг дэвшүүлж, интернетийн хэрэглээ нь гэр бүлийн харилцаа болоод нийгэм дэх хүн-хүн хоорондын харилцааг багасгаад зогсохгүй, хүнийг ганцаардалд оруулах, нийгмээс тусгаарлах аюултай (Patterson, Lundmark, Kiesler, Mukopadhyay, & Scherlis, 1998) гэжээ. Харин социал медиагийн талаар судалсан судалгаанд социал медиаг “шууд холбогч”, “гүүр буюу дамжлагатайгаар холбох”, “харилцааг хэвээр хадгалалт”-ын үүрэгтэй байдаг гэжээ (Ellison, 2008). Энэ мэтчлэн олон улсад интернет хэрэглээ гарж эхлэхтэй зэрэгцэн нийгэм дэх хүн-хүн хоорондын харилцаанд интернет хэрхэн нөлөөлөх талаар олон орны, янз бүрийн салбарын судлаачид өөрсдийн судалгааны үр дүнд тулгуурласан таамаглал дэвшүүлж байжээ. Дээрх тодорхойлолтуудын хүрээнд өнөөгийн монгол гэр бүлийн харилцаан дахь цахим хэрэглээг тодорхойлох бүрэн боломжтой. Учир нь хээрийн судалгааны явцад зарим хүмүүс социал медиа нь гэр бүлийг холбож өгдөг, зарим нь социал медиа хүмүүсийн харилцааг үгүй хийж байна гэх мэт олон янзын өнцгөөс тайлбарлаж байсан юм (2022 он, хээрийн судалгааны тэмдгэлэлээс).

Техник, технологийн хөгжил, даяаршлын үр дүнд гэр орноосоо хол газар очиж, сурах, ажиллах хэрэгцээ зарим гэр бүлд гарч байна. Жишээлбэл, Ц.Сайнноровын 6 хүүхдээс 3 нь гадаадад амьдран суудаг бол Монголд байдаг гурван хүүхэд нь хот, суурин газар оршин суудаг байна. Ц.Сайнноров гэртээ ганцаараа амьдардаг ба үр хүүхдүүдтэйгээ харилцахыг хүсвэл өөрийн ухаалаг гар утсаараа холбогдож, яридаг талаараа дурдаж байв (2022 он, хээрийн судалгааны тэмдгэлэлээс). Тэрээр дан ганц үр хүүхэдтэйгээ гэлтгүй найз нөхөд, хуучин ажлын хамт олон, хамаатан садантайгаа интернетээр холбогдож ярьдаг гэж байв (2022 он, хээрийн судалгааны тэмдгэлэлээс). Ц.Сайнноров “Хол газар байсан ч хөөрхөн хүүхдүүдээ хараад уулзсан юм шиг л болдог” (2022 он, хээрийн судалгааны тэмдгэлэлээс) гэж хэлж байсан нь Эллисоны 2008 онд бичсэн өгүүлэл дэх социал медиагийн “шууд холбогч” хэмээх үүргийг гүйцэтгэж байгаа юм. Үүнийг сэтгүүлч Паттон “...компьюетэр суурьтай зуучлалын харилцаа холбоо дэлхий дахиныг холбох болно. Цемент зам болон агаарын замаар холбогдож чадаагүй харилцаа холбоо цахимаар явж, дэлхийн өнцөг булан бүрийг салгахгүй...” (Patton, 1986) хэмээн 1986 онд бичиж үлдээжээ. Хөдөө орон нутагт судалгаа хийх явцад судалгаанд оролцож байсан айлын хүүхдүүд миний хувийн социал медиа хаягийг авч, хотод ирсний дараа видео колл хийж байсан нь бидний харилцааг хэдэн зуун километрийн цаанаас ч

холдуулаагүй юм (2022, Хээрийн судалгааны тэмдэглэлээс). Энэ мэтчлэн айл гэрийн гишүүн бүр цахим ертөнцөд өөрсдийн гэсэн хаягтай болох нь хүн хоорондын харилцааг таслахгүй, холдуулахгүй мөн улам дотно болгож буй мэдрэмж төрүүлж байна.

Харин зарим тохиолдолд гэр бүлийн гишүүд хэт цахим ертөнцөд орох нь эсрэгээрээ гэр бүлийн харилцааг хүйтэн хөндий болгох үндэс болох тохиолдол ч байна. Жишээлбэл, Улаанбаатар хотод хийсэн хээрийн судалгаагаар гэр бүлийн гишүүд утсаа оролдоод л суудаг, хоорондын харилцаа гэж үгүй, хүүхэд том болох тусмаа ярихаа больж, утсаа үзэх нь элбэг гэх мэт зүйлсийг ярьж байв (2022, Улаанбаатар, Хээрийн судалгааны тэмдэглэлээс). Үүнийг Мичиган мужийн их сургуулийн доктор Кейт Хамптон, “...гэр бүлийн гишүүд цөөн байх тусам интернет харилцаа холбоо, мэдээлэл, зугаа цэнгэл өгдөг хэрэгсэл болох нь их” (Hampton, 2003) гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн гишүүдийн тоо бага байх тусам гэр бүлд ярилцаж, шийдвэрлэх асуудал харьцангуй бага байж, хувийн цаг их гарах нь их байдаг байна. Мөн тэрээр, хүмүүсийн биелэн ярилцах, харилцах нь цахим харилцаа руу шилжиж буй тул олон нийтийн харилцаа суларч байгаа гэх санааг дэвшүүлэхээс гадна газарзүйн байршлаас үл хамааран хоорондоо харилцаж буй нь заавал биечлэн уулзах гэсэн хүслийг багасгаж, хүмүүс илүү хувь хүнлэг (individualistic) болдог гэж үзэж байна (Hampton, 2003). Өөрөөр хэлбэл, хүүхдийнхээ сургуулийн социал бүлэгт байдаг эцэг эх, хүүхддээ хичээл, сургууль дээр нь юу болсон талаар цаг алдахгүйгээр мэдэж, харин гэртээ хариад хүүхэдтэйгээ ярилцах нь багасах юм. Коронавируст цар тахлын үеийн хөл хориогоор цахим ертөнцөд “Гэр бүлийн гишүүдтэйгээ ярьж үзлээ. Овоо дажгүй хүмүүс байсан байна” гэх мэт хошин яриа түгэж байсан нь хөл хорионоос өмнө хүмүүс хоорондын харилцаа хичнээн холдсон байгааг харуулжээ. Энэ мэтчлэн гэр бүлийн харилцаанд “цахим” гэх ойлголт орж ирсэн нь нэг талаас эерэг зүйлсийг авчирч байгаа ч сөрөг үр дүнд ч хүргэж болохыг энэхүү дэд бүлэгт бичлээ.


### 3.5 Бүлгийн дүгнэлт

Олон жилийн турш нүүдлийн мал аж ахуй эрхэлж байсан монголчууд ч техник, технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхаж, бодлогын баримт бичигтээ “Цахим үндэстэн” болох зорилгыг тавьсан байна. Энэ нь монголчуудын хүн-хүн, хүн-байгалийн харилцаанд өөрчлөлт оруулж, “хүн-технологи” гэх шинэ харилцааг бий болгожээ. Хүн-технологийн харилцаа гарч ирснээр монголчуудын хүн-хүн хоорондын харилцааны үндсэн дүрэм болох хүндлэл, бэлгэдэлийн утганд өөрчлөлт орж байна. Жишээлбэл, цахим орчинд өөрийн нас, хүйсээ мэдэгдүүлэхгүйгээр өөрөөсөө ах хүнтэй муудах, хэрэлдэх гэх мэт авир гаргаж буй нь “хүн ахаа, дээл захаа” гэх олон мянган жилийн турш ам дамжин уламжлагдан ирсэн зүйр цэцэн үг, харилцааны онцлог, хэм хэмжээ үгүй болж байгаа юм. Гэсэн хэдий ч зарим талаараа улс орон цахимжих нь хүмүүсийг гэрээсээ мод тарих, сүм хийдэд ном уншуулах зэрэг боломжийг нээж хүн-байгаль болоод шашин шүтлэгийн асуудлыг зохицуулагч, холбогч нь болжээ. Мөн хүмүүс өөрсдийн дуртай газраасаа олон улсад болж буй сургалт, семинар, ахисан шатны сургуулийн хичээл, семинаруудыг хүртэл хүлээн авч буй нь цахимжих үйл явцын давуу тал болж байна. Гэсэн хэдий ч энэ нь багш-оюутан, багш-суралцагч, багш-шавь гэх монголчуудын харилцааны ёс заншлыг бага багаар алга болгож буй сөрөг талтай байна. Интернет хэрэглэгч секунд тутамд асар хурдацтайгаар нэмэгдэж буй өнөө цагт хүн-технологийн харилцаа улам гүнзгийрч, хүн-хүн, хүн-байгалийн харилцаа багасах хандлагатай байгаа нь хээрийн судалгаа болон бусад эрдэмтэн, судлаачдын өгүүлэл, нэг сэдэвт өгүүллээс харагдсан.

## ДУГНЭЛТ

### БАЙГАЛЬ-ХҮН-ТЕХНОЛОГИ

Хэдхэн арван жилийн өмнө монгол нүүдэлчдийн харилцаа уламжлалт хүн-байгаль, хүн-хүн хоорондын харилцаан дээр тогтож байсан бол өнөөдөр технологи гэх шинэ ухагдахуун гарч ирсэн байна. Энэхүү судалгааны ажлын нэгдүгээр бүлгээр хүн-байгалийн харилцааг схемчлэн үзүүлсэнтэй адил хүн-хүн, хүн-байгалийн харилцаанд шинээр гарч ирсэн технологи гэх ухагдахуун хэрхэн хүн-хүн, хүн-байгалийн харилцааг зохицуулж буйг дараах байдлаар схемчлэн үзүүллээ. Нэг ёсондоо, хүмүүсийн өдөр тутамдаа хийдэг байсан зан үйл, өргөл, барьц зэрэг нь тухайн зан үйлтэй холбоотой аппликейшнээр солигдож, интернетийн орчинд хийгддэг болжээ. Харин хүн-хүн хоорондын албан болон хувийн харилцаа нь сошиал медиагаар дамжиж, интернет орчинд өрнөдөг болсон байна. Өөрөөр хэлбэл, эдүгээгийн хүн-байгаль, хүн-хүн хоорондын харилцаа интернет гэх хийсвэр ертөнцөд өрнөдөг болж өөрчлөгдсөн болохыг хээрийн судалгаа, анхдагч болон хоёрдогч эх сурвалжин дээр тулгуурлан мэдэж болохоор байна. Хэдийн хүмүүсийн байгаль, хүнтэй харилцах харилцаанд өөрчлөлт орж байгаа ч уламжлалт зан заншил, хэм хэмжээ, онцлог зэргийг хадгалсан байгаа нь зарим хүн-байгаль, хүн-хүн хоорондын харилцааны жишээн дээр ч гарч ирж байсан юм. Монголын Засгийн газар “Цахим үндэстэн” гэх зорилгын хүрээнд хэрэгжүүлж буй бодлогоо монголчуудын уламжлалт хүн-байгаль, хүн-хүн хоорондын харилцааны үндсэн дээр монгол онцлогыг хадгалсан цахим үндэстэн болох тал дээр ажиллах нь өөрсдийн өвөрмөц байдлаа хадгалж авч үлдэх, бусдаас онцгойрох ондоошлоо тодорхойлох боломжийг бүрдүүлж өгөх юм.



## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Хүн-хүн, хүн-байгаль, хүн-технологийн харилцааг онолын өнцгөөс баяжуулж, судалгааны эргэлтэд оруулах
- Хүн-хүн, хүн-байгалийн харилцаанд технологи хэрхэн нөлөөлж буйг хээрийн судалгаа, онолоор баяжуулах
- Хүн-технологийн харилцааны эерэг талуудыг судалж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах

## НОМ ЗҮЙ

- Х.Нямбуу. (1970). *Хамгийн эрхэм ёсон*. Улаанбаатар: БНМАУ Ардын Боловсрол Яамны хэвлэл.
- Х.Сампилдэндэв. (2004). *Монгол зан үйл, аман зохиолын харьцуулсан судалгаа*. Улаанбаатар: Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн.
- Я.Цэвэл. (2021). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Т.Хулан. (2022, 8 2). *iToim*. Retrieved 8 2, 2022, from <http://itoim.mn/article/0P3RI/34170>
- Buken, N. O. (2004, March). *Placebo and the placebo effect*. Retrieved September 4, 2022, from Researchgate: [https://www.researchgate.net/publication/291664612\\_Placebo\\_and\\_the\\_placebo\\_effect](https://www.researchgate.net/publication/291664612_Placebo_and_the_placebo_effect)
- Yuichi Ogino, H. N. (2006). *Inner Experience of Pain: Imagination of Pain While Viewing Images Showing Painful Events Forms Subjective Pain Representation in Human Brain*. Gunma: Gunma University.
- Д.Энхболд. (2014, June 4). "Хонхны дуу" бол шинээр сэтгэгчдийн, шинэчлэл өөрчлөлтийн л дуу. (assa.mn, Interviewer)
- Kohl-Garrity, F. E. (2019). *The Weight of Respect*. Michigan.
- Ц.Дамдинсүрэн. (1940). *Монголын нууц товчоо*. Улаанбаатар.
- З.Дэнсмаа. (2009). *Өрнө Дорнын соёл дахь эерүү найрсуу зан харилцааг харьцуулах нь /Монгол, Англи Хятадын жишээн дээр/*. Улаанбаатар.
- Mondal, P. (2018, December 31). *Communication: Definition, Principles, Elements and Means of Communication*. Retrieved from Your Article Library: <https://www.yourarticlelibrary.com/sociology/communication-definition-principles-elements-and-means-of-communication/36557>
- Coman, M. (2006, January). *Media Anthropology: An Overview*. Bucharest, Romania.
- Seeman, D. (1997). *Anthropology and the religious student: Between love and respect. Bekhol Derakhekha Daehu*, 5-24.



Э.Болорхажид. (2020, 01 20). *Цагаан сар ба Төсөв. Нэг өрх 1.5 сая төгрөгийн зардал гаргадаг*. Retrieved from news.zindaa.mn: <https://news.zindaa.mn/21aj>

Өдрийн сонин. (2022, 6 8). *Монгол Улсад хамгийн эрэлттэй байгаа 39 мэргэжил*. Retrieved from dnn.mn:

<https://dnn.mn/%D0%BC%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB-%D1%83%D0%BB%D1%81%D0%B0%D0%B4-%D1%85%D0%B0%D0%BC%D0%B3%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%8D%D1%80%D1%8D%D0%BB%D1%82%D1%82%D1%8D%D0%B9-%D0%B1%D0%B0%D0%B9%D0%B3%D0%B0%D0%B0-39-%D0%BC%D1%8D%D1%80%D0%B3%D1%8D%D0%B6%D0%>

Bureau, T. U. (2022, 10 20). *2022 World Population by Country*. Retrieved from World Population Review: <https://worldpopulationreview.com/>

World, D. A. (2022, 10 20). *Digital Around The World*. Retrieved from Data Reportal: <https://datareportal.com/global-digital-overview>

Worldometer. (2022, 10 20). *World Population*. Retrieved from worldometer: <https://www.worldometers.info/>

Б.Энхболд. (2010). *Өрх, гэр бүл дэх харилцааны эрхэм ёсон хийгээд хориг /Монгол, германы жишээгээр/*. Retrieved from catalog.num.edu.mn: <https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-detail.pl?biblionumber=93097>

司馬遼太郎. (2008). *街道をゆく5 モンゴル紀行*. 東京: 朝日新聞出版.

Л.Хантөгс. (2004). *Монголчуудын цээрлэх ёсны соёл*. Retrieved from catalog.num.edu.mn: <https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-detail.pl?biblionumber=95083>

Humphrey, C. (1987). *The Host and the Guest: One Hundred Rules of Good Behaviour in Rural Mongolia*. Retrieved from Academia: [https://www.academia.edu/2487628/The\\_Host\\_and\\_the\\_Guest](https://www.academia.edu/2487628/The_Host_and_the_Guest)

Sneath, D. (2019). Everyday Hospitality in Mongolia. *L'Homme*, 67-88.

Atwood, C. (2000). Worshipping Grace: The Language of Loyalty in Qing Mongolia. *Project Muse*, 86-139.

- Humphrey, C., Mongush, M., & Telengid, B. (1993). Attitudes to nature in Mongolia and Tuva: a report. *Nomadic Peoples*, 51-61.
- Банзаров, Д. (1846). *Одон тэнгэрийг урих, тахиx судар*.
- Hockett, C. (1958). *A Course in Modern Linguistics*. New York: MacMillan Company.
- Birdwhistell, R. (1952). *Introduction to Kinesics: An Annotation System for Analysis of Body Motion and Gesture*. Washington DC: Department of State, Foreign Service Institute.
- Kant, I. (1785). *Groundwork of the Metaphysics of Morals*.
- Wawrytko, S. (1982). Confucius and Kant: The Ethics of Respect. *Philosophy East and West*, 237-257.
- К.Т., С. (2017). Elder Respect: Exploration of Ideals and Forms in East Asia. *Journal of Aging Studies*, 13-26.
- С.Дулам. (2000). *Монгол бэлгэдэл зүй. Дэд дэвтэр: Өнгөний бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх.
- B.Ortner, S. (1973, October). *On Key Symbols*. Retrieved from JSTOR:  
<https://www.jstor.org/stable/674036>
- Ferre, F. (1995). *Philosophy of Technology*. Georgia: UGA Press.
- Д.Бум-Очир. (2012). *Нийгэм, соёлын хүн судлалын онолын үүд*. Улаанбаатар: Адмон.
- White, L. A. (2007). *The Evolution of Culture: The Development of Civilization to the Fall of Rome*. Abingdon, Oxfordshire: Routledge.
- Kohn, E. (n.d.). *How Forests Think*.
- Kohn, E. (2013). *How Forests Think: Toward an Anthropology Beyond the Human*. California: University of California Press.
- Appadurai, A. (1990). Disjuncture and Difference in the Global Cultural Economy. *SAGE*.
- С.Дулам. (2009). *Одон тэнгэрийг урих тахиx судар*. Улаанбаатар.
- Barnard, A. (2000). *History and Theory in Anthropology*. Cambridge: Cambridge University Press.

- Battsengel. (2018). *The Secret History of the Mongols*. Ulaanbaatar: Mongolia: Discover the Secret History of the Mongols Foundation.
- Raymond. (2010). *Mongolian Proverbs: A Window into Their World*. San Diego: Alethinos Books.
- Thrift, E. (2014). Pure Milk: Dairy production and the discourse of purity in Mongolia. *Asian Ethnicity*, 492-513.
- Ahearn, A. (2020). *Milk, Female Labor, and Human-Animal Relations in Contemporary Mongolia*. Retrieved from Researchgate:  
[https://www.researchgate.net/publication/343737353\\_Milk\\_Female\\_Labor\\_and\\_Human-Animal\\_Relations\\_in\\_Contemporary\\_Mongolia](https://www.researchgate.net/publication/343737353_Milk_Female_Labor_and_Human-Animal_Relations_in_Contemporary_Mongolia)
- Х.Сампилдэндэв. (1985). *Малчин ардын зан үйлийн уламжлал*.
- Ч.Заяасүрэн. (2021). *Монгол сацал мялаалгын үгийн дээжис*. Улаанбаатар: Хэл зохиолын хүрээлэн.
- Chong, C. (2019). *Through the lens of Pchum Ben. Sacred Moments: Reflections on Buddhist Rites and Christian Rituals*. New Delhi, India: Christian World Imprints.
- Descola, P. (2013). *Beyond nature and culture*. Chicago: Chicago Press.
- Fijn, N. (2011). Human-Animal Coexistence in Mongolia. *Royal Asiatic Society*, 274.
- Charlier, B. (2015). *Faces of the Wolf: Managing the Human, Non-human Boundary in Mongolia*. Boston: Brill Rodopi and Hotei Publishing.
- Stépanoff, C. (2017). Animal Autonomy and Intermittent Coexistences: North Asian Modes of Herding. *Chicago Journals*.
- У.Бямбаням. (2014). *Хишиг: Монголчуудын хишиг хүртэх ёс, "Нүгэл төөрүүлэх" зан үйл*. Улаанбаатар: Антоон мостаэрт.
- Humphrey, C. (2002). After-lives of the Mongolian Yurt: the archaeology of a Chinese tourist camp. *Material Culture*, 189-210.
- Charleux, I. (2021). Ovoo and the ritual remaking of religious, ecological, and historical politics in Inner Asia.

- Davaa-Ochir. (2008). *Oboo Worship. The Worship of Earth and Water Divinities in Mongolia.*
- Delaplace, G. (2021). *Being skillful. Wisely navigating an intensely heterogeneous cosmos in Mongolia. Open Edition.*
- Smith. (2015). *Treasure Underfoot and Far Away. Mining, Foreignness, and Friendship in Contemporary Mongolia.* Princeton: Princeton University.
- Г.Цэрэнханд. (2005). *Монголчууд: Угсаа-соёл, зан заншил.* Улаанбаатар: Адмон.
- Д.Бум-Очир. (2017). *Монгол бөөгийн зан үйл.* Улаанбаатар: МУИС пресс.
- Н.Бямбасүрэн. (2012). *Монгол, Хятад угсааны бэлэг барих ёсыг харьцуулах нь.*  
Retrieved from Номын сан, Монгол Улсын Их Сургууль:  
<https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-detail.pl?biblionumber=90602>
- Weber, M. (1978). *Economy and Society.* California: University of California Press.
- Simmel, G. (1905). *Die Probleme der Geschichtphilosophie.* German.
- Bourdieu, P. (2008). *Structures, Habitus, Practices.*
- Bum-Ochir. (2006). *Respect and Power without Resistance.* Cambridge: University of Cambridge.
- Rheingold, H. (1995). *The Virtual Community: Finding Connection in a Computerized World.* Addison Wesley Longman.
- 吉田純. (2000). *インターネット空間の社会学—情報ネットワーク社会と公共圏.* 東京: 世界思想社.
- Patterson, M., Lundmark, V., Kiesler, S., Mukopadhyay, T., & Scherlis, W. (1998). Internet Paradox: A Social Technology that Reduces Social Involvement and Psychological Well-being? *American Psychologist*, 1017-1031.
- Ellison, N. (2008). Social Network Sites: Definition, History, and Scholarship. *Computer-Mediated Communication*, 210-230.
- Patton. (1986). *Open Road.* Simon&Schuster.

Hampton, K. N. (2003). Neighboring in Netville: How the Internet Supports Community and Social Capital in a Wired Suburb. *City & Community*, 277-311.